

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-66
1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн Байнгын хороонд хүргүүлнэ/	6-47
2. Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод хүргүүлнэ, үргэлжлэл/	47-58
3. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн/	58-66

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
10 дугаар сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 55 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: П.Батчимэг;

Томилолттой: Л.Соронзонболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Бат-Эрдэнэ, М.Энхцэцэг;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Н.Батсүмбэрэл, М.Мандхай, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн Байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Л.Отгонтуяа, Р.Ричинбазар, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын менежер Б.Чанцалдулам, Б.Долгорсүрэн, Д.Энхдалай, И.Эрдэнэцэцэг, Э.Энхбаатар, В.Эрдэнэцогт, С.Нацагдорж, Гүйцэтгэлийн аудитын газрын менежер Ю.Энхтуяа, Д.Нямжаргал, Нийцлийн аудитын газрын менежер Э.Баттогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, Ж.Алтантуяа, ахлах мэргэжилтэн П.Энхманлай, мэргэжилтэн С.Гэлэгжунай, Г.Үлэмждэлгэр, Э.Цолмон, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, мөн яамны Геологийн бодлогын газрын дарга Х.Санчигдорж, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Амартүвшин, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, мөн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, Санхүүгийн хэлтсийн дарга

Т.Сумъяа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга А.Амгаланзаяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Энхбаатар, мөн яамны Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын дарга М.Ням-Очир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Уянга, Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хэлтсийн дарга Ү.Мөнхжаргал, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, мөн яамны Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Золбаяр, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Д.Батбаяр, Сүлжээний дэд бүтцийн хэлтсийн дарга Ч.Гүнсэнхорол, Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч П.Дэлгэрмаа, Төрийн захиргааны удирдлагын газрын Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн Салбарын нэгдсэн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан шинжээч Д.Мөнхсолонго, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга П.Батбаатар, Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч П.Жаргалсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Б.Найдалаа, Г.Лувсанжамц, С.Цэнгүүн, Ө.Шижир, О.Батнайрамдал, Х.Булгантуяа, Г.Очирбат, Э.Одбаяр, Ц.Баатархүү, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, мөн яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх хэлтсийн дарга Ү.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ө.Шижир, Б.Найдалаа, Г.Лувсанжамц, О.Батнайрамдал, Ч.Лодойсамбуу, Г.Очирбат, С.Эрдэнэбат, Ж.Ганбаатар, Р.Сэддорж нар үг хэлэв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн

даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн төслийн хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 12 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодод хүргүүлнэ, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбаян, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Я.Гантөмөр, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Баянмөнх, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, мөн хэлтсийн мэргэжилтэн У.Марал, Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийн хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Г.Очирбат, Б.Уянга, Б.Тулга, Б.Заяабал, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбаян, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	15
Татгалзсан:	8
Бүгд:	23

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, мөн банкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал Г.Борхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Х.Шижирмөнх нар байлцав.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Пунсалмаа, Э.Батшугар нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Р.Сэддорж “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 57 минут үргэлжилж, 32 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 71.8 хувийн ирцтэйгээр 13 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 07-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
09 цаг 55 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Ренчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Хүрэлбаатарын Булгантуяа, Шинэбаярын Бямбасүрэн, Жамбалын Ганбаатар, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Бадрахын Найдалаа, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Ренчинбямбын Сэддорж, Буяагийн Тулга, Агваанлуvsангийн Ундраа, Саруулсайханы Цэнгүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүдээс чөлөө авсан гишүүд байгаа. Энийг ажлын албаныхан бүртгэж авсан. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56,3 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газраас 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

2.Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төсөл /Засгийн газраас 9 дүгээр сарын 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ирүүлсэн зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. Үргэлжлэл/

3.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2025 оны 9 сарын 30-ны өдөр ирүүлсэн./

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 1.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Байнгын хорооны хуралдаанд Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ричинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Үндэсний аудитын газар Цэнджав Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, Баттуяа Нийцлийн аудитын газрын дарга, Чанцалдулам Санхүүгийн аудитын газрын менежер, Долгорсүрэн Санхүүгийн аудитын газрын менежер, Энхдалай Санхүүгийн аудитын газрын менежер, Эрдэнэцэцэг Санхүүгийн аудитын газрын менежер, Энхбаатар Санхүүгийн аудитын газрын менежер, Эрдэнэцогт Санхүүгийн аудитын газрын менежер, Нацагдорж Санхүүгийн аудитын газрын менежер, Энхтуяа Санхүүгийн аудитын газрын менежер, Нямжаргал Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор, Баттогтох Нийцлийн аудитын газрын менежер, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Батхүү Төрийн нарийн бичгийн дарга, Сүрэнхорол Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Анар Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Баясгалан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Мөнхтөр Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Эрдэнэтуяа Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Гэрэлбат Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Шадар сайдын ажлын албанаас Батбаатар Стандарт хэмжилзүйн газрын дарга, Эрдэнэбаяр Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал, Ариунбуян Онцгой байдлын газрын дарга, Хошууч генерал, Сүхбаатар Шадар сайдын ажлын албаны референт, Онгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сангийн яам Ганбат Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Тэлмүүн Татварын бодлогын газрын дарга, Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батмөнх Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Гантогтох Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Уранцэцэг Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Дашпүрэв Төрийн нарийн бичгийн дарга, Санчигдорж Геологийн бодлогын газрын дарга, Амартүвшин Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Зам тээврийн яам Насантогтох Төрийн нарийн бичгийн дарга, Сугармаа Авто замын бодлогын зохицуулалтын газрын дарга, Сумъяа Санхүүгийн хэлтсийн дарга, Дэлгэрсайхан сайдыг дуудаарай. Ирнэ гэж байна лээ. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Даваацэрэн Төрийн нарийн бичгийн даргын үүрэг үүргийг түр орлон гүйцэтгэгч, Отгонбат Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Жаргалсайхан Биеийн тамир спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батдорж Залуучуудын хөгжлийг хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батчимэг Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Амгаланзаяа Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Энхбаатар Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Ням-Очир Нийтийн аж ахуйн бодлогын зохицуулалтын газрын дарга, Уянга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Одбаяр Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Найрамдал Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Баттөгс сайдын зөвлөх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын

газрын дарга, Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам Золбаяр Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батбаатар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга, Баттулга “Үндэсний дата төв” УТҮГ-ын захирал Мягмарнаран “И-Монгол Академи” УТҮГ-ын захирал, Батбаяр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч, Гүнсэнхорол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Сүлжээ, дэд бүтцийн хэлтсийн дарга, Дэлгэрмаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Хөрөнгө оруулалт, санхүүгийн хэлтсийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч, Мөнхсолонго Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хөрөнгө оруулалтын санхүүгийн салбарын нэгдсэн төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг хариуцсан шинжээч, Эрчим хүчний яам Жаргалсайхан Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Цогтгэрэл Албаны дарга, Үндэсний статистикийн хороо Лхамсүрэн Дэд дарга, Лхагваа Тамгын газрын дарга, Үндэсний статистикийн хорооны дарга Батдаваа ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлж болно гэж заасан.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдийн талаар асуулттай гишүүд нэрсээ өгье. Цэндийн Баатархүү гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар.

Ж.Ганбаатар: Ж.Ганбаатар тээ. Олон Ганбаатар байгаа. 2 асуулт асууя.

1 дүгээрт биржтэй холбоотой 1 асуулт асуугаадахъя. Биржээс хүн байгаа биз дээ. Эсвэл Эрдэнэс Тавантолгойгоос. Байхгүй бол тэгээд Сангийн яам хариулаарай. 3 сарын өмнө биржийн асуудлаар биржээр бараг нүүрсээ зарах нь буруу байна. Энэ шийдвэр их буруу болжээ л гээд байсан. Өчигдөр тэгээд тэр Уул уурхайн сайдын мэдэгдлийг сонсоход бол бирж их мундаг ажиллаж байгаа юм байна гэж ойлгосон. Бас нэг гишүүн гарч ирээд мэдэгдэл хийсэн чинь бирж ажиллахгүй байгаа гэсэн. Алинд нь үнэмших вэ. Ямар мэдээлэл нь зөв бэ. Тодорхой хариулна шүү. Тоон мэдээлэл хэрэггүй шүү. Аль мэдээлэл нь үнэн бэ. Алинд нь бид итгэх вэ. Сангийн яам хариулаарай. Ганбат дарга байна уу. Өглөө явж байсан шүү дээ Ганбат дарга байна уу. Ганбатаас л хариулт сонсмоор байх юм. Хөрөнгийн биржээс хүн байгаа юм уу, байхгүй юм уу. Энэ 2 мэдээллийг сонсмоор байх юм. Өчигдөр Уул уурхайн сайдын мэдээллийг сонсоход бол биржээр нүүрс зарсан. Тэгээд эдийн засгийн алдагдал арилсан. Монгол Улс мөнгөтэй болсон. Өмнө нь бол биржээр огт нүүрс зарахгүй, биржийг будилуулж байсан юм байна лээ, хүчээр будилуулсан байна лээ өмнөх Засгийн газар гэж хэлсэн. Тэгээд тухайн үед бол биржээр юмаа зарахгүй байна гэхээр энд сууж байгаа олон нөхөд намайг их олон үгээр доромжилсон шүү. Одоо тэгээд үнэнд гүйцэгдэж байх шиг байна. Тэгээд алинд нь итгэх вэ. Сангийн яам хариулаарай. Сайд нь байгаа юм уу. Эдийн засгийн байнгын хороогоор төсвийн асуудал хэлэлцэж байхад Сангийн сайд байдаггүй юм уу. Үгүй ээ, тэр ямар хамаатай юм. Энэ чинь Их Хурлын ажил 1 номерын ажил биш юм уу. Ер нь тийм юм, ийм юм гэдэг их тайлбартай болсон байх юм. Энэ Сангийн сайд чинь биржийг явуулахгүй гээд зөндөө, 2 удаагийн төсвийн тодотголоор баахан юм яриа биз дээ. Та нар бүгдээрээ нийлээд. Одоо яг биржийн үйл ажиллагаа чинь

яг яаж явж байгаа юм. Энэ үнэхээр засгийг чинь аварчихсан юм уу, үгүй юу. Монголбанкыг мөнгөтэй болгосон юм уу, үгүй юу. Энэ 2 хүний мэдэгдлийн алинд нь итгэх юм. Бид нарт зөв тоон мэдээлэл өгөхгүй байна шүү дээ. Энэ минут бол миний 1 сэдэвт л хүрэх юм байна л даа. Эхлээд хариултаа авчхаад тодотгоё .

Р.Сэддорж: Хариулт Сангийн яам. Сангийн сайдыг дуудаарай. Төрийн нарийн бичгийн даргыг. Сангийн яам, дараа нь Аж үйлдвэрийн яам. 5 номер дээр суучих Сангийн яам. Санжаадорж дарга эхлээд хариулаад явж бай. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд Учрал ирсэн.

М.Санжаадорж: Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Уучлаарай гишүүн ээ, энэ үйлдвэрчний танилцуулга дээр Төрийн нарийн бичгийн дарга хэлэлцүүлэгт нь ороод, тайзан дээр нь гараад суучихсан. Сангийн сайд болохоор төсөл танилцуулж байна. Яг одоо ороод ирнэ. Хажуу талын зааланд байгаа.

Биржтэй холбоотой мэдээлэл бол 9 дүгээр сарын байдлаар нүүрсний хувьд 12,5 сая тонн нүүрс борлуулсан. 4,1 сая тонн төмрийн хүдэр борлуулсан. 35 мянган тонн зэсийн баяжмал, тэгээд 43 мянган тонн жоншны хүдрийн баяжмал арилжаалсан гэсэн ийм мэдээ биржээс байна.

Р.Сэддорж: Аж үйлдвэр Эрдэс баялгийн яам гараа өргөөрэй. Хаана байна. 5 номер дээр суучих.

Б.Дашпүрэв: Сайн байна уу. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. Биржийн арилжаа нийт Монгол Улсын хэмжээнд 8 сарын 20-ны байдлаар 7,5 сая тонн бүтээгдэхүүн экспортолж байсан бол энэ нь дөнгөж 1 сар 10 хоногийн хугацаанд 5 сая тонн бүтээгдэхүүн экспортолсон ийм амжилттай яваа. Идэвхжилттэй байгаа.

Р.Сэддорж: Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууна.

Ж.Ганбаатар: Энэ Сангийн яам бүгдээрээ хуучин, бараг 3 Засгийн газар, 5 Засгийн газар дамжаад ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд 1, 2 сарын өмнө өөр хариулдаг. 2 сарын өмнө шал өөр юм ярьдаг. Одоо бирж болж л байна шүү дээ тэгээд ажиллаад. Болохгүй гээд байсан хүмүүс яагаад төрөл нь арилчхаж вэ. Сайд нь ч хэвээрээ. Төрийн нарийн, тэр саяын 5 номер дээр суудаг залуу хүртэл хэвээрээ. Тэгээд ярьж байгаа зүйл нь тэс өөр. Шадар сайд аа, ярьж байгаа зүйл чинь тэс өөр. Тэгээд хариулахдаа дандаа хүн доромжилно. Хэвлэлээр хүн гүтгэнэ. Тэгсэн мөртөө өнөөдөр биржийн асуудал мундаг байна гээд. Яагаад өмнө нь хийж болохгүй байсан юм. Бараг би байгаагүй бол Биржийн хуульд чинь өөрчлөлт орох гэж байсан шүү дээ Учрал сайд аа. Та мэдэж байгаа шүү дээ. Тэгсэн бол бүр балрах байсан байна шүү дээ. 1 минут сунгачихъя.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж байна. 1 минут.

Ж.Ганбаатар: Би бас саяхан 1 юм сонслоо Учрал сайд аа. Энэ чинь биржээр нүүрсээ бүгдийг нь зарах ёстой болохоос биш 25 хувиа зарсан бол биржийн үнээр АМНАТ төлнө гэнэ үү. Наадах чинь Монгол Улсын хууль зөрчиж, Засгийн газар тогтоол гаргаж байна шүү дээ. Энэ чинь Биржийн хуульдаа бүгдээрээ Монгол Улс нүүрсээ бүгдийг нь биржээр зарах ёстой байтал 25 хувиа зарах юм бол юу гэнэ үү. Би эсвэл дутуу ойлгосон уу. Сүүлийн үед олон мэдэгдэл яваад байхаар юмыг

ойлгохгүй байна л даа. Нэг нь нэг юм яриад, нөгөөдөх нь өөр юм яриад. Тэгээд өгч байгаа мэдээлэлдээ итгэхгүй байна би. Энэ ирж байгаа мэдээллүүд чинь ерөөсөө ямар ч цензур алга. Одоо энэ хариултаа өөрөө сонсож байгаа биз дээ Эдийн засаг, хөгжлийн сайд. Энэ хариулт би юу асуусан, энэ хүмүүс юу хариулж байна. Тэгээд би ийм хариулт авчхаад, тэгээд/минут дуусав/

Р.Сэддорж: Анар хариулъя. Эрдэнэс Тавантолгой дахь бүрэн эрхт төлөөлөгчийн багийн Эдийн засаг, хөгжлийн яамнаас орсон гишүүн байгаа. Анар хаа байна. Анар тийшээ 5 номер луу. Батнайрамдал гишүүний нэр нэмээрэй.

Б.Анар: Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Анар. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2025 оны эхний хагас жилд 85 удаагийн нээлттэй цахим арилжаа зохион байгуулснаас 20 удаагийн арилжаагаар нийтдээ 1,3 сая тонн нүүрс арилжаалагдаад байсан. Эрдэнэс Тавантолгой дээр биржийн арилжаа зохион байгуулалтыг бол сайжруулснаар онцгой дэглэм тогтоосон сүүлийн 2 сар хагасын хугацаанд бол уул уурхайн биржээр нийт 75 удаагийн арилжаагаар 327 сая ам.долларын үнэлгээ бүхий 5,8 сая тонн нүүрсийг амжилттай арилжаалсан. Бусад биржийн арилжаагаар хийгдсэн бусад бүтээгдэхүүнүүдийг бол түрүүн мэдээллийг нь өгсөн байх. 25 хувьтай холбоотой Засгийн газрын тогтоолыг Уул уурхайн яамнаас хариулсан нь зөв байх.

Р.Сэддорж: Уул уурхайн яамнаас хэн хариулах юм. 5 номер

Б.Дашпүрэв: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Дашпүрэв Төрийн нарийн бичгийн дарга. Монгол Улсын ашигт малтмалын тухай хуульд төрийн компаниудыг 100 хувь биржээр арилжих ийм хуулийн зохицуулалттай. Харин хувийн хэвслүүд, хувийн аж ахуйн нэгжүүд биржээр заавал арилжих ийм зохицуулалт байхгүй. Тэгэхээр бид бүхэн бол энэ биржийн арилжааг идэвхжүүлэх хүрээндээ ер нь бол үндсэн 25 хувьдаа хүрдэггүй. Тэгэхээр 25 хувиа биржээр арилжих юм. Үлдсэн бүтээгдэхүүнд нь АМНАТ-ыг биржээр тооцно гэдэг зохицуулалт маань өөрөө энэ бусад төрийн болон хувийн аж ахуйн нэгжийн бирж рүү орох энэ идэвхжилийг нэмэгдүүлнэ гэдэг ийм тооцоо судалгаа байгаа.

Р.Сэддорж: Хариултаа гүйцээчих 5 номер 1 минут.

Б.Дашпүрэв: Гэхдээ нөгөө урт хугацаатай, том гэрээнүүд байгаа учраас ер нь биржийн арилжаа 25 хувьдаа хүрэхгүй байгаа. Тэгэхээр 25 хувьд хүрэх гэдэг нь бол биржийн арилжааг идэвхжүүлэх зорилготой. Мөн хувийн ... хууль дээр байгаа.

Р.Сэддорж: Энийгээ яг тодорхой болгоод, дараагийн Байнгын хорооны хурал дээр ч юм уу, энэ Байнгын хорооны ажлын албаныхан Монголын Хөрөнгийн биржээс энэ биржийн худалдаа яаж явж байгаа, ялангуяа энэ гишүүдийн асуугаад байгаа энэ биржийн арилжаа яаж явагдаж байгааг сонсох хэрэгтэй юм байна. Одоо Бадрахын Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Бид нар төсөв хэлэлцэхээр жилийн жилд зүгээр боочихсон, хуваарилчихсан төсөв дээр тойрч жоохон маргалдаж байгаад л тэр чинээгээрээ батлаад байна л даа. Зүгээр асуулт ийм байна. Хэдхэн товчхон асуулт асууя.

Яг энэ хөгжлийн бодлого гэдэг юм уу, ирэх онд, ирэх хэдэн жил ямар төслийг нь 1 дүгээрт, 2 дугаарт, 3 дугаарт, 10 дугаарт эрэмбэлж байгаа хөгжлийн бодлогыг

барьж байгаа тэрнийхээ дагуу төсвийг хуваарилж байгаа нь аль яам бэ. Хэн бэ. Эдийн засаг, хөгжлийн яам уу. Сангийн яам уу. 1 асуулт.

2 дугаарт гадаа багш нар суулт хийж байна. Ахмадууд тэтгэврээ нэмье гэж байна. Эмч, багш нар дуугарахгүй байгаа боловч яг адилхан. Тэгээд жилийн жилд намар төсөв батлах үеэр төсвөөр шийдчих юм болов уу гэж горьддог юм уу, яадаг юм. Ямар ч байсан жагсаж, баахан хүсэлт гаргаж байгаа юм. Яг энэ дээр одоогийн Монгол Улсын Засгийн газар багш нарын цалинг нэмэх гээд тодорхой ярьчихъя. Энэ дээр яг ямар бодлого бариад, хэзээд нь яаж нэмээд, нэмэх бодлого байгаа юм уу, байхгүй юм уу. Ер нь багш нарын хөгжлийг яаж харж байгаа талаар тов тодорхой Засгийн газрын байр суурь хэрэгтэй байна.

2-т нь тэр цалинтай холбоотой олон хүсэлт ирж байгаа. Тэгэхээр яг анх салбарынх нь яамнаас хэдэн төгрөгийн төсөв тавьж ирээд, санал ирээд, хэдийг нь хаана хассан талаар мэдээлэл өгөөч. Тиймэрхүү яриа их байгаад байгаа. Тэгээд энэ дээр тодорхой яг тоо, дүнг нь хэлж өгөөч ээ. Үндэслэл нь яг юу юм. Энэ хэдэн асуултад хариулт авчхаад, тэгээд тодруулж асууя.

Р.Сэддорж: Учрал сайд.

Н.Учрал: Найдалаа гишүүний асуултад хариулъя. Төслүүдийг эрэмбэлэх ажил бол хийгдэж байгаа. Одоо 5 жилийн үндсэн чиглэлийг сая ШУА-ийн Их чуулганаар бас танилцууллаа. Гол саналуудыг тусгаад ажиллаж байна. 10 дугаар сарын 15-ны өдөр Засгийн газарт танилцуулаад, Их Хуралд 10 дугаар сарын 31-ний өмнө өргөн мэдүүлнэ. Үүнийг дагалдуулаад улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг өргөн барих ёстой. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр бол 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвтэй төслүүд хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтаж байгаа гэсэн үг. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт бол 30 тэрбумаас дээш төслүүдээ хамт өргөн мэдүүлээд, түүнээс өмнө бол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төслүүдийг төсөвт тусгах, санхүүжилтийг тодорхой болгох, эрэмбэлэх ажлуудыг хийх ажлаас бол шинэ Засгийн газар байгуулагдаад бол ажлаа эхэлсэн. Энэ хүрээндээ Засгийн газрын 14 мега төсөл 4 жилийн хөтөлбөрт орсон байсан төслүүдийг бол эрэмбэлсэн. Мөн яам болгон дээр байсан 149 төсөл байсан. Энэ 149 төслийг бид нарын 4 бүлэг, 14 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн. Энэ шалгуур үзүүлэлтийг нь Тэргүүн Шадар сайдын тушаалаар баталдаг. Энэ төслүүдийг эрэмбэлэхдээ бол 4 бүлэг нь макро эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, төслийн бэлэн байдлын үнэлгээ, санхүүжилтийн эх үүсвэрийн үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ буюу социал импакт гээд үнэлгээг бол хооронд нь яг тэр 1-5 оноогоор үнэлдэг аргачлалын дагуу үнэлээд 149 төсөл бол эрэмбэд орсон гэсэн үг. Ингээд бид сая төсөв барихдаа улсын жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэхийг хянахаар 50 төсөл нь улсын төсвөөс санхүүжүүлэх ямар нэгэн боломж байхгүй.

Тийм учраас нэгэнт батлагдсан жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ёстой гэдэг утгаараа бол төсөвт дагуулаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг хамт өргөн мэдүүлсэн. Ингээд энэ 50 төслийг бол төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулна гэж зорьж байгаа. Энэ төслүүд дотор бараг 50 орчим хувь нь нийтийн үйлчилгээний, дээрээс нь дэд бүтцийн гээд аймаг, орон нутгийн түвшинд хийж болох төслүүд байгаа юм. Тэгэхээр энэ утгаараа бол үе шатуудыг нь бууруулах шаардлагуудыг нь багасгах нутгийн өөрөө удирдах байгууллага тус төслийг хэрэгжүүлэхдээ өөрөө удирдах байгууллага руу оруулаад батлагдчих юм бол заавал Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яам руу явуулаад, төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалтад оруулдаг. 3 удаа Сангийн яамнаас зөвшөөрөл

авдаг, тэгээд багадаа 1 жил 3 сар орчим болдог асуудлуудыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиар өөрчилсөн. Энэ хүрээндээ улсын төсвөөс татаас авдаггүй аймгууд гэхээсээ илүү 21 аймаг, нийслэл дээр аль аль нь хялбаршуулсан журмаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөө хэрэгжүүлье гэдэг энэ боломжийг олгосон. Энэ хүрээндээ бол төслүүд хэрэгжих бололцоо бүрдэж байгаа гэсэн үг.

Төслүүдийг аль нэгийг нь зогсоох биш бид нар нөгөө эрэмбэлэх ажлуудыг л хийсэн. Тэгэхээр 149 төсөл эрэмбэлэгдсэн. 14 төсөл бол эрэмбэлэгдсэн. Одоо хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дагалдуулаад оруулж ирэх гэж байгаа гэсэн үг. Тэгээд 5 жилийн үндсэн чиглэлд бол яг энэ багшийн, эмчийн, нийгмийн салбар тэр дундаа хүний хөгжил гэсэн тухайлсан бүлэг авч үзээд, үүн дээр бол нөгөө Ки Пи айуудыг маш тодорхой болгож байгаа. Тийм учраас нөгөө Эдийн засаг, хөгжлийн яам дээр гүйцэтгэлийг үнэлээд, хянадаг, төлөвлөөд төсөвлөөд .../минут дуусав/

Р.Сэддорж: Учрал сайд 1 минут.

Н.Учрал: Тэр төлөвлөөд төсөвлөөд хянадаг чиг үүрэг нь өөрөө Эдийн засаг, хөгжлийн яам дээр ирсэн учраас бид нар 5 жилийн чиглэлийг боловсруулахдаа нэлээд сайн ажиллалаа. Энэ дээр бол нөгөө индикаторуудыг их тодорхой болгосон. Дандаа индексээр хэмжинэ. Тийм учраас эргээд Багшийн хөгжлийн хуулийг тухайн үед миний бас санаачилсан хууль. Тэгээд энэ хууль дээр бол ажлын гүйцэтгэлийн үнэлгээ буюу гүйцэтгэлд суурилсан цалингийн системийг бий болгоно гэж хуульчилсан мөртөө түүнээс хойш өөрөө боловсролын асуудал эрхэлж байгаа төрийн захиргааны төв байгууллага ямар индикаторуудаар хэмжих юм, гүйцэтгэлийг хэрхэн үнэлэх вэ гэдэг механизм тодорхой болгоогүйгээс болоод эрүүл мэндийн салбар ч гэсэн боловсролын салбар ч гүйцэтгэлийн үнэлгээ огт хэрэгжиж чадахгүй байна. Тийм учраас 5 жилийн чиглэлээ жилийн төлөвлөгөөгөө эргээд хянадаг механизмаа бол энэ удаа хэмжигдэхүйц болгож өгч байгаа. Тийм учраас бол багш боловсрол энэ аль салбарт бол гүйцэтгэлийн шинэ .../минут дуусав/

Р.Сэддорж: Зам, тээврийн сайд Дэлгэрсайхан хүрэлцэн ирсэн байна. 5 номер Сангийн яам.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төсвийн нийт хүрээ буюу төрийн зарцуулж болох нийт зарлагын дээд хэмжээг Улсын Их Хурлаас 6 сарын 1-ний дотор баталдаг хуультай байгаа. Энэ баталсан нийт хүрээ дотор багтаагаад, нийтдээ 58 төсвийн ерөнхийлөн захирагчийн зардлыг хувааж Засгийн газар бол 7 сарын 1-ний дотор баталдаг. Өөрөөр хэлбэл орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагч байгаа. 21 аймаг, дээр нь нийслэл. Мөн Засгийн газрын харьяа 19 төсвийн ерөнхийлөн захирагч байгаа. Мөн Улсын Их Хуралд шууд тайлагнадаг 17 төсвийн ерөнхийлөн захирагч байгаа. Ингээд хязгаартаа багтаагаад, саналаа 7 сарын 25-нд төсвийн ерөнхийлөн захирагч нар ирүүлэх үүрэгтэй. Тэрнээс биш юу гэдэг юм зарим төсвийн ерөнхийлөн захирагч нарыг хязгаараасаа хэтрүүлж саналаа өгчхөөд, энэ саналаа бид нар өгчихсөн Сангийн яам нэмээгүй гэдэг тийм асуудал байдаггүй. Бид бол зөвхөн хязгаарт нь багтаасан саналыг авдаг.

Р.Сэддорж: Сангийн яам гүйцэтгэж хариулъя. 1 минут. 5 номер.

М.Санжаадорж: Тэгэхээр нийт төсвийн тэр хязгаартаа багтаасан тэр ерөнхийлөн захирагчдаа хуваасан 58 төсвийн ерөнхийлөн захирагчдаа хуваасан

санал дотроо явдаг. Энэ жилийн хувьд бол нийт 58 төсвийн ерөнхийлөн захирагчаас зөвхөн 2 төсвийн ерөнхийлөн захирагч бол батлагдсан төсөвтөө багтаасан саналыг эхэлж өгсөн. Бусад нь тэрнээсээ хэтрүүлчихсэн байсан. Тэгэхээр Сангийн яам энэ төсвийг эрэмбэлж болохгүй. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрөөр хэлбэл нийт төсвийн багцдаа багтаагаад ямар ажлыг хийх вэ гэдгийгээ ирэх жил ямар үндсэн салбарын зорилгоо ямар үр дүнд хүргэх вэ гэдэг зорилгодоо нийцүүлж төсвөө бол хуваарилах ёстой. Цалиндаа хэдэн төгрөг, бусад зардалдаа хэдэн төгрөг гэдэг байдлаар. Тэгээд тийм байдлаар орж ирж байгаа тэр төсөв дээр бид нар боловсруулалт хийж ажилладаг. Тэрнээс биш юу гэдэг юм хэтрүүлж саналаа өгчхөөд ингэж байгаа зүйлүүд дээр бол Сангийн сайдын гарын үсэгтэй бичгээр буцаасан. Энэ жилийн хувьд.

Р.Сэддорж: Найдалаа гишүүн тодруулж асууя.

Б.Найдалаа: Яг иймэрхүү байдлаар техник чанартай юм ярихаар бид нар ямар ч үр дүн байхгүй л дээ. Боочихсон төсөв дээр юу ярих вэ дээ. Гол нь бодлогын асуудал. Яг энэ янзаараа бол Монгол Улс багш нарын цалинг нэмж чадахгүй. Чадахгүй болохоор 10, 20 жил явсаар байгаад хуримтлуулчхаж байгаа байхгүй юу. Эмч нарынх ч адилхан. Төрийн албан хаагч ч адилхан. Яагаад гэвэл бодлого байхгүй. Бодол бол байна. Нэмнэ ээ, нэмэх бодол байгаа. Хөөрхий гээд. Бодлого байхгүй. Тэгээд төсөл ярихаараа бид нар дандаа зам ярьж байгаа биз дээ. Дэд бүтэц, мянганы зам гээд мянгуужингийн үлгэр гэдэг чинь үнэн шүү дээ. Зам барьж чадахгүйдээ биш, тэрийг барьснаар хөгжил ирэхгүй, харин хүний хөгжил ирснээр зам нь аяндаа очно. Тэгэхээр багш нарын цалин дээр жишээлбэл багш нарын хөгжил гээд ярих юм бол тэр замтай харьцуулаад, эрэмбэлээд, тэгээд 1 ийм эрээвэр хураавар, эрэмбэлэх тухай юм яримааргүй байна. Зүгээр үнэхээр чухал гэж үзэж байгаа бол тэр дээрээ ...1 минутаа нэмчих үү.

Р.Сэддорж: Энэ хариулт хангалтгүй гэж үзэж байна. 1 минут нэмье.

Б.Найдалаа: Хариулт хангалтгүй, хариулт угаасаа байх ч боломжгүй юм байна. Үнэхээр багш нарын цалинг нэмье гэж байгаа бол үнэлэмжийг нь өсгөө гэж байгаа бол бодлого хэрэгтэй. Бодлого гэж байгаа нь зам барьчхад, дараа нь тэгсхийж байгаад мөнгө олдвол биш ээ. Ирэх 5 жилд, 7 жилд хэд болгох юм. Тэрийгээ Монгол төр заачих. Дүнтэй, тоотой нь, хугацаатай нь. Хууль болгочихъё. Тэгээд тэр дээрээ мөнгөө олох нь замаасаа авна уу, баялгийн сангаасаа авна уу, гаднаас зээлнэ үү тэр бол тусдаа асуудал байхгүй юу. Энэ Монгол төрийн бодлого болохоос биш, зүгээр байдаг бүх юмаа хүслийн жагсаалтдаа хуваачхад, зам харгуйдаа хуваачхад, эргээд үлдсэнээр нь өнгөрсөн жил шигээ явж бай даа, мөнгө алга гэж ярьж байгаа чинь өөрөө Монгол төрийн бодлого биш. Сайд хүний хариулт бол биш шүү. Тэгээд Сангийн яамны яг мэргэжилтнүүдээс бол ийм хариулт хэлж болно. Мөнгө байхгүй. Сайд нар бол мөнгийг олох ёстой, хуваарилах ёстой бодлого барьж байгаа хүмүүс. Энэ дээр зарчмын өөрчлөлт гарахгүй бол бид нар цалин байтугай юу ч хийж чадахгүй. Монгол улс урагшлахгүй.

Р.Сэддорж: 5 номер хариулах уу. 5 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт төсвийн нийт зарлагын хэмжээ өөрөө мөнгөний бодлоготой бол уялддаг. Хэр их зарлага тавьж байгаагаас шалтгаалаад нөгөө талдаа хувийн хэвшилд хэр их боломж гарч ирэх вэ гэдгээс

шалтгаална. Инфляцад бол төсвийн нийт зарлага нөлөөлнө. Хэрвээ инфляц бага байх юм бол хүү багатай зээл олдох боломж тэр хэмжээгээр нэмэгдэнэ.

Монгол Улсад нийт ажил хийж байгаа 1,4 сая иргэн байгаа. Үүнээс 220 мянга орчим нь төсвөөс цалин авч байна. Тэгэхээр үлдэж байгаа 1,2 сая хүний сайн сайхны төлөө Монголын нийт ард түмний сайн сайхны төлөө төсвийн бодлого маань өөрөө төрийнхөө мөнгөний бодлоготойгоо бас уялдаж явах шаардлагатай гэж бид үзэж байгаа. Зөвхөн багш нарын цалинг бид нар онцлогоор авч үзээд ингэж явах бол зохисгүй. Бүх салбарын цалинг нэгдсэн байдлаар авч үзэх нь зөв болов уу гэж үзэж байна. Монголбанкнаас сүүлд хийсэн судалгаагаар төрийн албан хаагчдын цалинг 10 хувиар нэмэхэд 4,4 хувиар инфляц нэмэгдэж байна гэдэг асуудал болчихоод байгаа юм. Тэгэхээр цалин нэмэхдээ бид нар эхлээд инфляцаа .../минут дуусав/

Р.Сэддорж: Найдалаа гишүүн дараа нь үгэн дээр хэлж болно. Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өглөөний мэнд хүргэе. Төсвийн 1 дүгээр хавсралт Кэй Пи Ай шалгуур үзүүлэлтээ л дахиад ярья. Миний салбар бол Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас асууя.

1 дүгээр хавсралтын 34.1.4.шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

34.1.5 шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. Цэвэр, бохир усны шугамд холбогдсон айл өрхүүд хүн амын хувийг нь нэмэгдүүлнэ гэсэн зорилт тавьсан байна. Дахиад юугаар хэмжих юм гэсэн чинь километр гээд тавьчихсан байна. Хувиа нэмэгдүүлнэ гэсэн зорилт тавьчихаад километрээр яаж нэмэгдүүлэх гэж байгаа юм. Дээрээс нь нэмээд зорилтот түвшин нь суурь түвшнээсээ багасаад ороод ирж байна. 220 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт Хот байгуулалтын яаман дээр байгаа. Ирэх жил. Хувиа нэмэгдүүлнэ гэсэн зорилго тавьчихаад, километрээр хэмжээд, тэр километр нь багасаад ороод ирж байгаа. Та хэд маань төлөвлөсөн ажил, тавьсан зорилго, зорилтоо яаж биелүүлнэ гэж тооцож байгаа юм.

Хоёрдугаарх нь үндэсний орон сууцын хөтөлбөр хэрэгжүүлнэ гэжээ. Төрийн албан хаагчид болон түрээсийн орон сууцын нэг маягийн зураг төсөл боловсруулна гэсэн. Энэ дээр эрчим хүчний хэмнэлттэй байдлаар ажлын даалгаврыг боловсруулж байна уу. Хөдөө, орон нутагт барилга барьдаг нэг маягийн зураг төсөв хийдэг. Нөгөөх нь бөөн эрчим хүчний алдагдалтай. Халаагаад халаагаад халдаггүй. Цонх, хаалга нь мөөгөнцөртөөд байж байдаг ийм асуудлууд орон даяар байгаа. Аймгийн төв, сумын төв хаа сайгүй. Ажлын даалгавраа яаж боловсруулж байгаа вэ гэсэн 2 дугаар асуулт.

3 дахь асуулт Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулах. Хүннү хотын ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг боловсруулж батлуулах гээд хэрэгжүүлэх шалгуур үзүүлэлт нь болохоор боловсруулж, батлагдсан үзэл баримтлал, ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал. Миний авсан мэдээллээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь боловсруулагдаад, өргөн баригдаад, зарим нь батлагдчихсан. Тэгсэн чинь араас нь үзэл баримтлалыг нь боловсруулна гээд ороод ирж байна. Ном журмаар бол энэ чинь эхлээд үзэл баримтлал нь байж байгаад, араас нь төлөвлөгөөгөө баталдаггүй юм уу. Араас нь ажлаа хийгээд байгаа

юм уу. Үзэл баримтлал нь байхгүйгээр хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөө баталсан болж таарч байна уу. Энэ дээр хариуцсан нэгж нь байвал тэр хариулахыг хүсэж байна.

4 дүгээр асуулт улс, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 20 минутын хот үзэл баримтлалд нийцүүлэн жишиг загвараа боловсруулна гэж байна. Та бүхэнд 20 минутын үзэл баримтлалыг боловсруулаад өнгөрсөн хаврын чуулганаар өгөөд, энийгээ Засгийн газарт өргөн бариад, Их Хурлаараа батлуулъя гэсэн. Одоог хүртэл өргөн баригдаагүй л явж байна. Энийг хэзээ өргөн барьж батлуулах вэ. Уг нь Хот байгуулалтын яамныхаа ажлыг нь бүгдийг нь дэмжээд л явж байгаа. Очоод л уулзалт хийдэг. Улсаараа нэг хүн шиг хотод амьдармаар байна шүү дээ. Дархан, Эрдэнэт, нийслэл, аймгийн төвүүд гэрээсээ гараад л ногоон байгууламж нь байж байдаг. Гэрээсээ гараад л сургууль, цэцэрлэг, эмнэлэг нь байж байдаг ийм болгоё гэсэн зорилттой л 20 минутын үзэл баримтлал мэргэжлийн хүний хувьд бүгдийг нь дэмжиж өгөөд, ажлын хэсэгт нь орж ажиллаад, гаргаад боловсруулаад өгөхөөр өргөн барихгүй юм. Тэгснээ тэрэндээ нийцүүлээд жишиг загвар боловсруулна гээд ороод байдаг. Ажлын дэс дараалал гэдэг юм яаж явж байгаа юм бэ. Энэ дээрээ тодорхой хариулт аваад, дараа нь тодруулъя.

Р.Сэддорж: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам. 4, 5 дээр суучих. Сайд Учрал сайдын микрофон өгье.

Н.Учрал: Тэгээд энэ Лувсанжамц гишүүний хурал болгон дээр хэлээд байгаа энэ асуудал бол яг үнэн шүү. Бүр одоо бодлогын баримт бичгүүддээ төөрлөө шүү дээ ер нь бол. 2019 оны хөгжлийн бодлогын хууль гарсан. Түүнээс хойш уг нь цэгцэлье гээд л их зорьсон юм байна лээ. Тэгээд 2021 онд 5 жилийн чиглэл баталсан. Тэгээд чиглэл баталж жилийн төлөвлөгөө оруулж ирдэг юм уу. Би бол гайхаж байгаа. Би энэ ажлыг аваад бас 100 л хонож байна л даа. Тэгээд энэ хугацаандаа яах вэ, би бол 2016 оноос өмнө бас хувийн хэвшилд ажиллаж байсан хүн учраас надад ки пи ай үнэлгээ энэ тэр бол тийм хол биш л дээ. Тэгээд яг тийм сэтгэлгээгээр ажил хийе гэхээр хэрэгтэй, хэрэггүй баахан бичиг баримттай. Тэгээд Хөгжлийн бодлогын хуулиар Эдийн засаг, хөгжлийн сайдад жилийн төлөвлөгөө, хөгжлийн бодлогын баримт бичигтэй төсөв уялдсан юм уу гэдэг дээр нь зөвшөөрөл өгдөг эрх байдаг мөртөө тэр чинь зүгээр л нэг бэлгэ тэмдэг. Төсөв орохын өмнөх орой яаруу сандруу явуулаад, залгаад хурдан дарцаа дарчих л гэдэг болохоос биш ийм юм байхгүй шүү дээ. Тэгээд яамнууд дээр ажлуудаа өөрсдөө хоорондоо нэгтгэхгүй, мэдээлэл нь дутуу, тэгээд орж ирээд Их Хурал дээр сууж байдаг ийм л байдалтай байхгүй юу. Тэгээд яг шалгуур үзүүлэлтээр нь хангаад байгаа юм бол байхгүй шүү дээ. Тэгээд өмнө жил яасан. Төрийн байгуулалтын байнгын хороо дээр жилийн төлөвлөгөөний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн талаар тайлан тавьсан. Одбаяр сайд, бид 2 орж ирээд. Тэгэхэд яасан одоо хэдэн ажил хийсэн. Тэгээд нөгөө үнэлгээ нь тодорхойгүй учраас, шалгуур үзүүлэлт нь тодорхойгүй учраас баахан зурагтай, юу хийсэн юм гэхээр тийм форум хийсэн, тийм уулзалт хийсэн гээд баахан зураг хавсаргачихдаг. Тэгээд хангалттай, хангалтгүй гээд үнэлчихдэг. Тэгээд аргагүйн эрхэнд л нэг ийм юм болоод байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ удаа юу гэж зорьсон бэ гэхээр нэгэнт ийм 5 жилийн чиглэлийг барих ийм цикл тохиочихсон. Тийм учраас энэ 5 жилийн чиглэл дээр дандаа индексүүдийг ер нь хэмжье л гэж зорьсон. Одоо жишээ нь бид нар төсвийн хүрээ оруулж ирэхэд эдийн засгийн өсөлт 5,7, 5,6 байна гэвэл уул уурхайн салбар хэдэн нэгж хувиар энд хувь нэмрээ оруулах юм. Түүнийг хийхийн тулд яг ямар ямар ажлыг

хийх юм бэ гэдгийг нь тавьж байгаа шүү дээ. Жишээ нь Оюутолгойн хэлэлцээрээ дуусгана шүү. Петрочайны хэлэлцээрийг дуусгана шүү. Ингэснээрээ алт, зэсийн агуулга нэмэгдсэнээрээ танайх ийм нэгж хувиар эдийн засгийн өсөлтөд нэмэр болно шүү гэдэг шиг яам болгон энэ жилийн төлөвлөгөөг биелүүлье гэвэл ийм ажлыг хийнэ шүү гэж. Боловсролын салбар юу гэдэг юм 3 дугаар ангийн хүүхдүүдийн унших чадварыг тэдэн хувиар ахиулна гэж байвал тухайн салбарт тестийн дундаж оноо тэд байна гэдгийг нь индикатор болгож тавиад, түүнд хүрээгүй бол хүрээгүй, хүрсэн бол хүрсэн гээд явах ёстой шүү дээ. Хүний хөгжлийн индексийг яах юм. Эдийн засгийн эрх чөлөөний индексээр эхний 60 байрт орно. 5 жил дотор. Тэгвэл ирэх жил 5 байраар ахиулна. 5 байраар ахиулахын тулд барилгын салбар ямар нэгж хувиар үүнд хувь нэмрээ оруулах юм. Үүнийг хийхийн тулд барилгын тусгай зөвшөөрлийг тэдээр цөөлнө. Яг ингэж л бичсэн. Энэ удаагийн 5 жилийн чиглэлийг. Тийм учраас 14 индексийг тавиад л оруулна. 14 индексийг тавиад энэ индекст хүрэхийн тулд танай салбар ямар үүрэгтэй вэ гэдгийг нь ингэж индикатор маягаар тавьж өгөөд, тэгээд ирэх жилээс жилийн төлөвлөгөө 5 жилийн чиглэлтэй нийцнэ. Энд хүрсэн үү, хүрээгүй. Тэр мянган форм хийнэ үү, яана уу тэр ерөөсөө хамаагүй. Энд хүрээгүй л бол хүрээгүй. Ажлын байрыг тэдэн хувиар нэмэгдүүлнэ. Үүнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар хэдэн хувь, яаж хувь нэмэр оруулах юм. Хүрсэн бол хүрсэн, хүрээгүй бол хүрээгүй гэж ингэж л явдаг. Тэгээд ингэж л явах ёстой юм байна лээ. Би тэгээд тэгж .../минут дуусав/

Р.Сэддорж: Асуулт дээр Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн, Улсын Их Хурлын гишүүн Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн Шижир нарыг нэмье. Хариулт 4 номер Сайн байна уу.

М.Ням-Очир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын дарга Ням-Очир гэж хүн байна. Гишүүний асуултад хариулъя.

Шаардлага хангасан ус хангамжаар хангагдсан хүн амын тоо, шаардлага хангагдсан ариун цэврийн байгууламжид холбогдсон хүн амын тоо гэдэг үзүүлэлтүүдийг хувилж гаргаж байгаа. Километр гэдэг бол бас урьд нь гарсан Эрчим хүчний яам дээр бас яригдаж байсан алдаа давтагдсан юм шиг байна. Манайхаас бол хувилж хүргүүлсэн байгаа. 2025 оны бид нарын зорилт бол шаардлага хангасан ус хангамжид холбогдсон хүн амын тоог 85 хүргэнэ. 2024 оны жилийн эцсийн тоогоор 83,6 хувьтай байгаа. 2025 оны жилийн эцсээр бид нар мөн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид холбогдсон хүн амын тоог 70 хувь хүргэх ёстой. 2024 оны жилийн эцсийн байдлаар 69,6 хувьтай байгаа. Ийм тоон үзүүлэлтүүдтэй байна.

Р.Сэддорж: 5 номер. 1 минут нэмж хариулъя.

Ү.Мөнхжаргал: Сайн байцгаана уу. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын хэлтсийн дарга Мөнхжаргал байна.

Нэг маягийн зургийг 2023 оны Засгийн газрын 483 дугаар тогтоолын дагуу хэрэгжүүлж байгаа. Түрээсийн орон сууцын бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд нэг маягийн зургийг хийлгэж байгаа. Тэгээд тэр нэг маягийн зургийн даалгаврыг бол ид бид нар боловсруулж байгаа. Лувсанжамц гишүүний асуусны дагуу ер нь эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт руу чиглүүлсэн байдлаар зургийн даалгаврыг боловсруулж байгаа. Таны саналыг аваад нэгтгэж болно.

2 дугаар асуудал 20 минутын хотын үзэл баримтлалыг өргөн барих талаар бид нар яг одоо ажиллаж байгаа. Өргөн барихаар бэлтгэж байна. Мөн Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 4 сард тендер зарлагдаад, 5 сарын 31-нд .../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 5 номер.

Ү.Мөнхжаргал: Хэмнэлтийн хуулиар бол төсөв нь татагдсан байгаа. Одоо тэгээд даалгавар нь шинэчилж, дахин боловсруулж батлуулаад, төсвийг нь бол оруулаад, энэ ажлыг бол хийлгэхээр ажиллаж байна. Хархорин хот нь өөрийн гэсэн хуультай байгаа. Энэ хуулийн хүрээнд бол энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа бүсчлэлийн дүрэм зэрэг бусад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуух ажлууд нь бол дараа нь хийгдэх юм байгаа юм.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн тодруулж асууна.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Тэгээд 1 дүгээр хавсралтынхаа шалгуур үзүүлэлт дээрээ өндөр ач холбогдол өгөөгүй болохоор өргөн барьсан төсөв дээр ийм асуудлууд гараад байгаа шүү дээ. Уг нь таны Ням-Очир даргын хэлж байгаагаар сайхан л зорилтууд сонсогдож байна. Тэгээд нэгэнт бид нар бичиг баримтаа зөв боловсруулаад, түүнийгээ барьж л хяналт үнэлгээгээ хийнэ. Тэгэхээр энийгээ сайн анхаараасай гэж бодож байна.

Ерөнхий төлөвлөгөө дээр Хүннү болон Хархорин хот дээр төлөвлөгөө боловсруулна гэж байгаа юм байна. Миний асуулт болохоор үзэл баримтлалаа төлөвлөгөөнийхөө араас батлаад байна. Боловсруулах гээд байна. Эхлээд үзэл баримтлал нь байж байгаад, дараа нь төлөвлөгөөгөө боловсруулдаг биш юм уу. Тэгэхээр өмнө нь үзэл баримтлалгүйгээр төлөвлөгөө баталчихсан гэсэн үг үү.

Р.Сэддорж: Хариулт хэдэн номер вэ. 5.

Ү.Мөнхжаргал: Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал бол батлагдсан байгаа. Хүннүгийнх бол хийгдэж байгаа. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө бол мэдээж үзэл баримтлалынхаа дараа хийгдэнэ. Одоо төсөв нь энэ жил хийгдэхээр төсөв нь ороод явж байгаа гэсэн үг. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь энэ жил хийгдэнэ. 2026 онд.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Тэгвэл одоо батлагдаагүй байгаа. Эхлээд үзэл баримтлалаа хийгээд, дараа нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөө юм байна. Ойлголоо. Баярлалаа. Энэ хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа 20 минутын үзэл баримтлалтайгаа нийлүүлэх ёстой шүү. Тэрний тулд та бүхэн маань сая хэлсэн үзэл баримтлалаа өргөн барьж батлуулна гэдэг ажлаа яаравчлах хэрэгтэй байна. Дахиад олон улсад онигоо болоод байгаа 1 юмыг ярья даа.

Тэгээд Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний олон улсын уралдаан зарласан. Тэгээд 1 дүгээр байрыг нь шалгаруулж чадахгүйгээр 5 компанид та бүхэн хамгийн шилдэг нь байлаа гээд хэлсэн. Тэгээд шагнал гардуулна гэсэн нөгөө шагналаа гардуулахгүй, миний авсан мэдээллээр бүтэн жил голорч байгаа. Гаднын Кюма Кенго энэ тэр гээд олон улсад алдартай архитектур оролцсон. Тэрнийх нь шагналын мөнгийг нь өгсөн юм болов уу, өгөөгүй юм болов уу. Араас нь

Хүннүгийн олон улсын уралдаан зарлаж байна. Өмнөх шагналаа өгөөгүй юм байж байж, 2 дахь уралдаан дээр нь гаднын аж ахуйн нэгжүүд орж ирэх болов уу даа гэсэн .../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт хэдэн номер вэ. 5 номер тодорхой хариулаарай.

Ү.Мөнхжаргал: Гишүүний саяын хэлсэн зүйлийг бид нар Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр анхаарч ажиллая.

Р.Сэддорж: Тэгээд гишүүн хэлээд байна шүү дээ. Хэмжих нэгж дээр километр гэж юу тавиад байгаа юм бэ. Километрийг чинь хэн ч ойлгохгүй шүү дээ. Та хэд л ойлгож байгаа. Тэгээд хувь хэдэн хувь биелэх ёстой, хэдэн хувьд нь хийх ёстой. Тэгээд хэдэн хувийг нь тавьж байгаа юм бэ гэдгийг л асуугаад байна шүү дээ. Тэгээд энэ дээрээ та хэд хэмжих нэгж дээрээ энэ юун дээрээ алдчихсан байна шүү дээ. Тодорхойгүй байна шүү дээ. Тэр 53км-ийг чинь хаана гэж хэн ч ойлгохгүй байна шүү дээ. Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Өглөөний мэнд хүргэе. Тэгээд энэ төсөв дээр бид нарын нэг харах ёстой юм гадаад зээлтэй холбоотойгоор орон сууцын төслүүдийг заавал ярих хэрэгтэй байгаад байгаа юм. Монголбанкныхан бас байгаа байх. Тэгээд ер нь энэ бодлого тодорхойлогч нар маань энэ бодлогоо эргэж харах хэрэгтэй үе байна л даа. 2016-2024 оны хооронд 6,1 их наяд төгрөгийг ерөнхийдөө бол ипотекийн зээлээр гарсан. Зарцуулагдсан байгаа юм. Тэгээд 2016 оноос хойш цэврээр бол 3,5 их наяд төгрөгийн өсөлт үзүүлэлт бол гарсан. Үүний 10 хувийг нь л арилжааны банкнуудаас санхүүжүүлсэн гэж үзэх юм бол Монголбанк ердөөсөө үлдсэн мөнгийг нь хэвлээд зах зээл рүү нийлүүлчихсэн байгаад байгаа юм. Тэгээд энэ маань бол өөрөө хэрэглээний үнийн индексийг 2 дахин нэмэгдүүлчихсэн. Нөгөө иргэдийн яриад байгаа юмны үнэ өндөр болчихоод байна. Инфляц өндөр болчихоод байна гэдэг асуудлыг дэгдээхэд хамгийн гол нөлөөтэй оролцчихсон хөтөлбөр маань бол өөрөө энэ ипотекийн зээл гэдэг хөтөлбөр байгаа юм. Тэгээд иргэдэд сонсогдохдоо энэ өөрөө асар гоё сонсогддог. Бид бүхэн иргэн болгон орон сууцад амьдрах хэрэгтэй гэдэг агуулга нь гоё харагддаг. Тэгээд бодит байдал дээр энэ хэнд хүрээд байна гээд харахаар жишээ нь 2025 онд 80 хувь нь Улаанбаатар хотод олгогдсон байгаа юм. Бид нар нөгөө Улаанбаатар хотын төвлөрөл хэт их байгаад байна. Яаж орон нутгууд руугаа хөгжлийг төлөвлөх вэ гэж ярьдаг хэр нь төрийн бодлого чинь өөрөө эсрэг зүг рүүгээ явчихсан. Улаанбаатар хот дотроо ахиад харах юм бол Хан-Уул дүүрэг нисэх дээр бүх төвлөрөл нь бий болчихсон байгаа юм. Тэгээд энэ чинь яг гэр хорооллыгоо өөрчлөөд байгаа бодлого мөн юм уу гэвэл үгүй. Одоо нийслэл дээр Нямбаатар даргын энэ баахан Хятадтай нийлж хийгээд байгаа энэ орон сууцын төслүүд байгаа. Эд нар бол цэвэр мөнгө угаалт дахиад л явагдаж байгаа юм. Тэгээд энэ бодлогыг бид нар нэг эргэж харах ёстой байгаад байгаа юм. Монголбанк дээр одоо яг мөнгө хэвлэсэн байдлаар явдаг байсан нь одоо сүүл рүүгээ баялгийн сан руугаа оръё гэдэг энэ асуудал яригдаж байна. Ер нь баялгийн сангийн мөнгийг бид нар зах зээл дээрээ мөнгө хэлбэрээр оруулаад өгнө гэдэг чинь асар буруу зүйл байгаа юм. Венесуэл улс яг ингэж явж байсан. Венесуэл улс бас яг баялгийн сангийнхаа мөнгийг орон сууц руу оруулаад, бүх иргэндээ орон сууц өгнө гэж ярьсан. Тэгээд тэр үнэд нь бол кентлизм буюу төртэй ойр гэрээт тендер авч чаддаг тэр компаниуд нь л хэдэн байрнууд бариад, нөгөө талдаа болонгуут нь эргэн төлөлт нь хангагдаж чаддаггүй, зах зээл нь өөрөө уначихсан. Тэгээд яагаад энэ бодлого буруу байгаад байгааг харах хэрэгтэй байна гэхээр одоо жишээ нь орон сууцын үнэ 2016 оны 1 дүгээр улирлаар 1 метр квадрат 1,9 сая төгрөг байсан. Одоо 2024 оных эцсийн байдлаар харахад 4,6 сая төгрөг болсон байгаа. Тэгэхээр чинь үүнтэй хамт

цалин өөрөө өсөөгүй байгаа. Тэгээд бид нар хиймэл эрэлтийг бий болгож, хуурамчаар энэ хөтөлбөрийг ингэж санхүүжүүлж явна гэдэг маань цаад утгаараа бид нар бүх эдийн засгаа унагаачихсан бодлого яваад байна шүү дээ. Энэ дээр Монголбанкнаас асуумаар байгаа юм. Энэ бодит байдлыг та нар гаргаж ирж хэлдэггүй юм уу. Одоо ингээд яваад байх юм уу. Баялгийн сангаар энийгээ цааш нь үргэлжлүүлээд явах юм уу.

Дараа нь эрчим хүчний та Чойжилсүрэнгээс асуумаар байгаа юм. 2017 оноос хойш Улаанбаатар хотын нэгдсэн дулааны хувьд хүчин чадал бол дүүрчихсэн, боломжгүй болчихсон гээд байгаа юм. Тийм хэр нь .../минут дуусав/

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн 1 минут.

С.Цэнгүүн: Тийм хэр нь яаж жишээ нь Улаанбаатар хотод нэмэх дээр дулаан цахилгаанд холбогдож яваад байгаа юм бэ. Бид нар үндсэн стандарт дээрээ бол - 40 градус хүртэл жишээ нь нэгдсэн дулааны сүлжээг бол тооцож авч явдаг. Сүүлийн жилүүдэд -27 градус болдог учраас тэр хоорондын зөрүү дээр нь бол дулаан сүлжээнийхэн шинэ холболтуудыг оруулж явж байгаа гэж тооцож байна. Гэхдээ өвөл ямар болохыг бид нар мэдэхгүй. Яг үнэхээр бодит байдал дээрээ -40 градус ирэх жилүүдэд хүрэх юм бол Улаанбаатар хот маань бол хөлдөх аюултай болж байгаа юм. Тэгэхээр үүний хариуцлагыг хэн хүлээх вэ. Бид бүхэн энэ төлөвлөлт дээрээ дандаа ийм буруу төлөвлөлтөөс болж үүдэж явсан үйл гайг нь үүрээд явж байна. Тэгээд энэ дээр хариулт авъя.

Р.Сэддорж: Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын харьяа төсвийн ерөнхийлөн захирагчдаас асууж байгаа. Монголбанк бол бие даасан төсөвтэй байгууллага учраас энд ирээгүй байна. Сангийн яам хариулна. Дээрээс нь Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын яам хариулна. Дараа нь Чойжилсүрэн сайд хариулна. Одоо 6 номер.

С.Тулга: Сайн байна уу. Сангийн яам Тулгаа. Гишүүний асуултад хариулъя. Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн хувьд 2024 онд 1.4 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт гаргасан. Энэ бол шинээр гаргаж байгаа мөнгө биш. Өмнө гаргасан ипотекийн зээлийнхээ эргэн төлөлтөөс Төв банкнаас жил бүр эргэн төлөлтөө буцааж, ипотекийн санхүүжилт рүү гаргадаг гэсэн манайх бол ойлголттой байгаа. Тэгээд 1,4 их наядаас Улаанбаатар хотод 60 хувийг нь буюу 866,2 тэрбум төгрөгийг, орон нутагт 566,2 тэрбум төгрөг буюу 40 хувийг нь олгосон байгаа. Үндэсний баялгийн сангийн хувьд бол дотроо 3 сан байгаа. Ирээдүй өв санг бол бид нар бол гадаадад, бусад орнуудын төв банк дээр хадгалж байгаа. Хуримтлалын сангийн хөрөнгийг бол дотоодод хөрөнгө оруулах байдлаар шийднэ гээд хууль дээрээ заачихсан байгаа. Энийг бол төв банкны бас данс дээр хадгалдаг. Хуримтлалын сангийн хөрөнгийг бол бид нар орон сууцын хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр дээр хөрөнгө оруулах байдлаар хэрэгжүүлж байгаа. Тэгээд хуримтлалын сан дээр жил болгон бодлогын хүүгээр хүү тооцоод явж байгаа.

Р.Сэддорж: Хариулт 5 номер.

Ү.Мөнхжаргал: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хэлтсийн дарга Мөнхжаргал. Ипотекийн зээлийг хүртээмжтэй болгох чиглэлээр яаман дээр бол санал боловсруулаад, зээлийн хөнгөлөлттэй журамд нь өөрчлөлт оруулах санал боловсруулж байгаа. Тухайлбал одоо яг Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл дээр дурдагдсан гэр

хорооллын дахин төлөвлөлтийн болон 1, 2 дугаар бүсүүдэд ипотекийн зээлийг хүүгийн ялгавартай байдлаар олгуулах яг ийм саналыг бид нар боловсруулаад холбогдох газар луу нь хүргүүлж байгаа.

Р.Сэддорж: Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Та ч ер нь шалтгаанаа бараг өөрөө хэлчихлээ дээ. -39 градустай 7 хоногоос дээш хугацаанд шөнө температур байсан тохиолдолд тооцож, тасалгаанд 23 градус барихаар ийм тооцоолол анх хийгдсэн юм байна лээ. Сүүлийн жилүүдэд -39 градус хүрэхгүй байгаа учраас Монгол зангаараа нэмж техникийн нөхцөлүүд олгож явсаар байгаад хүчин чадлаас нь 50 хувь давчихсан ийм байгаа нь үнэн. Нэн ялангуяа 2012-2016 онд бол хамгийн их техникийн нөхцөлүүд олгогдсон байдаг юм. Улс төр гэж янз бүрийн юм ярихгүй би. Ер нь бол Улаанбаатар хотын дулааны асуудал ярьж байх шиг байна. Хэт ачаалагдсан хэсгүүд дээр нь нэн ялангуяа Хан-Уул дүүргийн 11, 15, 17, 18, Баянзүрхийн 26 дугаар хорооны төгсгөл дээр газрын станцаар яг гарцаагүй таны яриад байгаа нөхцөл байдал порсе мажор үүссэн тохиолдолд нөгөө талаас нь/минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Газрын станцаар ийм нөөцөөр дулааны станц барихаар 3, 4 газарт ажлыг нь эхлүүлээд байгаа. Хамгийн сүүлийнх нь бол будилж будилж явсаар байгаад бид нар Зайсангийн гүүрний зүүн талд 4 га газар 1 аж ахуйн нэгж ажиллаж байсныг нь аваад энэ жил 1-ийг нь эхлэх гэж байна. Сэлбэ дэд төв, Дамбадаржаа дэд төв гэх мэт дулааны тархмал эх үүсвэрүүдийг нэмж барихаас өөр аргагүй. Өнгөрсөн 2024 онд Амгалан дулааны станцыг 116 гигакиллкалори цагаар нэмэгдүүлснээс өөр яг сүүлийн 3 жилийн туршид бол Улаанбаатар хотод дулааны хангамжийн талаар бодитой ажиллаж сүртэй хийгдэж амжаагүй байна. Хүлээн зөвшөөрөх ёстой гэж бодож байгаа.

Р.Сэддорж: Цэнгүүн гишүүн хариулт хангалтгүй гэж үзэх 1 минут.

С.Цэнгүүн: Сангийн яамнаас асуумаар байна. Гадаад зээлийг ашиглалтаа бид нар яг жишээ нь орон сууцын төсөвлөлт хийгээд байгаа маань өөрөө энэ бүтээмж дээрээ хэр байгаа юм бэ. Та нар энэ дээр тооцоонуудыг нь хийж үзэж байгаа юу. Бид бүхэн чинь хөгжлийн төлөвлөгөө дээрээ хэтэрхий олон төслүүдтэй байгаад байна. Сангийн яам дээр жинлэж үзэж байгаад, илүү үр өгөөжтэй төслүүдийг нь оруулж ирж байгаа гэж ойлгоод байгаа. Тэгэхээр энэ дээрээ яг хийсэн судалгаа байгаа юу гэж асууя.

Барилгын яамнаас болохоороо метр квадратын үнийг харьцуулж хармаар байна л даа. Энэ гадаад зээлээр хийгдэж байгаа барилгуудын метр квадратын үнэ, хувийн хэвшлийн компаниуд, хувийнхан өөрсдөө хийж байгаа метр квадратын үнэ 2-ын харьцаа нь хэдтэй байгаа вэ. Энэ дүн дээр хармаар байна. Яагаад гэхээр жишээ нь Хятадын зээлээр баригдаж байгаа барилгуудыг харангуут тусламж гээд жижиг мөнгө өгчихдөг. 1 төсөл ч байдаг юм уу өгчхөөд, тэрийгээ дагуулаад тэр тусламжийн дүнгээсээ асар өндөр дүнгээр зээлийг нь өгчихдөг. Телевиз худалдаж авах юм бол будаа агшаагч өгч байна гэж байгаа юм шиг юмыг манай засагт өгчхөөд байна шүү дээ.

Р.Сэддорж: 4 номер Сангийн яам.

Ж.Дэлгэржаргал: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Тэгэхээр гадаад зээл, тусламжийн төслүүд дээр яг орон сууцтай холбоотой 5 төсөл хэрэгжиж байгаа. 1 нь бол Ногоон нуур 1008 айл бол БНХАУ-ын буцалтгүй тусламжаар, бусад төслүүд нь Азийн хөгжлийн банк, Солонгосын Эксим банк гээд нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй ийм төслүүд явж байгаа. Бид нарын хувьд энэ төслүүдийг дамжуулан зээл болгох ийм ажлуудыг бас Сангийн яам дотроо хийгээд явж байгаа. Хэлэлцээрүүд дээр. Энэ үлдсэн тусламжаас бусад зээлийн төслүүдийн хувьд бол Улсын Их Хурлаар 2018, 2019 онд хэлэлцээрүүд нь соёрхон батлагдсан. Олон улсын гэрээгээр бид нар энэ төслүүдийг хэрэгжүүлээд дуусгах ийм үүрэг хүлээгээд явж байгаа. Гадаад зээлийн ашиглалт дээр бол гүйцэтгэлд нь үндэслээд санхүүжүүлээд явж байгаа. Зээлийн төслүүдийн хувьд бол Өрийн удирдлагын тухай хуулийн 18-д заасны дагуу Улсын Их Хурлаар соёрхон батлахдаа ТЭЗҮ хийгдээд, ТЭЗҮ дээрээ яг энэ нийгмийн хувьд ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагатай гэдэг тодорхойлогдоод .../минут дуусав/

Р.Сэддорж: 4 номер гүйцээж хариулъя. 1 минут.

Ж.Дэлгэржаргал: Түүний дагуу хэрэгжилт нь явж байгаа. Яг бид нарын гаргасан судалгаагаар бол метр квадрат нь 3 саяас 3 сая 300 гэдэг ийм судалгааг бол сүүлд хэрэгжүүлэгч байгууллагуудаас авсан. Барилга, хот байгуулалтын яамнаас мэдээж нэмж дэлгэрэнгүй өгөх байх. Бид нарын хувьд бол яг санхүүжилт гэрээ хэлэлцээрийнхээ дагуу хэрэгжилтийнх нь явж байгаа санхүүжилт дээр ашиглалтыг нь хариуцаад явж байна.

Р.Сэддорж: 5 номер.

Ү.Мөнхжаргал: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Мөнхжаргал. Саяын Сангийн яамны холбогдох хүний хариуцсан Ногоон нуурын 1008 айлын орон сууцын төсөл дээр бол энэ 10 дугаар сард улсын комисс ажиллаж, эцсийн байдлаар улсын комисс хүлээж авна. Тэгээд энэ гүйцэтгэлээр яг метр квадратын үнэлгээ нь гарах болохоор яг энэ ажил бол хийгдэж байгаа. Солонго 1, 2 төсөл мөн эхний ээлжийн 980 айлын орон сууцыг 2026 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Энэ дээр бас мөн гүйцэтгэлээр 1м2-ын үнэлгээ эцсийн байдлаар гарах байгаа. Одоогоор бол яг эцэслэн гараагүй байгаа.

Р.Сэддорж: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Бид чинь нөгөө мөнгөгүй биш, мөнгөтэй улс байгаад байгаа юм. Манай сайд нар юм ярихаараа мөнгө байхгүй гээд хоосон хармаа тэмтрээд байдаг. Тэгээд яг бодит байдал дээрээ бид нар маш их мөнгөтэй. Зөвхөн сүүлийн 5 жил 2026 оныг оруулах юм бол бид нар 162 их наяд 800 тэрбум төгрөг үрж байгаа байхгүй юу. Тэгээд өнөөдөр асуудал нь шийдэгдсэн 1 салбар ч байхгүй. Тэгээд төслөө яаж эрэмбэлдгийг бас 1 дүгээрт ойлгохгүй байна. Яагаад гэхээр 2026 оны төсөв дээр нийтдээ 579 ширхэг төсөл суусан. Түүний 489 нь ямар нэгэн барилга байгууламж, зам байгаа юм. Тэгээд анхны төсөвт өртөг нь 5,8 байсан. Энэ бүх төслүүдийн. Одоо 8,6 болсон. 2,8 их наяд буюу нийтдээ 3 их наядаар өсчхөж байгаа юм. Нөгөө ахмадын тэтгэврийг нэмж чадахгүй, багш нарын цалинг нэмж чадахгүй, тэтгэмжийг нь өгч чадахгүй, мөнгө байхгүй гээд хэлээ гаргаад, толгойгоо маажгаад суугаад байдаг. Бодит байдал дээр 3 их наядыг анхны төсөвт өртгөөрөө нэмээд л оруулаад ирж байгаа юм. Энэ бол авлига. Үүний цаана авлига байгаа. 2026 онд шилжиж орж ирж байгаа 139 төсөл чинь 805 тэрбумаар өссөн. Зөвхөн 2026 онд. Үгүй ээ, яагаад төсөвт өртөг нэмэгдээд байдаг юм. 5-аас дээш жил үргэлжилж байгаа 1

тэрбумаас дээш мөнгөн дүн нь өссөн 42 төсөл байна. Тэгээд бид нар чинь ийм баян улс юм уу. 1 асуудлаа дор нь шийдээд байж байж чаддаггүй юм уу. Тэгээд нөгөө цахим улс болно, лаг улс болно, ёстой цаасгүй болно гээд байсан бичиг хэргийн зардал чинь 5 дахин өсчихсөн шүү дээ. Зөвхөн орон нутгийн. Нөгөө хаана байна тэр цахим шилжилт чинь.

Тэгээд Эдийн засаг, хөгжлийн сайдаас 1 юм асууя. Ингэж байгаа юм. Хэрэглэгчийн эрх ашгийг 100 хувь хамгаална гэчихсэн байгаа. Одоо тэгээд манай хэрэглэгчийн эрх ашиг 100 хувь хамгаалагдаад байгаа юм уу.

2 дугаарт цахим дэлгүүрт байршуулах барааны тоог нэмэгдүүлнэ. 2026 онд 800 барааг цахим дэлгүүрт байршуулна гэнэ. Үгүй ээ, энийг чинь та нар хийхгүй шүү дээ. Энийг чинь тэр цахим худалдааны сайтууд өөрсдөө хийчихдэг байхгүй юу. Тэгээд яах юм. Та нар оймс, бандааш зарна гээд цахим худалдааны дэлгүүрт ороод сууж байх юм уу. Энэ цаасан дээр чинь ингээд бичсэн. 650 нэр төрлийн барааг 800 болгоно гээд. Үгүй ийм онигоотой юм хийхээ болиоч ээ сайд нар аа, Засгийн газраа за. Энэ нэмэх гээд байгаа 250 нэр төрлийн бараа нь юу юм. Ямар цахим худалдааны дэлгүүрт юу нэмэх гээд байгаа юм та нар. Наадхыг чинь тэр shopru.mn манай цахим үнэхээр сайн хөгжчихсөн шүү дээ. Та нартай, та наргүй өөрсдөө хийчихнэ. Хэрэглэгчийнхээ зах зээлийг мэдрээд. Зөрчлийг хянан шийдвэрлэнэ 100 хувь, хэрэглэгчийн гомдлыг 100 хувь шийднэ. Хэрэглэгчийн эрх эрхийг 100 хувь хамгаална гээд. Үгүй ээ, 100 хувь хамгаалчхаад байгаа юм уу. 100 хувь хамгаалчихсан байснаа дахиад 100 хувь гээд биччихсэн байгаа байхгүй юу. Үгүй ээ, ийм юм байдаг юм уу. Одоо Монголын бүх хэрэглэгчдийн сэтгэл хангалуун хаппи амьдраад байгаа юм байна л даа. Гомдол гаргах 1 ч хүн Монгол Улсад .../минут дуусав/

Р.Сэддорж: Эхний асуудал Сангийн яам хариулах уу. Учрал сайд.

Н.Учрал: Өнөөдөр яг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний хуулиар бол тэр Монополын эсрэг газар худалдан авахын газар бол Доржханд сайд дээр байгаа. Тэгэхдээ энэ Засгийн газар байгуулагдаад 100 хонож байгаа. Өмнө нь бол жилийн төлөвлөгөөг Их Хурлаар баталсан. Тэр төлөвлөгөөний дагуу л ажлаа хийж байгаа гэсэн үг. Тэр цахим дэлгүүр дээр шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнүүдийгээ оруулдаг и-тендер, и-прокурмент гээд ийм платформ байдаг. Тэгээд тэр дээр бараа үйлчилгээгээ худалдаж авдаг. Уг нь бол агуулга нь зөв. Тэгэхээр тэр тоогоо нэмэгдүүлсэн цагт бол янз бүрийн жишээ нь 1 компьютер эвдэрлээ гэхэд нэг шинээр авлаа гэхэд тендер зарлаад хугацаа алдаад байхгүйгээр тэр жагсаалтад байгаа бараа бүтээгдэхүүнээс худалдан авдаг. Энэ бол жишиг. Тэгэхээр тэр тоог бол ахиулах ёстой. Тэр бол зөв.

Тэгээд сая энэ Шижир гишүүний хэлж байгаа бол бид анхаарах ёстой. Бид нар гол нь жишээ нь намайг Цахим хөгжлийн сайдаар ажиллаж байхад Мэдээлэл технологийн үйлдвэрлэлийг дэмжих хууль, дээрээс нь тухайн үед бид нар яг энэ программ хангамжтай холбоотой худалдан авалт хийх бололцоотой тэр майнд голя энэ тэр гээд нэг систем хөгжүүлсэн шүү дээ. Тэгээд би Сангийн яамнаас их гуйсан даа. Тэгээд тэр дээр софтверүүдийг нь тавиад шууд худалдан авдаг болгочхооч ээ. Тэгээд дэмжихээч гээд хуульд 2 үг хийчих гээд яваад чадаагүй. Одоо бол ер нь цаашаа энэ хувийн хэвшилд байгаа янз бүрийн ийм онлайн худалдааны платформуудыг тэндээс шалгууруудыг хангасан бүтээгдэхүүнүүдийгээ энэ дээр нэгтгээд л аль ч сайтаар байна уу, аль ч тэр онлайн худалдаагаар байна уу авбал түүнийг нь шалгуур давсан бол худалдан авалтаа хийдэг буюу хувийн хэвшилтэй

хамтраад л хийх ёстой. Ингээд тухайн үед бол хуульд бичсэнээ яривал их олон удаа бичсэн. Тэр Нийтийн мэдээллийн хууль, сүүлдээ нөгөө цахимыг дэмжье гээд цаасан гээд хууль дээр нь байхаар нь цахим болгоё гээд 109 хуулийг хүртэл өөрчилж өгсөн шүү дээ. Тэгээд одоо ингээд эс үйлдлээрээ нэхээд байх юм. Сая энэ Эдийн засаг, хөгжлийн сайдаар ирээд нөгөө гааль дээр очсон чинь хүртэл цахимаар систем байгаад байдаг. Гэтэл бичгээр шаардчихсан шаардлага нь бараг 55 шаардлага байгаад байдаг. Цахимаар болоод байхад цаасаар нэхээд байдаг ийм эс үйлдэлтэй. Тэгэхээр бид нар ер нь хуульд биччихээд, хуульд авсан журмаар хаадаг юм байна лээ л дээ. Тэгэхээр 109 хуулийг ч өөрчилж өгсөн. Сая Гааль дээр тэр журмыг нь ч цуцалсан. Ингээд хууль давсан Хэрэг эрхлэх дээр байхад бас 54 билүү журам цуцалсан. Тэгээд байхад эс үйлдэхээрээ ийм хүн их авах гээд цахимаар дэмжье гээд байхад хүний оролцоог хангуулах гээд байдаг ийм зовлонтой. Тэгээд сая Эдийн засгийн эрх чөлөөний хууль бол энийг бас шийднэ гэж би найдаж байгаа юм. Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Зөвшөөрөл мэдэгдлийн хууль легал инфо дээр тавигдаад хэлэлцэгдээд, хувийн хэвшилд яриад явж байна.

Төр бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаас бусад тохиолдолд ямар нэгэн хуулиар хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нэмэлт шаардлага тавих, хянан шалгахыг хуулиар бүрэн хориглоно. Эдийн засгийн эрх чөлөөний хууль гаргасан. Ингээд одоо төрийн зарим чиг үүрэг буюу зөвшөөрлийн хуулиараа одоо энэ легал инфо дээр тавигдаж байгаа. Сая Засгийн газраас мэдүүлсэн хуулиар 100 зөвшөөрлөө мэргэжлийн холбоонд шилжүүлнэ. Одоо ингээд энэ хэмжээлшгүй эрх мэдэл тал талд төвлөрүүлдгээсээ салъя. Тэгээд хуулиа шат шатдаа хэрэглээд явъя л гэж зорьж байгаа.

Р.Сэддорж: Сангийн яам 6 номер.

Ж.Дэлгэржаргал: Шижир гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Өргөн барьсан төсөл дээр бол 549 төсөл байгаа. Яах вэ, энэ төслийн тоог бид нар сүүлийн 4 жилтэй харьцуулахад бол тухайн жилүүдээсээ 1 дахин буурсан. Шилжих төслийн тоо ч гэсэн он дамжин хэрэгжиж байгаа төслийн тоо буурч байгаа. Төсөвт өртөг нэмэгдэх асуудлууд бол гардаг. Энэ дээр бид нар сүүлийн 3 жил төсөвт өртгийн нэмэгдэл юунаас үүдэлтэй байгаа вэ гэхээр аудитаас гаргасан судалгаагаар нэг маягийн зураг төсөв, жишиг зураг төсөв, эсвэл газрын асуудал солигдох, нэмэлт ажлууд үүсэх гээд. Тэгэхээр нэмэгдлийг бид нар төсвийн төсөлд тусгахдаа 2 шалгуур тавьж байгаа.

1 дүгээрт нь бол тухайн нэмэлт санхүүжилтээр холбогдох эрх бүхий байгууллагуудын магадлалын ерөнхий дүгнэлт гараад, магадлалын ерөнхий дүгнэлт нь Сангийн яамны хүсэлтээр Үндэсний аудитын газар дүгнэлт гаргаад, яг тэр дүгнэлтийн дагуу тусгаж байгаа. Тэгэхээр 2026 оны хувьд бол 908 тэрбум биш нэмэгдлийн дүн 194 тэрбум .../минут дуусав/

Р.Сэддорж: 6 номер гүйцээж хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Нэмэгдлийн яг нэмэгдсэн санхүүжилтийн дүн бол 100 төслийн 194 тэрбум байгаа. Тэгэхээр өмнөх жилүүдэд бид нар судалгаа хийгээд 2010 оноос хойших судалгааг аваад үзэхээр ер нь нэмэгдэж байгаа төслүүдийн эхэлсэн он нь 2010-2021 онд эхэлсэн төслүүд байгаад байгаа. Тэгээд аудитын гаргасан судалгаан дээр ч байгаа, манай хийсэн судалгаан дээр ч байгаа. Яг бүх л

дүнгүүдээр тухайн төслийг эхлүүлэх байдлаар тавигдсан төслүүд. Яг хэрэгжүүлж дуусгахын тулд нэмэлт санхүүжилт үүссэн дээр 3 шатын ийм шалгуур тавьж, дүгнэлт гаргаж байж шийдвэрлээд явж байгаа.

Р.Сэддорж: Шижир гишүүн.

Ө.Шижир: Зөвхөн 2026 он руу чинь шилжиж орж ирж байгаа 139 төсөл чинь 805 тэрбумаар нэмэгдэж байгаа шүү дээ. 805. Та надаас энэ цаасыг ирээд ав. Танай өгсөн цаасан дээр байгаа.

2 дугаарт төр сүүний фермер яах гээд байгаа юм. Эрэмбэлчихсэн юмнууд чинь 2026 онд санхүүжих 820 тэрбум төгрөг зам гэж байгаа юм. Ингээд доошоо инженерийн шугам сүлжээ 215, хамгийн доор нь энэ жил 120 тэрбумаар санхүүжээд, нийт төсөвт өртөг нь 3,6, 3,7 тэрбум болж байгаа сүүний ферм байна шүү дээ. Төр сүүний фермээр яах гэж байгаа юм. Сайд нар сүү уух гэж байгаа юм уу. Хувийнхаа хэрэгцээндээ сүү авах гэж байгаа юм уу. Энийг бас ойлгохгүй байна.

2 дугаарт энэ цахим дэлгүүрт 650 бараа байршуулаад, 2026 онд 800 болгох юм гэнэ. Энийг чинь та нар хийдэггүй шүү дээ. Энийг чинь цахим худалдааны дэлгүүрүүд өөрсдөө хийчихдэг байхгүй юу. Юу зарах, юу худалдахаа. Тэгээд ийм байдлаар цаас оруулж ирэхээ болиоч ээ.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж 1 минут.

Ө.Шижир: 2024 оны МАН-ын мөрийн хөтөлбөр дээр 560 бодлогын баримт бичиг байна гээд биччихсэн. Тэгээд манай нам ялах юм бол энэ бодлогын баримт бичиг бууруулна. Бид нар маш тодорхой 1 бодлогын баримт бичигтэй байна гэсэн. Ингээд та нар засаг аваад, дахиад хэд хэдэн бодлогын баримт бичиг нэмчихлээ. Тэгээд энэ олон бодлогын баримт бичигт дотроо та нар өөрсдөө төөрөөд, хэмжих нэгжүүд нь хүртэл худлаа тавиад, сүүлдээ цахим барааны дэлгүүрээр юу зарахыг хүртэл шийддэг болох гээд байна шүү дээ. Энэ загас толгойноосоо өтдөг гэдэг шиг нөгөө урсгал зардал нь дийлдэхээ больчихсон. Би бүх сайд нар луу 10 сарын 1-ний өдөр бичиг явуулсан байгаа. Тэгээд ерөөсөө хариу ирдэггүй. Сангийн яамнаас 25 хоног хүлээж байж 1 урсгал зардлын бичиг авсан. Тэр дээр чинь бичиг хэргийн зардал чинь 5 дахин өсчихсөн. Урсгал засвар чинь 855 хувиар өсчихсөн. Бичиг хэргийн зардал чинь 5 дахин өсчихсөн. Багаж техник хэрэгсэл чинь .../минут дуусав/

Р.Сэддорж: 6 номер хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Өргөн барьсан төсвийн төсөл дээр Хөдөө аж ахуйн сайдын багц дээр цөцгийн тос боловсруулах ферм гээд Булган аймагт барихаар байгаа. 2022 оны төсөв хийхдээ Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж гэдэг нэртэй өргөн барьсан. Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад үүнийг цөцгийн тосны ферм болж Улсын Их Хурал өөрөө сольж ингэж батлагдсан байгаа. 2022 оноос 2024 онд хэрэгжихдээ энэ төсөл 2024 онд дуусах хугацаатай байсан боловч гүйцэтгэл бүрэн гараагүйгээс 2024 оны батлагдсан санхүүжилтээс 120 сая төгрөгийг татуулчихсан байдаг. Гэрээний үйл үлдэгдэл. Тэгээд 2025 оны төсөв дээр байхгүй учраас гэрээнийх нь үлдэгдлийн санхүүжилт 120 сая төгрөгийг захиалагчийн ирсэн хүсэлтийн дагуу бид нар 2026 оны төсөвт тусгасан байгаа. Тэгээд энэ төсөл бол бүрэн ашиглалтад орсон. Төсөв дээр тавигдсан дүн бол гэрээнийх нь үлдэгдэл санхүүжилт явж байна.

Р.Сэддорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Өглөөний мэнд. Надад Сангийн яам болон Уул уурхайн яаманд асуулт байна. Өчигдөр Засгийн газрын тэр 55 дугаар тогтоол нэлээн яригдлаа. АМНАТ лүү л бид нар гараа дүүрчихлээ л дээ. Энэ АМНАТ гээд яриад байгаа боловч энийг бид нар том зургаар нь харах ёстой юм. АМНАТ гэдэг бол төрийн нийтийн өмч буюу ард түмний өмчийг ашиглаад, түүнд төлж байгаа төлбөр юм. Яг бүх орны жишиг дээр байдаг. Тэр төрд, Сангийн яаманд, Төрийн санд төлөгдсөн нийт АМНАТ-ын 2/3 нь Баялгийн сан руу явдаг шүү. Тэгэхээр чинь бид нар нэг ёсондоо АМНАТ өөрчлөх тоолонд Баялгийн санд орох, Баялгийн сангаар дамжаад 3,5 сая иргэнд очих Ирээдүйн өв санд 65 хувь нь хадгалагддаг энэ мөнгө рүүгээ л дүнг нь өөрчлөөд байна гэсэн үг л юм л даа. Тэгээд энэ дээр нэг тодорхой асуултууд байгаа юм.

Биржийн тухай хуулийг баталснаас хойш биржээр бол бараг 20 гаруй их наяд төгрөгийн арилжаа явагдсан. Нэлээн амжилттай явсан. Уул нь бол. Энэ 55 дугаар тогтоол дээр нийт борлуулж байгаа бүтээгдэхүүнийхээ 25 хувийг гээд заачихсан байна лээ л дээ. Тэгэхээр АМНАТ хэрвээ бид нар өөрчлөх гэж байгаа бол нэлээн тийм бодитой судалгаан дээр үндэслэж заавал хийгдэх ёстой. Яагаад гэвэл энэ дээр хэдэн тэрбумын асуудал яригдана. Дандаа Баялгийн сан руу орох мөнгө л гэсэн үг байхгүй юу. Баялгийн сан руу 65 хувь нь 25 хувийг нь бол буцаадаг төсөв рүүгээ. Тэгэхээр энэ 25 хувь гэдгийг яаж, ямар тооцоолол дээр үндэслэж гаргаж байгаа юм бэ. 1 дүгээрт.

2 дугаарт яагаад энэ тогтоол дээр 12 сарын 31-ээр дуусна гэж байгаа юм. Яагаад 4 сарын хугацаатай нэг туршилтын юм шиг тавьсан юм бэ. Ийм түр зуурын Засгийн газрын тогтоолоор ингэж АМНАТ-ыг өөрчилж болох уу. Энэ бол нэлээн ноцтой санагдаад байна л даа.

2 дугаарт төсвийн хүрээ дээр ч гэсэн, төсвийн төсөөлөл дээр ч гэсэн Оюутолгой төслийн зэс, алтны агуулга сайжрах учраас гээд ер нь бол ДНБ-ий өсөлтийн тооцооллоо хийсэн байна лээ л дээ. Тэгэхээрээ төсөв ч гэсэн эндээс шууд том зургаараа хамаараад явна гэсэн үг. Тэгэхээр 1 тохиолдолд Оюутолгой төслийн зэс, алтны хувь нь сайжрах юм уу. Энэ бол нөгөө Онтрегийн талбай руу малталт ороод, Онтрегийн талбай руу олборлолт хийгдсэн тохиолдолд Оюутолгой төслөөс гарч байгаа зэс, алтны агуулга илүү сайжрах ийм тооцоололтой юм. Онтрегийн талбай дээр байгаа зэс, алтны агуулга Оюутолгой бүлэг ордын хамгийн өндөр нь байхгүй юу. Хамгийн өндөр. Тэгэхээр энэ дээр тооцоолол дээрээ яг ямар агуулгаар хийсэн юм. Онтре дээр бид нар малталт орно. Олборлолт хийгдэнэ гэдэг тооцоолол явсан юм уу. Эсвэл тэр дээр бас яг төрөөс хувь авах дээр юу гэж тооцоолсон бэ.

Р.Сэддорж: Жавхлан сайд Байнгын хорооны ирцдээ ороорой. Шадар сайд ирсэн байна. Жавхлан сайд. Уул уурхайн яам хариулъя. 5 номер.

Б.Дашпүрэв: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Дашпүрэв. Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Хуульд экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн зах зээлийн үнийн эх сурвалжийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана гэдэг ийм хуулийн заалттай. Энэ хуулийнхаа дагуу тогтоолд өөрчлөлт оруулсан. Ер нь Монгол Улсын түрүүн бас Ганбаатар гишүүний асуусан зүйл дээр энэ Биржийн тухай хууль дээр зөвхөн төрийн болон орон нутгийн өмчит компаниуд 100 хувь биржээр арилжаагаа хийх ийм

зохицуулалттай. Үүн дээр бид бүхэн нийтдээ 406 жонш, төмрийн хүдэр, нүүрсний компаниудыг биржээр арилжих, энэ биржийн идэвхжилийг бий болгох зорилгоор хийгдсэн. Үндсэндээ хувийн компаниуд биржийн арилжааны идэвх бол сул байгаа. Тэгэхээр энийг нэмэгдүүлэх хүрээндээ 25 хувь биржээр зарчих юм бол үндсэн АМНАТ-ыг бусдыг бол тооцно гэдэг ийм нөхцөлийг бий болгосон. Ингэснээрээ биржийн арилжааны бол идэвх нэмэгдэж, төрийн компаниуд бол 100 хувь явна. Харин энэ дээр нэмэгдэж хувийн аж ахуйн нэгжүүд орж ирнэ гэдэг ийм тооцооллыг хийсэн. Тухайн үед биржийн энэ асуудал орж ирж байхад Сангийн яамнаас АМНАТ-ийн төлбөр ноогдуулах улсын төсөвт 50 орчим тэрбум төгрөг тасарна гэдэг ийм тооцооллыг гаргаж ирж байсан. Бид бүхэн биржийн арилжааныхаа идэвхжилээр үнэ хаялцуулж байгаа зарчим дээрээ 100 орчим тэрбум төгрөг улсын төсөвт нэмэгдэх боломжтой гэдэг ийм тооцооллыг хийсэн. Өнөөдрийн байдлаар түрүүний хэлсэн дээр 5 сая тонн нүүрс нэмж идэвхжилээрээ олборлосонтой холбогдолтой 80 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлчихсэн байгаа. Жилийн эцсийн гүйцэтгэлээр бид бүхэн 130 тэрбум төгрөг нэмж олох юм байна гэдэг ийм тооцоололтой байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Жавхлан сайд нэмж хариулах уу. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Энэ жилийн хувьд нүүрсний үнэ уначихсан, нүүрсний компаниудын хувьд бас нэлээн том сорилтын жил болж байна. Ер нь бол өрсөлдөх чадвар нь нэлээн суларч ирж байна. Ихэнх үйлдвэрүүд нь нүүрсний уурхайнууд бас хаалгаа барьсан. Салбарын хувьд бол бас хүндхэн жил болж байх шиг байна. 1 дүгээрт.

2 дугаарт бид юуны тулд Үндэсний биржийн тухай хуультай боллоо Уул уурхайн яам. Тэгэхээр энэ уул уурхайн бирж рүүгээ бүрэн шилжих ёстой. Энэ салбарын либералчлах, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр хамгийн том өөрчлөлт бол энэ хууль маань өөрөө. Тийм учраас энэ хуулийг төрийн компаниуд ч тэр, хувийн хэвшлийн компаниудад ч тэр ижилхэн илүү хамрагдах тэр нөхцөл боломжийг нь тавих үүднээс салбарын яамнаас эдгээр саналууд ирсэн байх. Таныг байхад ч гэсэн энэ саналууд бас цуцлагдаж байсан болов уу гэж ингэж бодож байна. Ирээд ингээд тодорхой хэмжээний орлого алдана. .../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя Жавхлан сайд.

Б.Жавхлан: Орлого алдахыг нь бол бид сануулж байсан. Гэхдээ бид энийг идэвхжилээр нь сэргээнэ. Алдаж байгаа орлогоосоо илүү давсан ийм орлого олно гэдгийг бол салбарын яамнаас бол зорьсон. Засгийн газар дээр хэлэлцээд энийг бол шийдвэрийг Засгийн газрын хурлаар гаргасан. Гэхдээ туршилтын хугацаа тавья. 12 сарын 31 хүртэл харъя. Үнэхээр идэвхжил нь цаашаа яг энэ зорьсон үр дүндээ хүрэх юм уу, үгүй юм уу. Хэрвээ салбараас ялангуяа хувийн хэвшлийнхэн энэ хамрагдалтаа нэмэгдүүлэхгүй, орлого нь нэмэгдэж өгөхгүй бол 12 сарын 31-ээс хойш сунгахгүй шүү гэдгийг анхааруулаад, хугацаа тавьсан ийм зохицуулалт. Одоо харин салбарын яамнаас хэлж байгаа энэ үр дүнгүүд нь бол гарч эхэлж байгаа юм байна. 12 сарын 31 хүртэл энэ үр дүн нь баталгаажна гэж ингэж харж байна.

2 дахь нь юу гэлээ. Онтрег яам нь хариулсан нь зөв байх.

Р.Сэддорж: 1 номер.

И.Батхүү: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Бид 2026 оны эдийн засгийн

тооцооллыг хийхдээ ер нь бүх салбараар бодит секторууд дээр хэрэгжих төслүүдийн явц, төлөвлөлт, үүнийгээ хэрэгжүүлэхэд шаардлагатай авах арга хэмжээнүүдийг бүгдийг нь тооцоолж, харгалзаж үзэж байгаа. Таны тухайлан асуусан Оюутолгойн ордын асуудал дээр ч гэсэн ирэх жилүүдэд баяжмалын хэмжээ, алтны агууламж нэмэгдэх тооцооллыг тусгасан. Дээр нь Онтрегийн лицензтэй холбоотой асуудлыг бас оруулж тооцсон байгаа. Засгийн газрын зүгээс байгаа асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллах ёстой. Бүх салбартаа шаардлагатай гэрээ хэлэлцээрийг хийх ёстой, хэлцлийг хийх ёстой гэдэг агуулгаар энэ дээр оруулж ажиллаж байгаа. Ер нь эдийн засгийн өсөлтийн тоонууд маань бас зорилтот түвшин гэж ойлгож байгаа. Шаардлагатай арга хэмжээг авч ажиллах ёстой гэж.

Р.Сэддорж: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Би асуугаад байгаа юм л даа. 25 хувь, 75 яг ямар тооцоолол дээр үндэслэсэн юм бэ гэсэн чинь тооцоолол дээр үндэслэсэн гээд яг ямар тооцоолол байгаа юм. Тэр тооцоолол, тайлан байгаа бол тэрийг хармаар байгаа байхгүй юу. Жишээлбэл Сангийн яамнаас санал өгөхдөө дор хаяж 1/3 нь байх нь зүйтэй гэсэн байна шүү дээ. Тэгэхээр Сангийн яам мэдээж төсвийн тооцооллыг хийгээд 1/3 гэсэн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр Уул уурхайн яам яагаад 25 хувь юм бэ гээд л асуугаад байгаа юм л даа. Яг ямар үндэслэлээр. Ялангуяа АМНАТ дээр бид нар маш тодорхой үндэслэл дээр ийм шийдвэр гаргахгүй бол Сангийн сайд аа, та мэдэж байгаа шүү дээ. АМНАТ бол Баялгийн сан руу орж байгаа үндсэн орлогыг бүрдүүлж байгаа хэлбэр шүү дээ. Төлбөр мөн үү. Тийм учраас үнэхээр тэгвэл тэр 100 тэрбумын нэмэлт ашиг гэдгийг нь би хармаар байгаа юм. Тэр 100 тэрбумын нэмэлт орлого яг хаанаас гараад байгаа юм. Нэмэлт цаг авчихъя.

Р.Сэддорж: Хариулт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам. 5 номер.

Б.Дашпүрэв: Дашпүрэв. Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. 25 хувийг тооцох тооцоолол нь бол ер нь энэ хувийн аж ахуйн нэгжүүд бол биржээр арилжих арилжаа бол үндсэндээ байхгүй. Сул явж байгаа. Тэгээд энэ олон компанийн асуудал. Төрийн өмчит компаниудын хувьд зарим том Тавантолгой, жижиг Тавантолгой 25-аас дээш хувь арилжигдаж байгаа ийм нөхцөл байдал. Тийм учраас ер нь хувийн хэвшлийн биржийн арилжааг идэвхжүүлэх хүрээндээ 25 хувийн гэдэг босгыг тавиад, тэгээд түүнд хүргэх гэдэг нь бол биржийн арилжааг нэмэгдүүлнэ гэдэг ийм зүйл байгаа. Ахиад түрүүний хэлсэн энэ 100 тэрбум төгрөгийн тооцооллыг би тооцоолол нь биржийн арилжааны дуудах босго үнээс дээшээ арилжигдаж байгаа үнийн зөрүү дээр үндэслэсэн тооцоо байгаа. Тэгэхээр нарийвчилсан тооцоо байгаа. Энэ тооцоог тан руу хүргүүлье.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж 1 минут Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: За за. Тооцоолол байхгүй юм байна. Тооцоолол байхгүй байна шүү. Ер нь бол ганц нэг аж ахуйн нэгжүүд 25, 75 гэсэн чинь л 25, 75 гэж би ойлголоо. Тооцоолол байгаа бол надад албан ёсоор бичгээр өгөөрэй. Яг тэр тооцоолол, ямар тайлан үндэслэл дээр гарсан юм. Яагаад Сангийн яамны 1/3 гэдэг нь худлаа гэж та нар баталсан юм. Тэрийг заавал хармаар байна. Тэгээд алдагдлын тооцоолол болон бас нэмэлт орлогын тооцооллыг харъя. Энэ бол ноцтой зүйл шүү. Та нар баялгийн сан руу гар хүрлээ шүү. 3,5 сая иргэнд оногдох АМНАТ дээр гар хүрлээ шүү. Зүгээр 1 татвар биш шүү энэ бол. Зүгээр нэг татварын асуудал биш. Тэгээд Онтре дээр бол та нар тооцоолол хийчихсэн гэж байна шүү дээ. Тэгэхээр тэр

дээр 34 хувь авна гэсэн юм уу, АМНАТ-аар орлуулна гэсэн юм уу. Энэ үндэслэлээ Улсын Их Хурлаар батлаагүй байж байхад яг ямар тооцоолол дээр үндэслээд тэр эдийн засгийн өсөлт рүү орчхов гэж би асуугаад байгаа юм л даа. Бас дахиад тэр дээр яг ямар тооцооллоор 5,6 гэсэн эдийн засгийн өсөлт рүү орсон бэ гэдэг л асуулт асуугаад байгаа юм л даа. Тэрийг яг тооцооллоо хэлмээр байна. Тооцоололтой юм уу. Энэ Эдийн засгийн байнгын хороо шүү дээ.

Р.Сэддорж: 5 номер тодорхой хариулаарай.

Б.Дашпүрэв: Нарийвчилсан тооцоог гишүүнд хүргүүлье. Байгаа.

Р.Сэддорж: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: 2026 оны төсөв дээр иргэдийн зүгээс, төрийн албан хаагчдын зүгээс хамгийн их бухимдаж байгаа нь цалин огт нэмэгдэлгүй байна. Дээрээс нь нэмээд ахмадуудын асуудал бас хүндэрч байна. Та бүхэн сайн мэдэж байгаа. Тэгээд харахаар ямар их зардал, ямар сонин категори дээр ямар их нэмэгдсэн юм бэ. Жишээлбэл, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд дээр байр ашиглалтын зардал 166,3 хувиар нэмэгджээ. Эвэл байрныхаа хэмжээг томруулах гэж байгаа юм уу. Эсвэл энэ урсгал зардлууд угаасаа үнийн өсөлттэй холбоотойгоор өсөж байгаа юм уу. Хэрвээ тийм байгаа бол яг ийм ачаалал иргэдийн нуруун дээр яг адилхан ирж байгаа. Тэгвэл яагаад ийм хувиар төрийн албан хаагчдынхаа цалинг нэмэгдүүлж болохгүй байгаа юм. Тогны үнэ, усны үнэ, цэвэр бохирын үнэ бүгдээрээ л адилхан иргэдийн нуруун дээр ч гэсэн ийм хувиар нэмэгдэж орж ирэх байх. Ирэх жил.

Ингээд дахиад л дээрээс нь нэмээд бараа үйлчилгээний бусад зардал гэдэг зардал бараг бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр маш их нэмэгдсэн байна. 1 удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал гэж энэ тэтгэвэрт гарахад олгодог 1 удаагийн 36 сарын тэтгэмж биш шүү. Энэ гэхэд жишээлбэл Эдийн засаг, хөгжлийн яаман дээр яагаад 686,2 хувиар нэмэгдэж байгаа юм. 6 дахин бараг 7 дахин яагаад нэмэгдэж байгаа юм. Дээрээс нь нэмээд төрийн албан хаагчдынхаа цалинг нэмж чадахгүй байж байж, боловсролын салбар дээрээ олигтой ахиц дэвшил гаргаж чадахгүй байж байж ирэх жил 1 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж авах зайлшгүй хэрэгцээ шаардлага энэ Засгийн газарт байгаа юм уу. Үүнийг энэ Эдийн засаг, хөгжлийн яамныхан байдаг юм уу, Сангийн яамныхан та бүхэн хариулаач.

Ахиад дээрээс нь нэмээд Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төсөв 60 орчим тэрбум төгрөгөөр өнгөрсөн жилээс ахиад нэмэгдсэн байна. Түүн дээр маш сонин зардлууд их нэмэгдсэн байгаа юм. Судалгаа хөгжүүлэлт гэдэг зардал жишээлбэл өмнө нь огт байхгүй байсан. Одоо нэмэгдсэн байна. Татаас гэхэд нийтдээ 1,6 тэрбум байсан 31 тэрбум, 32 тэрбум төгрөг болж нэмэгджээ. Тэгснээ ингэж байгаа. Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас гэж байгаа юм. Хэрвээ хувийн хэвслээр гүйцэтгүүлэх гэж байгаа бол сайн байна. Тэгвэл бид нарын өөрсдийн төрийн албан хаагчдын цалин, үйл ажиллагааны зардал энэ хэмжээгээрээ бас буурах ёстой биз дээ. Төр өөрөөр хэлбэл өөрөө хийхгүй ажлаа бусдаар хийлгүүлье гэж би ойлгож байгаа шүү дээ энийг.

Нөгөөдөх нь ахиад төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал. Энэ ямар тэтгэмж, ямар урамшуулал олгох гээд байгаа юм. Одоо уг нь халамжийг чинь Халамжийн яам нь халамжийнхаа хуулиар олгодог байсан чинь одоо сүүлдээ яам

болгон халамжийн яам болох гээд байгаа юм уу. Энэ яг ямар учиртай юм. 18,4 хувиар нэмэгдсэн байна гэнэ.

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын шууд гэдэг нь яагаад 13 бараг 14 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн юм бэ. Энэ шууд зардал гэдэг нь яг юу юм. Үүнийг бас асууя.

Р.Сэддорж: Хариулт. Сангийн яам. 5 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төсвийн зарлагатай холбоотойгоор бол хэд хэдэн өөрчлөлтүүдийг 2026 оны төсвийн төсөлтэй хамт оруулж ирсэн байгаа. Энэ нь бол Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг дээр мөн нэлээд бас яригдаж орж ирсэн. Энд 1 дүгээрт бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж гээд хэт ерөнхий эдийн засгийн ангилал байна. Энэ дотор маш олон төрлийн зардлууд байгаад байна. Үүнээсээ бас ингээд элдвийн зардал гарч байгаа нь яг цэгцтэй зардал биш байгаа нь бол өөрөө аудитаар зөрчил үүсгэх, дараа нь төсвийн сахилга баттай холбоотой байна гэдэг ийм асуудал гараад, Улсын Их Хурлаас 52, 54 дүгээр тогтоолоор гарсны дагуу энэ зардлыг бол бид нар нарийвчилсан. Нарийвчлахдаа бол сүүлийн 3 жилийн хугацаанд байгаа нийтдээ 4 сая орчим гүйлгээг бид нар шалгаж үзээд, энэ зардлуудаас ер нь ямар зардлууд гарч байна гээд үзсэн. Жишээ нь байр ашиглалттай холбоотой зардал буюу харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний зардлыг энэ зардлаас гаргаж байсныг бол тусгайлан зориулалтыг нь гаргаж өгөөд, энэ зардал дээр тавьсан байгаа. Тэгэхээр явчихсан.

Мөн зарим зардлууд энэ нарийвчлах асуудлын хүрээнд 7 эдийн засгийн ангилал бол шинээр нэмж тавьсан байгаа. Яг таны тусгайлан асуусан тэр асуултууд дээр байгаа жишээ нь төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал дээр юу байгаад байна вэ гэхээр Боловсролын зээлийн сангаас олгож байгаа энэ тэтгэмжийн зардлууд байгаа. Та Боловсролын зээлийн сан дээр байгаа зардлыг харсан болов уу гэж бодож байна. Энэ дээрээс бол тэтгэмжийн зардлууд орж ирдэг. Түүнчлэн яг эдийн засгийн 2026 онд мөн аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх онцлох арга хэмжээ гээд бид нар бол Соёлын сайд дээр хүүгийн татаас бол тавьсан байгаа. Энэ нь бол урьд өмнө тавигдаж байгаагүй зардал бол туссан. Энэ хэмжээгээр 23,1 тэрбум төгрөг бол Соёлын сайд дээр шууд дээр нэмэгдэж орж ирсэн байгаа. Мөн түрүүн тусгайлан асуусан тэр судалгаа хөгжүүлэлтийн зардал гэдэг нь эдийн засгийн ангиллын түрүүний бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг задалж, тусгайлан тавьсантай холбоотойгоор шинэ ангилал гарсан. Тэгэхээр өмнөх он дээр бол энэ эдийн засгийн ангилал дээр зардал байхгүй байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл нөгөө зардлаасаа хасагдаад, энэ дээр тусгайлан орж ирсэн байгаад байгаа.

Эдийн засгийн ангиллын бас нэг түрүүний асуусан асуулт дээр 1 удаагийн тэтгэмж гэдэг халамжаас бол тусдаа зардал байгаад байдаг. 1 удаагийн тэтгэмж гэдэг дээр Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нөгөө түлээ нүүрсний тэтгэмж олгох, байгууллагаас нөгөө нас барахаар буяны ажилд зарцуулан гаргах гэх мэт яг ийм зардлууд бол тухайн байгууллагаасаа тэр үйлдвэрчний эвлэлтэйгээ байгуулсан гэрээний хүрээнд гарах ёстой зардлууд бол энэ зардал дээр гардаг байгаад байгаа.

Мөн нөгөө алдар цолтон ахмадуудад бол төрөөс бол нэмэгдэл хөнгөлөлт олгох тухай хуулийн дагуу ахмадыгаа хүлээж авах зардлууд байна.

Р.Сэддорж: Булгантуяа гишүүн. Сангийн яам нэмж хариулъя гэж байна. 6 номер 1 минут.

Ж.Дэлгэржаргал: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр эдийн засгийн ангиллын хувьд тоног төхөөрөмж нийтдээ 482 тэрбумаар санхүүжихээр өргөн барьсан. Тэгээд хөрөнгө оруулалтын зардлын хувьд бол тогтмол зардал биш учраас яг хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлж ингэж тусгадаг. 6 салбар дээр ер нь хамгийн өндөр байгаа. Коп-ийн хуралтай холбоотой Байгаль орчны сайдын 91 тэрбум, боловсрол, сургууль цэцэрлэгтэй холбоотой тоног төхөөрөмж 56 тэрбум, эрүүл мэндийн салбар, мэс заслын тоног төхөөрөмж, оношилгоотой холбоотой 49 тэрбум, тэгээд батлан хамгаалах, хууль зүй, цахим гэсэн ийм 6 салбар дээр бол тоног төхөөрөмж өндөр байгаа.

Р.Сэддорж: Булгантуяа гишүүн тодруулж асууя.

Х.Булгантуяа: Тэгвэл жишээлбэл Эдийн засаг, хөгжлийн сайд дээр өнгөрсөн жилтэй харьцуулах юм бол 7 дахин олон ахмадууд нь албан хаагчид нь нүүрс түлэх юм байна. Эсвэл нас барахад олгох тэтгэмж нэмэгдэж байгаа эсвэл нас барах хүмүүсийнх нь тоо нэмэгдэж байгаа гэж байгаа юм уу. Ийм нэг утгагүй зардлуудаа л хэмнэж уг нь бид нар төрийн албан хаагчдынхаа цалинг тавимаар байгаа юм л даа. Одоо нэг ийм юу харагдаад байх юм. Та бүхэн анзаараач. Бид нар зам шинээр барихаа бол огцом нэмж байгаа мөртөө машин унах иргэдийн хүслийг бууруулмаар байна гээд байгаа юм. Тэгээд машины импортын онцгой албан татварыг нэмээд, хэрэглээний зээлийг нь хязгаарлаад байгаа мөртөө зам бариад байдаг. Хэрвээ машин унахыг нь хязгаарлах гэж байгаа юм бол нөгөө талдаа машины импортыг хязгаарлах гэж байгаа юм бол зам барьж яах юм. Тэр зам дээгүүр чинь машинаар л явна биз дээ. Бид нар гүйхгүй нь ойлгомжтой юм чинь. Энэ 2 чинь утга учрын хувьд логикийн хувьд 1 дүгээрт болж байгаа юм уу. 2 дугаарт .../минут дуусав/

Р.Сэддорж: 1 номер хариулъя.

И.Батхүү: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулийн өөрчлөлтийг дагаад шинжлэх ухааны салбар хуучин Боловсролын сайдын багцад шилжиж ирсэн байгаа. Энэ салбарт дагаад бараг 2000 орчим орон тоотой эрдэмтэн судлаачид шинжлэх ухааны ажилтнууд байж байгаа. Энэ хүмүүсийг ажиллах нөхцөл бололцоог нь хуучин түвшинд нь хадгалах, нийгмийн асуудлын холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй байгаа. Яг багш ажилтан, эмч гэж хэлэхээс гадна бас шинжлэх ухааны салбарын ажилчдын хуулиар олгогдсон эрх үүргийг бид бас хамгаалах үүрэгтэй. Түүнтэй холбогдох зардлууд нь байж байгаа. Тэр байрны түрээсийн асуудал нь ч гэсэн яг адилхан энэ олон Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд 32 байгууллага байгаа. Холбогдох хүрээлэн академи гээд энэ байгууллагуудын түрээсийн зардлууд тийшээ шилжиж орж ирсэнтэй холбоотой өсөж харагдсан байгаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж 1 минут авах эрхтэй. Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Эдийн засгийн байнгын хороо дээр бол манай Улсын Их Хурлын гишүүд их ач холбогдол өгч оролцож байна. Сайд нараас 3 сайд байх шиг байна. Бусад нь бол байхгүй байна. Эдийн засгийн байнгын хороо дээр чинь харьяалагддаг бараг хэдэн сайд байгаа билээ. Бараг 10-аад сайд байх ёстой. Дээрээс нь нэмээд нөгөө хамгийн том Эдийн засгийн байнгын хорооноос төсвөө батлуулж, энд хянуулах ёстой хамгийн том төсвийн ерөнхийлөн захирагч нар нь өөрсдөө байхгүй байна шүү. Хэдүүлээ яг ийм байдлаар төсөв ярих юм бол одоо нөгөө иргэдийн бухимдаад байгаа өвөл болох гээд байдаг, хүйтрэх гээд байдаг, 2026 он гарах гээд байдаг, төсвөө яримаар байдаг. Бид нарын татварын мөнгийг яаж зарцуулах гээд байна гээд иргэд бухимдаад байдаг. Энэ бүгд дээр аль аль талаасаа л ач холбогдол өгмөөр байна. Төрийн албан хаагчид харин манай төрийн захиргааны яам, Тамгын газрынхан бол бүгдээрээ их ач холбогдол өгч оролцсон байна. Тэгээд та бүхэн маань ийм их мөнгийг ирэх жил татвараас авч зарцуулах гэж байгаа дээр аль аль талаас нь ач холбогдол өгөөч ээ гэж хүсэж байна.

Р.Сэддорж: Сангийн яам 1 тооцоо бодож байгаарай. Үдийн цай хөтөлбөр чинь 1-5-д өгч байгаа тийм ээ. Тэгээд цалин тэтгэвэр нэмсэнтэй яг адилхан зүйл бол энэ үдийн цай байхгүй юу. Үдийн цайгаа өгдөггүй улс орнууд ер нь манай Монгол, өөр ямар орнууд байдаг юм бол. Тэгээд 6-12 дугаар ангид өгөхөд хэдэн төгрөг болох вэ гээд би гишүүдийн дараа асуух гээд байгаа юм. Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Өдрийн мэнд хүргэе. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо дээр Монгол Улсын эдийн засгийг бүхэлд нь харж ярьж байгаа. Тэгээд бид Монгол Улсынхаа эдийн засгийг одоо байгаагаас нь 3 дахин нэмэгдүүлье гээд л 2024-2028 оны хөтөлбөрийг гаргасан шүү дээ. Ингэж яриад л бид нар эдийн засгаа солонгоруулъя. 14 мега төслийг явуулж байж, 1 хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянга руу дөхүүлье л гэж бид нар зорилт тавиад явсан шүү дээ. Одоо үүнийхээ талаар ярьж байгаа хүмүүс бүр байхгүй болчихсон. Тэгээд Тэргүүн Шадар сайд байж байгаад түрүүн гараад явчихлаа. Эрэмбэлнэ, эрэмбэлнэ л гээд байгаа юм. Хэзээ эрэмбэлж дуусаад, хэзээ бид нарт танилцуулаад, хэзээ үр дүн гаргах гээд байгаа юм.

Аж үйлдвэржилтийн байнгын хороонд би ажиллаж байсан. Одоо Эдийн засгийн байнгын хороонд орж ирж байгаа. Манай Байнгын хорооноос ажлын хэсэг гаргасан. Ялангуяа энэ 14 мега төсөлтэй холбоотой эдийн засагт үр өгөөж өгөх Аж үйлдвэрийн парктэй холбоотой. Би дэд ажлын хэсэг Гангийн үйлдвэр сэргээгдэх сэргээгдэх эрчим хүч буюу тархмал эх үүсвэрийг хариуцан ажиллаж байгаа. Монгол Улсад ган хэрэгтэй хэрэгтэй гээд байдаг Монгол Улсын гангийн үйлдвэрийг бүгдийг нь гацаачихсан. Орж ирсэн хувийн хэвшлүүдийг нь хөөгөөд нийлээд явуулчихсан. 2, 3 Засгийн газрын тогтоол байна лээ. 2, 3 материалтай бүгдтэй нь танилцаж байгаа. Тэгээд хувийн хэвшлээ дэмжихгүй яаж энэ эдийн засгаа солонгоруулах гээд байгаа юм. Тэгээд энэ Гангийн үйлдвэрийн эрэмбийнх нь хэдэд нь байгаа юм. Асуумаар байгаад байгаа юм.

2 дугаарт сэргээгдэх эрчим хүч буюу бүсчилсэн маягаар хөгжье л гэсэн. Хангайн бүсэд юу байгаа юм, давуу тал юу байгаа юм бэ. Түүгээрээ хөгжье гэсэн. Говийн бүсэд давуу тал юу байгаа юм бэ. Түүгээрээ хөгжье гэсэн. Тэгээд тэрнийх нь суурь нь эрчим хүч. Тэгээд энэ тархмал эх үүсвэр дээр чинь ямар бодлогоор аль аймагт ямар эрчим хүчний бодлого яваад байна гэхээр байхгүй. Материал байхгүй шүү. Тэгээд энэ цаашаа тэгээд бид нар яаж хөгжих юм. Одоо 2026 оны улсын төсөв МАН-ынхан дотроо хөлөө жийлцээд, 2, 3 хэд хуваагдчихсан юм мэдэхгүй. 1 нь гарч ирээд яриад улсын төсөв улайчихлаа гэдэг, араас нь 1 нь гарч ирж яриад мөнгө байгаа шүү гээд байдаг. Мөнгө байгаа юм бол энэ талбай дээр жагсаж байгаа багш

нарынхаа цалинг нэм л дээ. Яг иргэдэд улаан нүүрээ үйлчилж байгаа тэр цагдаа нар, эмч нар цалинг нь нэмье л дээ. Нийгмийн даатгалын сан гээд жил болгон ярьдаг. Ирээдүйнхээ мөнгийг идээд дуусгалаа гээд л ярьдаг. Ямар реформын шинжтэй өөрчлөлт бодлогын өөрчлөлт оруулж ирж байгаа юм бэ. Орж ирж байгаа юм ерөөсөө харагдахгүй байгаад байна. Эрүүл мэндийн даатгалын сан гээд бүгд ярьдаг. 1 хэсэг нь болохоор гүйцэтгэлээр үнэлгээ хийгээд явж байгаа нь буруу болчихлоо гээд байдаг. 1 нь зөв гээд байдаг. Энэ дээрээ дүгнэлт гаргаад, хэдүүлээ бодлогын шийдвэрүүдээ гаргаад явмаар байна. Бүх юм гаднын зээл, тусламж болсон. Одоо үүний ар дээрээс бид нар дахиад 475 сая долларын зээл, тусламжийн гэрээг ярих гэж байна. Монгол Улс өөрсдөө хөгжиж болохгүй юм уу. Энэ гишүүдийн яриад байгаа зардлаа тана л даа. Зөв хөрөнгө оруулалтууд руугаа бодлогоор дэмж л дээ. Инфляцаа бууруулъя гээд байгаа юм. Зөв. 1 минутаа нэмээд авъя.

Р.Сэддорж: 1 минут.

Г.Очирбат: Эдийн засгаа тэлж, инфляцаа бууруулъя гээд байгаа нь зөв. Тэгвэл одоо хөтөлбөрүүдийнхээ үр дүнг ярья л даа. Хэдүүлээ сүүлийн 3 жил, 4, 5 жил бараг энэ хүнсний хувьсгал гээд явсан. Яг инфляцад яаж нөлөөлсөн юм. Тэгвэл махны ханш өнөөдөр хэдэн төгрөгөөр буураад, инфляцад хэдэн хувь нөлөөлчхөөд байгаа юм. Гурил гээд л түрүүн ярьсан. Аж үйлдвэрийнх нь салбарыг дэмжих гээд байгаа юм шиг, татан буулгах гээд байгаа ч юм шиг явсан. Ямар үр дүн гарсан юм. Хэдэн компанид нь ямар зээл өгөөд, тэндээс нь бодлогын ямар үр дүн гарсан юм. Газар тариалангийн салбарт ямар үр дүн гарсан юм. Цагаан алт гээд ярьсан. Өчнөөн тэрбум төгрөг зарцуулсан. Шинэ хоршоо гээд сонгуулийн өмнөхөн яваад л хэдэн 100 сая, хэдэн 100 тэрбумаар л зарцуулсан. Одоо үр дүнгээ тэгвэл ярья л даа. Эдийн засагт яг ингэж нөлөөлөөд, инфляц буучихсан, инфляц буучихсан болохоор олон улсын байгууллагууд бид нарыг дахиад зээлжих зэрэглэл өссөн байна гэдэг тоон утгаар нь хэдүүлээ ярья. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо л энэ Монгол Улсын эдийн засгийг бүгд сууриар нь харж байгаа.

Р.Сэддорж: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Би тэр төрийн сантай холбоотой хэсгийг нь хариулъя. Бусад нь яамнууд хариулна биз. 2025 оны батлагдсан төсвийн жил 3 дахь улирал дээрээ явж байна. Жилийн дундуур тодотгол хийсэн. Одоо ямар ч байсан бид орлогынхоо хэмжээнд энэ жилийн төсөвлөсөн бүх төрийн санхүүжилтийг саадгүй хийгээд явж байна. Би энэ талаар албан ёсоор мэдэгдсэн. Одоо бид нар 2026 оны төсөв ярьж байна. Цалин мөнгө нэмэгдэх асуудал бол 2026 оны төсөвтэй холбоотой шүү. Энэ жилийнхээ хэдүүлээ ямар ч байсан цалин, төсөв мөнгө, тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн мөнгө бүхий л зардлууд, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бүрэн санхүүжилтээ аваад, тодотголын дараах төсвөөрөө явж байна. Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, Хөдөө аж ахуйн салбарын эрчим хүчний салбарын асуултууд байсан. Тэрийг Эдийн засаг хөгжлийн яам буюу бусад холбогдох сайд нар хариулна биз ээ.

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байна уу. 1 номер.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батхүү. Очирбат гишүүний зарим асуултад нь хариулъя. 14 мега төслийг бол зогсоосон, хойшлуулсан зүйл байхгүй. Төсөл бүр өөрийн онцлогтой. Гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжих, гаднын зээлээр санхүүжих гэх мэтчилэн янз янз байгаа. Одоогийн байдлаар эх үүсвэр нь баталгаажсан Эрдэнэбүрэнгийн УЦС, Ураны төсөл

гэх мэтчилэн төслүүд явж байна. Төсөл бүрийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг мөнгөн хөрөнгийн урсгал, санхүүжилтийнх нь дүнгээр ирээдүйн ирэх жилүүдийн тооцоолол нь бас бид авч үзэж байгаа. Энэ мега төслүүдийн 1 онцлог нь бол яг улсын төсвөөс шууд санхүүжүүлэх биш гаднын шууд хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалт, гаднын зээл нь бол төлбөрийн тэнцэлд үзүүлэх нөлөөлөл нь багатай. Эх үүсвэр нь гадаад валютаар хэрэгжилтийнхээ дагуу орж ирэх учраас тийм юм байгаа юм. Ер нь хэрэгжихэд бэлэн байдал гэсэн байдлаар 4 чиглэлээр бас эрэмбийг нь тооцоолоод гаргасан байгаа. Энэ төсөл бүр дээр дэлгэрэнгүй мэдээлэл байгаа. .../минут дуусав/

Р.Сэддорж: Очирбат гишүүн 1 минут авах уу. Очирбат гишүүн хариулт хангалтгүй гэж үзвэл 1 минутын эрхтэй.

Г.Очирбат: Тодорхой хариулъя. Яг Гангийн үйлдвэр хийж чадна, чадахгүй. Эрэмбийн 14-ийн төдөд байгаа. Тэдэн сарын тэдэнд энэ дуусна. Хувийн хэвшлээр хийлгэнэ, үгүй бол төрийн өмчит компани хийнэ. Тэр байтугай бүр Дарханыхан чинь Иргэдийн хурал нь хүртэл Аж үйлдвэрийн паркт нь газар өгөхгүй гэсэн мэдээлэл, тэр бичлэг хүртэл байлаа шүү. Энийгээ маш тодорхой болгомоор байна. Тэгээд Эдийн засгийн байнгын хороо дээр Монгол Улсын бодлого мөнгөний бүх талаар нь харж байгаа Байнгын хороо. Тэгэхээр энэ дээрээ маш тодорхой яг энэ инфляц руу онилсон ийм ийм арга хэмжээ хийгээд инфляц буурчихсан байна буюу тэр инфляцад нөлөөлдөг сагсан дахь нэр төрлийн бараа бүтээгдэхүүний эхний 20-д нь ингэж нөлөөлсөн байна. Бодлогоор бид нар энэ энийг татвараас хөнгөлөөд, эд нар нь дотоодын үйлдвэрлэл болоод, өртөг багасаад инфляцад ингэж нөлөөлсөн байна гээд тодорхой хариулаад өгмөөр байна.

Р.Сэддорж: 1 номер.

И.Батхүү: Энэ хөгжлийн төслүүдийг 14 мега төслөөр эрэмбэлээд, хэрэгжиж эхэлсэн төсөл 4 байна. Ач холбогдол өндөр төсөл гээд 5 төсөл байгаа. Энэ дотор нь гангийн цогцолбор гээд 2,2 их наяд төгрөгөөр хэрэгжүүлэхээр яг энэ төслийн бэлтгэл ажил холбогдох бэлэн байдлыг хангах чиглэлээр “Эрдэнэс Монгол” компани Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяанд ажиллаж байгаа. Төслийн бэлэн байдал мега төсөл маань өөрөө олон хүчин зүйлээс шалтгаалдаг учраас хэзээ яг эхлээд, хэзээ дуусах вэ гэдэг дээр тодорхой огноо дээр нь холбогдох байгууллагуудад нь мэдээлэл хүргүүлнэ.

Р.Сэддорж: Дууссан. 2 минут авчихсан. Эдийн засаг, хөгжлийн яам Очирбат гишүүнд яг энэ асуугаад байгаа хариултыг нь уулзаад, бичгээр өгчих. Энэ бараг жил гаруйхны өмнө л баталсан юмыг л асуугаад байна шүү дээ. Эрэмбэлсэн 14 мега төслөө баталсан. Энийг л асуугаад байна. Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн.

Э.Одбаяр: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд 2026 онд Монгол Улс хаанаас хэдийг олж, хаана хэдийг зарах вэ гэдэг төсвийн тухай асуудлаа хэлэлцэж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд хэлэлцүүлгийн үйл явцыг харж байхад данхар төр гэж яг энийг хэлээд байгаа юм. Тойроод баахан төрийн албан хаагч нар. Тоон дотроо төөрөөд, утсаа маажаад сууж байдаг. Яг хариуцлага хүлээх төсвийн ерөнхийлөн захирагч нар буюу сайд нар нь болохоор улс төрдөө толгой нь эргээд, хүзүүгээ маажаад сууж байдаг. Тэгээд өнгөрсөн 7 хоногт манай Ардчилсан намын бүлэг хуралдаад энэ төсөв чинь эзэнгүй болчихлоо. Энийгээ буцаагаад татаач ээ гэсэн. Агуулга нь. Тэгээд 2025 оны төсвийг боосон хүмүүс энд бараг бүгдээрээ сууцгааж байна л даа. Дараагийнхаа засагт орчихсон. Тэгээд өнгөрсөн жилээс

хөнжлийнхөө хэрээр хөлөө жий гэдэг уриатай, өөрөөр хэлбэл нэг тийм орлого, зарлага 2 нь мөргөж байя гэдэг тэр концепцоор энэ төсөв батлагдаж байгаа гэж ойлгосон. Тэгээд тестлээд байгаа юм уу, янзыг нь үзээд байгаа юм уу, Их Хурал нь буцаах юм уу, Ерөнхийлөгч нь хориг тавих юм уу юу ч гэсэн 1,3 их наядын алдагдалтай төсөв оруулаад үзье дээ гэдэг байдлаар асуудалд хандчихсан. Яг тойрохоор энд Санжаадорж, Дэлгэржаргал 2 л нөүтбүүк ухаад сууж байгаа. Утас нь бүгд утсаа ухаад, хов сонсоод л байж байгаа хүмүүс байхгүй юу.

Тэгээд нийгэмд хүлээлт үүсэх ёстой. 2026 онд Их Хурлаас баталж байгаа Засгийн газрын өргөн барьж байгаа төсвөөс бидний энэ асуудлыг шийдэх юм байна гэдэг 1 сэдэв, 1 хүлээлт байх ёстой гэж би ойлгодог. Гадаа гудамд жагсаж байгаа багш нарыг би уйдсандаа сууж байна гэж би ойлгохгүй байгаа. Яах аргагүй 2026 оныг Боловсролын хөгжлийг дэмжих жил болгож зарлая гэдэг шийдэл гаргаад, Засгийн газрын тогтоол гаргаж байсан гэж ойлгож байгаа. Тэгээд ядаж ирэх жилдээ энэ сургууль, цэцэрлэгийн хүртээмж, багш нарынхаа нийгмийн асуудлыг шийдэх концепцоо энэ төсөв рүүгээ оруулаад ир л дээ. Яг гудамд жагсаж байгаа хүмүүсийн улс төрийн зорилготой шийдэж байгаа мессежийг бүгдээрээ, бид нар манай энэ ордонд хамт сууж байгаа хүмүүс бүгд маш соргоогоор хүлээж авдаг, энэ тэрийг огцор гэнэ, тэр тэг гэнэ гэдгийг маш сайн ойлгодог. Яг бидний энэ асуудлыг шийдээд өгөөч ээ гэхээр сонссон ч сонсоогүй царайлаад кармандаа гараа хийгээд алхчихдаг. Энэ боловсролынхоо асуудлыг нэг шийдээч ээ. Багш нарынхаа энэ цалинг нь, авдаг юмыг нь дээшлүүлж байж хүүхдүүд чинь бас нэг хичээл зүтгэлтэй эрдэм ном түгээх ажлыг хийнэ шүү дээ. Тэгээд 1 асуудлаа 1 жилдээ барьж аваад шийдье гэж бодохгүй. Задгай ...1 минутаа авчихъя Сэддорж дарга аа.

Р.Сэддорж: 1 минут Одбаяр гишүүн.

Э.Одбаяр: Тэгээд одоо хэдүүлээ нэг хэсэг нь хэлэлцүүлсэн болоод, нэг хэсэг нь хэлэлцсэн болоод ийм жүжиг тавиад, төрийн албан хаагчид нь энэ жүжгийн олны хэсэгт нь тоглоод, яг яс юман дээрээ эзэн байхгүй энэ төсөвт. Яг эцсийн хариуцлага хүлээх ч хүн байхгүй. Бие биеийнхээ цагийг үрэхээ больё л гэж байгаа юм. Бодитой байя, прагматик байя. Ер нь бол бид нарын энэ байдалд л хүмүүс уурлаад байгаа шүү дээ. Ажлын арга барилаа өөрчилье. Жоохон амьдралтай байя. Төсөв боловсруулахдаа, төсвөө төлөвлөхдөө, төлөвлөгөөгөө гаргахдаа зөвхөн тэр ахиад сонгогдох тэр хүслээ жоохон хойш нь тавиад, яг амьдрал ахуйд нь хэрэг болох хүмүүсийнхээ асуудлыг 1, 1-ээр нь бүгдийг нь биш юм гэхэд 1, 1-ээр нь шийдье гэдэг тэр хүлээлт л байгаа. Тэгээд тэрэнд зориулсан нэг ширхэг хөрөнгө оруулалт, нэг ширхэг асуудал, шийдэл харагдаагүй. Тэгэхээр асуулт бол асуугаагүй шүү. Хариулт авах сонирхол алга. Тэгэхээр ер нь .../минут дуусав/

Р.Сэддорж: Үг хэллээ. Цэндийн Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Бүгдээрэнд нь өдрийн мэндийг хүргэе. Төсөв тоогоор илэрхийлж байгаа. Хөгжлийн бодлого зөвхөн 1 жилийн юм уу, хагас жилийн тоонуудыг яриад баймааргүй байгаа. Засгийн газар бол ирэх жилүүдэд яах вэ гэдэг тэр төсвийн төсөөллөө хүрээний мэдэгдэл дээр их тодорхой танилцуулах хэрэгтэй. Өнөөдрийн төсвийн хэлэлцүүлэг бол төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвөө танилцуулж байна гэж ойлгож байгаа. Төсвөө танилцуулж байна гэж ойлгож байгаа. Зарчмын зөрүүтэй санал бол 3 дугаар хэлэлцүүлэг дээр явна гэж ийм дэгтэй, ийм журамтай. Тэгээд энэ жилийн төсвийн онцлог бол эдийн засгийн өсөлтийн төсөв биш хэрэглээний төсөв, барилга байгууламжийн төсөв, авто замын төсөв болжээ. Уг нь бол боловсролын жил болгож зарласан бүх яам барилга барьдаг энэ ажил руу

уралдаж байгаа юм байна. Боловсролын яам энэ жил хамгийн их барилга барих юм байна. Байгууламж барих юм байна. Ийм төсөв болжээ. Би 2 зүйлийг тодорхой асуумаар байгаад байгаа юм.

Азийн хөгжлийн банкны зээлээр сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг дээшлүүлэхээр зээл авч байгаа юм байна. Тэгээд энэ барилга байгууламжийг яг ачааллыг нь аваад үзэх юм бол ачаалал багатай газруудад барихаар төлөвлөсөн юм байна. Ачааллынхаа шинжилгээг яг ямар аргаар хийсэн юм бэ. Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг 2 бол хамгийн их ачаалалтай байгаа шүү дээ. Цаашдаа ойрын 5 жилд энэ ачаалал нэмэгдэхээр байгаа шүү дээ. Нэг сургууль барина гэдэг бол 70 жилийн настай, 100 жилийн настай ийм байгууламж байдаг шүү дээ. Тэгэхээр энэ урт хугацаандаа энэ ачааллын шинжилгээгээ хийсэн юм уу. Эсвэл Улсын Их Хурлын гишүүдийн тойргийн төлөөх уралдаанаар энэ барилга байгууламжийнхаа газар зүйн байршлыг тавьчихсан юм уу. Энэ дээр хэлж өгөөч.

2 дугаарт энэ татварын хөнгөлөлтүүдээ яаж тусгаж байгаа юм. Манай энэ цахим хөгжлийн салбарынхан инновац IT-ийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа start up-уудад татварын хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн буцаалт өгөх гэж байгаа шүү дээ. Хууль нь батлагдчихсан. Засгийн газраар журам нь батлагдчихсан. Тэгээд маш олон салбарт хүлээлт байгаад байдаг. Залуучуудаа дэмжье гээд байдаг. Сангийн яам яг энийгээ шийдсэн юм уу. Төсөвлөж оруулж ирсэн юм уу. Энийг тодорхой хариулж өгөөч.

3 дугаарт нь эдийн засгийн нөхцөл байдлын асуудлаар Улсын Их Хурлын гишүүд, зарим гишүүд хэтэрхий улс төржсөн мэдэгдэл хийж байгаа чинь энэ гадаад харилцаа талдаа нөлөөлнө шүү дээ. Өчигдөр бол 2 өөр байр суурь ... /минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут Баатархүү гишүүн.

Ц.Баатархүү: Улсын төсөв бол улайсан байгаа. Цалин тэтгэврээ бол тавьж чадахгүй хэмжээнд очсон гэж байгаа юм. Нэг хэсэг нь бол болж байна гээд байх юм. Тэгээд энэ Эдийн засгийн байнгын хороон дээр энийг ярихгүй бол өөр хаана ярих юм. Нөхцөл байдал чинь яг ямар байгаа юм бэ. Энийгээ тодорхой хэлээч ээ.

Хамгийн сүүлд нь улсын төсвөөр бүх юмыг шийднэ гэдэг энэ хандлагыг өөрчилмөөр байна. Хөгжлийн санг амилуулж, Монгол Улсын хөгжил дэвшлийн төлөөх томоохон бүтээн байгуулалтыг хэзээ хийх юм бэ. Хөгжлийн санс чинь 0, Баялгийн сангийн хууль чинь хэрэгжихгүй байна. Бүх юмыг улсын төсвөөр хийнэ гэхээр төсөв чинь хүрэхгүй. Салбар болгонд жил болгон жоохон юм дусаадаг. Дэвшил ирж байгаа салбар байхгүй. ЖДҮ-лэлийн салбарт өчнөөн зээл өглөө. Ноос ноолуурт өглөө. Арьс ширд өглөө. Боссон/минут дуусав/

Р.Сэддорж: Сангийн яам 5, 6 дээр суучих. 6 номер Сангийн яам.

Ж.Дэлгэржаргал: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Улсын төсвийн хөрөнгө оруулалт сургууль, цэцэрлэгтэй холбоотой асуултад хариулъя. Төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжих дүн бол 3,2 их наяд байгаа. Тэгээд үүний 1 их наяд нь бол шинэ хөрөнгө оруулалт. Шинэ хөрөнгө оруулалтыг бид нар энэ орон зай дээрээ салбаруудын хувьд бол яг боловсрол, эрүүл мэндийн салбарыг бол эхний бодлогоор эрэмбэлсэн байгаа. Ирсэн саналуудын хувьд бол боловсролын салбар яг энэ 2026 онд төсвийн төсөлд ирсэн санал бол 2,1 их наяд байгаа. Эдгээрээс яг хуулийн шаардлага хангаад ,

улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжих боломжтой шинэ сургууль, цэцэрлэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр төлөвлөсөн. 2 нь бол Улаанбаатар, Баянгол болон Баянзүрх дүүрэгт байгаа. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр нийтдээ 41 сургууль, цэцэрлэгийн 32 нь бол сургууль байгаа. Тэгээд энэ хүрээнд бол Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт нийтдээ 10 гаруй сургууль баригдахаар төлөвлөсөн. Ер нь яах вэ их өгөгдөл дээр суурилаад сургууль, цэцэрлэг хэрэгтэй байршлуудыг бол Боловсролын яамтай хамтраад гаргасан. 108 сургууль ойрын 3 жил барих шаардлагатай буюу ээлжийн коэффициент нь 2-оос дээшээ гэсэн байршлууд байгаа. Эдгээрийн 84 нь бол Улаанбаатар хотод, 24 нь бол хөдөө, орон нутагт байгаа. Тэгээд Боловсролын яамны хувьд бол яг энэ эрэмбээ их өгөгдлөөр гарсан эрэмбээ барьсан гэж ойлгож байгаа. Азийн хөгжлийн банкны төслүүд дээр. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын шинээр төлөвлөсөн сургууль, цэцэрлэг бол яг энэ 108 байршилд байгаа сургууль, цэцэрлэгийг нөгөө талд нь яг хуулийн шаардлага хангасан буюу сүүлийн 2 жил ба батлагдсан зураг төсөвтэй ийм төслүүдийг төлөвлөсөн.

Р.Сэддорж: Нэмж хариулъя. Виртуал бүсийн татварын хөнгөлөлтийн талаар 5 номер дээр.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Баатархүү гишүүний асуултад хариулъя. ААНОАТ-ын тухай хуулийн 22.5.4-д бол виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдийн мэдээлэл технологийн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогыг улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс хойш 5 жилийн хугацаанд 100 хувь хөнгөлнө гэдэг ийм хууль бол 2024 оны 6 сарын 5-ны өдөр өөрчлөгдөөд, хэрэгжиж байгаа. Энэ хүрээнд бол өнгөрсөн 9 сард бол мэдээллийн технологийн үйлдвэрийг дэмжих виртуал бүсийг бол байгуулсан байгаа.

Татварын хөнгөлөлтийг бол заалт болгоноор төсөвлөдөггүй. Татварын ерөнхий хуульд заасны дагуу бүх татвар төлөгч хуульд заасан нөхцөл шаардлага хангасан тохиолдолд татварын хөнгөлөлтийг тайлангаараа эдлээд явдаг. Тэгэхээр энэ заалттай холбоотойгоор тусгайлан зардал юм уу, татварын буцаан олголт бол төсөвлөгддөггүй. Хуулийнхаа дагуу бол татвар төлөгч болгон эдлээд явах бүрэн эрхтэй нээлттэй байдаг.

Р.Сэддорж: Баатархүү гишүүнд 1 минут.

Ц.Баатархүү: Биш ээ, энэ нөгөө татварын хөнгөлөлтүүд явахаар чинь орлого талын чинь орж ирэх орлого талаа бид нар төсөвлөж байгаа шүү дээ. Та хэд бол хүү, торгуулийн орлогоо хүртэл төлөвлөж байгаа шүү дээ. Би чинь нийслэлд 8 жил төсөв баталсан. Хүү, торгуулийн орлогыг хүртэл төсөвлөдөг байхгүй юу. Тэгэхээр орлого тал дээр чинь энэ жил ийм ийм хуулиар ийм татварын хөнгөлөлт гарна гэдгээ яаж төсөвлөж байгаа юм бэ л гэж би асуугаад байгаа юм. Тэр чинь зарлага биш орлого талаас чинь буурах байхгүй юу. Татварынхан, Сангийн яамныхан байна уу. Тэгэхээр та бол зүгээр хууль яриад байна л даа. Одоо бид нар тоо тэнцүүлэх тухай юм ярьж байна шүү дээ. Орлого тал чинь буурна л гэж хэлэх гээд байгаа юм. Татварын орлого тал чинь. Энийгээ 1 дүгээрт анхаараарай. Дараа нь тэгээд сайхан хариулаарай гэдгийг хэлье.

Тэр эдийн засгийн нөхцөл байдлаа гараад энэ хэвлэлийнхэнд мэдэгдэл хийж болохгүй байгаа юм уу. Өнөөдөржин л Улсын Их Хурлын гишүүд 2 хуваагдаж, маргалдах гээд байна шүү дээ.

Р.Сэддорж: Эхлээд Сангийн яам хариулах уу. Сангийн яам Санжаадорж. 4 номер.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбоотой асуудал бол 2026 оны төсвийн төсөл дээр бол 1,4 их наяд төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээр тусгасан байгаа. Яг түрүүний таны дурддаг тэр 1 хувийн борлуулалтын орлогоос буурах хэсэг бол зүгээр орлого талаасаа хасагдчих юм. Тэр тооцоон дээр ороод ирж байгаа гэсэн үг болчхож байгаа юм. Хөнгөлөлт, чөлөөлөлт гэдэг бол өөрөө эхэлж хурааж авчхаад, буцаагаад нөгөө хасагдуулах юмнууд болчихно. 1 дүгээрт.

2 дугаарт яах вэ, сая энэ хууль маань батлагдсанаас хойш 2024 оны хувьд яг энэ чиглэлээр гарсан гүйцэтгэл бол байхгүй байгаад байгаа. 2025 оны хувьд бас тайлангийн жилдээ харж байгаад гүйцэтгэлүүд нь бол орж ирнэ гэсэн тийм байдлаар тооцоолж байгаа.

Р.Сэддорж: 1 номер.

И.Батхүү: Баатархүү гишүүний асуултад нэмэлтээр хариулт өгье. Сая зарлагдсан эдийн засгийн бодит гүйцэтгэлийн тоон мэдээлэлтэй холбоотой асуудал дээр тодорхой батлагдсан аргачлал цаглаврын дагуу Үндэсний статистикийн хорооноос гүйцэтгэлийн тоонууд зарлагддаг. 2 дугаар улирлын байдлаар 5,6 хувийн өсөлттэй байна гэсэн тоо гарсан байгаа.

Монголбанктай холбоотой тэр гадаад валютын албан нөөцийн хэмжээ бол 5 тэрбум 874 сая доллар байгаа гэсэн мэдээллийг Монголбанкнаас саяхан хийсэн. Цэвэр нөөцийн хэмжээг бол Монголбанкнаас албан ёсоор зарладаггүй. Гэхдээ миний ойлгож байгаагаар бол эерэг томоохон дүнтэй байгаа гэсэн ойлголттой байгаа. Дээр нь нэмээд төрийн сангийн үлдэгдлийн талаар бас Жавхлан сайд өчигдөр мэдээлэл өгч байсан. Санхүүжилтүүд асуудалгүй явж байгаа гэж ойлгож байгаа. Шаардлагатай бол Үндэсний статистикийн хорооны дарга маань энд бас байж байгаа.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асуулаа. Би бас Их Хурлын гишүүнийхээ хувьд Сангийн яамнаас бид энэ цалин тэтгэврийн талаар их ярьж байгаа боловч боломж бололцоогоороо л нэмэгдүүлээд явж байгаа. Тэгээд та бүхэн бүгдээрээ үр хүүхдүүд, дүү нартай хүмүүс. Яг одоо дэлхий даяар 11 цагаас ч юм уу үдийн цайг хүүхдүүд нь уудаг. Бид бол 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд үдийн цай өгдөг. Улс даяар 6-12 дугаар ангийн хүүхдүүд бол аав ээжээсээ мөнгөтэй нь мөнгөтэй, мөнгөгүй нь мөнгөгүй тэгээд дэлгүүр хоршоо хаанаас үдийн цайгаа уудгийг бол та бүхэн мэдэж байгаа. Тэгээд энэ цалин нэмсэн, тэтгэвэр нэмсэн, энэ 6-12 дугаар ангид үдийн цай өгсөн бол ер нь ялгаагүй. Ерөөсөө бид нарын хамгийн анхаарах ирээдүйдээ анхаарах зүйл бол энэ үдийн цай. Үдийн хоол гэнэ үү, цай гэнэ үү хүүхдүүдэд бол тэгээд энэ бол адилхан. Тэгэхээр 6-12 дугаар ангид ямар хэмжээний зардал гарах вэ. 1-5-д хэд гардаг юм. 6-12-т ямар зардал гардаг юм. Энийг өгөх чиглэл бодлого юм байхгүй юу. Тэгээд энэ хоол үйлдвэрлэлийн салбар чинь дагаад хөгжинө. Тэр сургуулийн гал тогоо хэдэн тогооч бол энийг хангаж барахгүй. Тийм учраас эргэн тойрны хоол үйлдвэрлэл, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол үйлдвэрлэл энэ дээр хөгжинө. Энэ дээр тооцоо гаргаж хэлээч. Сангийн яамнаас хэн хариулах вэ. 4 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Одоогийн байдлаар дээр бид 1-5 дугаар ангийн хүүхдүүдэд буюу нийтдээ 2026 оны төсвийн төсөлд тооцсоноор бол 822 мянган хүүхдээс 1-5 дугаар ангид сурч байгаа 349,4 мянган хүүхдэд 141,3 тэрбум төгрөгөөр үдийн хоолны энэ хөтөлбөрт хамруулна гээд тооцсон байгаа. Энэ дээр мэдээж хэрэг нэмэгдээд дотуур байрны бүх хүүхдүүдэд бас үдийн хоолны зардал туссан байгаа. Нэмээд 6-12 дугаар ангийн үлдэж байгаа 448,4 мянган хүүхдэд үдийн хоолны энэ тооцооллыг нэмж тооцно гэх юм бол нийтдээ 196,2 тэрбум төгрөг нэмж шаардлагатай байгаад байгаа. Үдийн хоолны энэ тарифын зардлыг бол сая сүүлд 2025 онд бас нэмэгдүүлэн тооцсон байгаа. Саяын энэ нэмэгдүүлсэн хоолны материалын тарифаар бол тооцсон. Баярлалаа.

Р.Сэддорж: 196,2 тэрбум төгрөгийг зориулах хэрэгтэй. Үүгээр 80, 90км зам л тавьж байгаа шүү. 80, 90км зам тавьснаас тэр хүүхдүүдээ 1 жил хооллочихдог, тэр хүүхдүүд сайн чанартай хоол унд хэрэглэвэл ямар өсөлт хөгжилт гарах вэ. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслүүдийн талаар төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Батнайрамдал гишүүнээр тасалъя. Саруулсайханы Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Ингээд төсөв хэлэлцээд сууж байх үед Монгол Ардын намаас бол 1, 2 гишүүн сууж байна. 32 гишүүнтэй Эдийн засгийн байнгын хорооноос 3 гишүүн байгаа юм байна. Гэхдээ 32 гишүүн суух ёстой ийм хурал дээр 2026 оны төсвөө ярилцаад сууж байхад бол ийм байдалтай байж байна гэдэг бол үнэхээр ичгэвтэр зүйл байна л даа. Тэгэхээр Монгол Ардын нам өөрөө 8 жил тасралтгүй засаг барьж байгаа. Монгол Ардын намын боловсруулсан энэ явж ирсэн төслүүд дээр бид нар өнөөдөр бас ярилцаад сууж байгаа юм. Тэгээд төрийн албан хаагч нар маань өнөөдөр энэ танхимд байгаа учраас та бүхэн маань уг нь бас энэ бодлогыг арай зөв чиглэл рүү явуулахад нь зоригтой дуугараад өгөөч ээ л гэж хүсмээр байгаа юм. Ялангуяа Сангийн яамныхнаас хүсмээр байна. Та бүхэн харж л байгаа. Одоо Шинэ хоршоо хөтөлбөр ямар хүнд нөхцөл байдалд бид нарыг аваачиж байна. Хүүгийн татаас дэлхийд 110 тэрбумыг бид нар төлж байна. Гэтэл эргэн төлөгдөх эсэх нь ч ойлгомжгүй ийм төслийг зүгээр сонгуультай холбоотойгоор гаргачихсан. Сангийн яамныхан яагаад энэ дээр үг хэлж болдоггүй юм бэ.

Дээрээс нь энэ ипотектэй холбоотой, тэгээд л бүх төрлийн сангууд хөнгөлөлттэй зээл гээд л гоё гоё нэртэйгээр оруулаад өгдөг. Сонгуульд санал авахын тулд явчихсан ийм хөтөлбөрүүдийн хойноос л бид нар яая даа гээд суугаад байдаг. Улсын Их Хурлын гишүүд нь эндээ орж ирэхээрээ энэ багш нарынхаа цалин тэтгэмжийг яаж нэмэх вэ, нийгмийн асуудлуудаа яах вэ гэдэг. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүдээс илүүтэй уг нь бол бодлогыг яг боловсруулж гаргаж ирж байгаа бичиг цаасан дээр байгаа энэ хүмүүс маань уг нь дуугараад болохгүй байгаа зүйлүүдийг нь хэлдэг болчих юм бол энд яг бодит өөрчлөлт явагдана. Тэгээд жишээ нь хүүхдийн мөнгийг больё гээд хэлчих зоригтой хүн байдаггүй. Хүүхдийн мөнгө 1 их наяд төгрөг зүгээр л хэрэглээний зардал болоод л гарч байгаа. Тэгээд энэ маань бол өөрөө иргэдэд сайхан харагдаж байгаа ч гэсэн бодит байдал дээр яадаг вэ гэхээр 100 мянган төгрөгийг бид нар өгч байгаа ч гэсэн дараа жил тэр 100 мянган төгрөгөөр юм авах гээд ороход дэлгүүрийн тэр 1 тороо ч дүүргэж чадахгүй л хиймэл мөнгө болгож бид нар тарааж байгаа шүү дээ. Тэгээд энэ бодитой үнэн зүйл. Тэгээд энийг гараад хэлж бид нар хүмүүст таалагдахгүй ч гэсэн зөв зам руугаа явахгүй бол манай улс чинь Венесуэл боллоо шүү дээ. Нэг л сайхан сэтгэлтэй өгөөмөр төслүүд хэрэгжүүлдэг улс. Бүгдээрээ л баахан зээлээр ч өгчихье, хөнгөлөлттэй юмыг ч өгчихье гэдэг. Гэтэл хэзээ ч зах зээлийн хүүг бид нар хуурамчаар тогтоох

боломжгүй. Ипотекийн 6 хувь гэж байгаа ч гэсэн тэрний бодит хүүгийн зөрүүг нь татвар төлөгч нар төлж байгаа. Тэгэхээр иргэддээ ч гэсэн бодитоор нь хэлэх ёстой. Хэн нэг нь тэрийг төлдөг тэр нь төр биш. Дандаа иргэд өөрсдөө буцааж л төлж байдаг. Тэгээд хиймлээр ийм хомсдол үүсгэчихсэн төслүүд дээр чинь бодитоор хямдхан юм шиг санагдаад хүн болгон авахыг хүснэ. Асар их эрэлт үүсэж байгаа юм. Тэр дээр нь төрийн албан хаагчидтай ойр байдаг хүмүүс нь танил тал авлига өгч ямар нэгэн байдлаар тэрэнд нь хамрагдахыг хүсдэг. Ипотек дээр бол танил талгүй бол авах боломж байхгүй л байгаа шүү дээ. Тэгээд ийм бодлогыг бид нар үргэлжлүүлээд яваад байж болохгүй. Авлига гээд л яриад байдаг хэр нь хаанаас тэр авлига авах боломж нь гарч байна гэхээр төрд эрх мэдэл олгоод, төрд ямар нэгэн хөнгөлөлттэй зээл, татаас элдэв сангууд гаргаж өгөх болгонд чинь л тэрийг нэг хуваарилж байгаа хүмүүст л бид нар эрх мэдэл өгөөд байгаа гэсэн үг. Тэгээд тэр утгаараа бид нар энэ татааснууд, хөнгөлөлттэй зээл, сангуудыг больчихмоор байгаад байгаа юм. Энэ бүх яамнуудад ч гэсэн холбоотой.

Та бүхэн магадгүй Монгол хүний хувьд иргэддээ сайхан санаад энэ төслүүд нь нээрээ гоё сонсогдож байна, хийчихмээр юм шиг санагдаж байж магадгүй. Гэхдээ энийг бид нар хэрэгжүүлээд 20 жил явлаа. Улам доройтож байгаа манай эдийн засаг. Тэгэхээр яг энэ эдийн засагтай холбоотой, санхүүтэй холбоотой тоон дээр нь сууж байгаа бодит харьцуулалтуудыг нь харж байгаа хүмүүс нь та бүхэн маань зориг гаргаад хэлдэг, энэ бодлогуудыг явуулахад нь Засгийн газар дээр үгүй ээ наад чинь бол буруу шүү гээд явчихдаг баймаар байна. Та бүхэн заавал энэ албан тушаалуудтайгаа зууралдах ёстой гэж үү. Миний хувьд ч гэсэн эрсдэл гаргаад явчихъя гэж бодож байгаа юм. Зүгээр Сангийн яаманд та бүхэн ийм олон жил суулаа гэдгээрээ бахархаж үлдэх нь чухал байгаа юм уу. Эсвэл Монгол Улсад бас өөрчлөлт хийсэн шүү гэдгээрээ бахархаж үлдэхийг хүсэж байгаа юм уу. Би үнэхээр гайх байгаа юм. Та бүхэн мэргэжлийн хүмүүсийн хувьд ойлгож байгаа хэр нь энд орж ирэхээрээ ердөөсөө бодит байдлыг хэлэхгүйгээр хуулийн дагуу .../минут дуусав/

Р.Сэддорж: Өлзийхүүгийн Шижир гишүүн.

Ө.Шижир: Сайд нар нь ажлыг нь хийлгэдэггүй шүү дээ Цэнгүүн ээ. Уг нь эд нар чинь мэргэжлийн хүмүүс байхгүй юу. Тэгээд сайд нар нь улс төрийн томилгоотой учраас ажлыг нь хийлгэдэггүй. Одоо энд 84 хүн байна. 84 төрийн албан хаагч ямар нэгэн байдлаар орж ирж. Хэдэн гишүүн байна. 8 гишүүн, тэгээд, 0 сайдтай. Сайд нар нь яг одоо хэвлэлийн хурал хийгээд улс төржөөд явчихсан. Өнөөдөр Монгол Улсад Засгийн газраас бусад бүх салбар ажлаа хийж байгаа. Ганцхан Засгийн газар өнөөдөр ажлаа хийхгүй, улс төржиж байна. Ер нь бол төрийн дээр нам гарчихаар ингэдэг байхгүй юу. Уг нь бол байр нь өөр байх ёстой юм. Бүгд улс төрийн томилгоогоор томилогддог. Бүгд нам дагаж томилогддог. Төрийнх нь дээр нам нь гарчихсан. Тэгээд намынх нь зовлон нь төрийн зовлон болоод, түмэн олноо хайхрахаа больчихсон. 2026 оны төсвийг чинь их гоё хэлээд байгаа шүү дээ. Хүн төвтэй төсөв. Засгийн газрын хамгийн том мега төсөл хүн байна гээд. Тэгсэн мөртөө ахмадынх нь тэтгэмжийг 2 хувааж өгнө. 2027 оныг чи өвчтэй байх чинь хамаагүй хүлээ гэж байгаа юм. Хүний эрхийн зөрчил. Тэгсэн мөртөө эмч, багш нарынх нь цалинг өгөхгүй гэж байгаа юм. Багийн төв дээр багийн эмч нарт сард ноогдох 30 литр бензинийг нь хүртэл өгч чадахаа больчихсон байна шүү дээ энэ Засгийн газар чинь. Өвдөх л юм бол үх гэдэг болсон. Өөрсдийнх нь урсгал зардал нь хамгийн багадаа 5 дахин, хамгийн ихдээ 500 дахин өссөн. Тэгээд урсгал зардлаа нэмээд л байна. Бүгдээрээ гоё нэмээд л байна. Одоо Сангийн яамныхан ирэх жил алт, зэс, нүүрсний чинь үнэ унахад урсгал зардлаа дийлэхгүй хэмжээнд ирж байна шүү дээ.

Нөгөө алдагдалгүй төсөв баталдаг гээд зарчим өнгөрсөн жил Ерөнхийлөгчийн хоригийн дараа жигтэйхэн сайхан гээд л ярьсан. Одоо тэр нь бас байгаа больчихсон. Зүгээр нэг төрийн бус байгууллагын дарга нь хэн болохоос хамаараад Засгийн газрын ажил нь бүтэн гацдаг болчихсон. Энэ чинь юу гэсэн үг юм. Зүгээр л нэг төрийн бус байгууллага шүү дээ намын дарга гэдэг чинь. Тэгээд энэ 84 албан хаагч нарт хандаж үг хэлэх юм уу. Уг нь энэ чинь хуульдаа төсвийн ерөнхийлөгчийн захирагчаас асуулт асууж, үг хэлнэ биз дээ. Тэгээд одоо энд чинь 1 ч төсвийн ерөнхийлөн захирагч байхгүй байна шүү дээ. Сэдээ дарга аа, 2016 онд одоо энэ төрийн дээр гарчихсан байгаа Монгол Ардын нам 21 аймагт 100 үйлдвэр барина гэсэн. Одоогоор бол 2100 үйлдвэртэй байх ёстой юм байна л даа. Хаана байна. Ард түмэн ялна гэсэн. Хаана байна. Төрийн хямралаас гарна гэсэн хаана байна. Цахим Засгийн газар болно гэсэн бас хаана байна. Бичиг хэргийн зардал нь 5 дахин өсчихсөн байгаа шүү дээ. Тэгээд ингэж цахим болдог юм уу. Тэгээд одоо бид нар нээрээ юу ч гэх вэ дээ. Төр нь сүүний ферм ч хийж байх юм. Цэцгийн тос ч хийж байх юм. Бяслаг ч хийж байх юм. Тэгээд хүн төвтэй төсөв гэсэн мөртөө яг хүндээ зориулсан шийдэл ерөөсөө байхгүй. Маш их мөнгөтэй. Зөвхөн сүүлийн 6 жилд 162 их наяд төгрөг зарцуулж байж өнөөдөр бид нар 1 ч салбарын асуудлыг шийдэж чадаагүй байна шүү дээ. Эхлээд сургуулиа шийдье л дээ. Цэцэрлэгээ шийдье. Онцгой байдлаа шийдье. Яагаад сургууль, цэцэрлэг, онцгой байдлынхаа асуудлыг зээлээр шийднэ гээд байгаа юм. Ийм эрэмбэ байдаг юм уу. Хүн төөрчихвөл яах юм. Зээлээр шийднэ. Зээл орж ирээгүй байгаа гээд сууж байх юм уу. Гал түймэр гарвал яах юм. Бид нар зээл хөөцөлдөж байгаа. Мөнгө байхгүй гээд сууж байх юм уу. Үгүй ээ, ийм болчихлоо шүү дээ энэ Засгийн газар чинь. Арай дэндүү юм. Бас энэ төр, засаг нь ажлаа хиймээр байна шүү дээ.

Р.Сэддорж: Энд 81 төрийн албан хаагч байна. Тэгээд түрүүний Байнгын хорооны хурал дээр бол хойшлогдсон. Манай Байнгын хорооноос болж гацсан, төсөв хугацаандаа батлагдахгүй байх асуудлууд байж болзошгүй учраас гишүүд та бүгдэд сайд нар чинь мэдээж чухал ажилтай болоод л сая чөлөө аваад л гарсан. Тэгээд мэдэгдэл хийж байгаа юм байна. Тэгээд та бүхэн энэ тэмдэглэл, протокол юмнуудаа бол сайн тэмдэглэж байгаа гэж итгэж байна. Бадрахын Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Яг энэ төсвийн хэлэлцүүлэг төсөв боловсруулж байгаа Байнгын хороон дээр хэлэлцэж байгаа Монгол Улс бид нар болохгүй байна. Сууриараа болохгүй байна. Асуудлыг 2 ангилж байгаа байхгүй юу. 2 ангилж байгаа. Одоо бид нарын хэлэлцүүлгийг яг бодлогын түвшний улс төрийн бодлого, гүйцэтгэл гээд. Одоо энд сууж байгаа 84 хүн гүйцэтгэлийн түвшний хүмүүс байхгүй юу. Баталчихсан төсвийг энд тэнд хуваарилсан гээд нэмэлт тодруулга өгөх ёстой хүмүүс болохоос биш түрүүн Сангийн яамны мэргэжилтэн андуурдаг шиг инфляц болно, тэгж болно гэдэг бодлого ярьдаг хүмүүс биш. Уучлаарай. Биш. Тэгээд яагаад энэ гишүүд сайд нарыг байгаач ээ гээд байгаа юм гэвэл сайд нар албан тушаалтныг байлгах гээд байгаа юм биш. Бодлого ярих гээд байгаа байхгүй юу. Тэтгэврийг яах юм. Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх юм уу, үгүй юм уу. Багш нарын цалинг нэмэх яг ямар бодлого байгаа юм. Аль замыг эхэнд үзэх юм. Замыг 1-д бодох юм уу, багшийг 1-д бодох юм уу, эмчийг 3-д бодох юм уу гэдгийг сайд нараас асуухын тулд энд байгаа юм. Тэгээд Байнгын хороо дээр тийм түвшний хэлэлцүүлэг болно гэхээс яг тэр замыг, тэр төсвийг, тэдэн төгрөг тэнд нь байгаа, тэрэнд нь ингэчихсэн, энэ тооцоо нь ингэчихэж гээд ийм тооцооллыг нь шалгах гээгүй. Тийм гүйцэтгэлийн түвшний юм ярих гээгүй байхгүй юу. Тэгэхээр улсын төсөв хэлэлцэнэ гэж байгаа нь яагаад парламентаар чухал вэ гэхээр бодлого хаашаа явж байна. Тэр бодлогоо дагаад мөнгөөр хувирсныг төсөв гэж хэлнэ. Тийм болохоор бид нарын ярьж байгаа

энэ төсвийн хэлэлцүүлэг, төсөв боловсруулсан, танилцуулж байгаа бид нарын асууж байгаа нь ч гэсэндээ номлолын хувьд буруу байна. Номлол нь ямар байна вэ гэхээр 20 гаруй жилийн өмнө зам дагавал хөгжил ирнэ гэдэг ийм өнгөтэй, гэрэлтэй, хөгжилтэй орнуудын гоё шилэн байшин, замыг нь хараад, тэрийг нь шүтчихсэн гэнэн, хөгжлөө ойлгохгүй төлөвлөгөө байгаа болохоор тэр дээр суурилсан тийм үзэл санаа дээр хийсэн төсөв байгаа болохоор энэ чинь утгагүй болчхоод байгаа юм. Үгүй ээ, хар л даа. Хамаг мөнгөө хувааж байгаад хэрэгтэй, хэрэггүй зам, байшин барьж тараагаад хийчихсэн. Тэгээд мөнгөгүй болох нь ойлгомжтой шүү дээ. Мөнгөгүй болсныхоо дараа одоо тэгвэл цалингаа нэмэхгүй байя, тэтгэврээ нэмэхгүй байя, яах вэ, тэр боловсрол тэгээд дараа болно биз гэсэн байдлаар хамгийн сүүлд нь хуваарилаад байх юм бол энэ чинь хөгжлийн бодлого биш байгаа байхгүй юу. Тэгээд шулуухан хэлэхэд Монгол Улсад хөгжлийн бодлого гэж байхгүй. Би энийг бол баталгаатай хэлж байна. Байгаа гээд гаргаад ирвэл үзүүлчих. Байхгүй. Ерөөсөө байхгүй. Хөгжлийн бодлого төсвөөр дамжиж хэрэгжинэ үү гэхээс биш хөгжлийн бодлого тэр тэр гээд бид нарын баталдаг бүх хүслийн жагсаалтаа хийчихсэн тэрэндээ гоё нэр өгчихсөн ийм хүслийн жагсаалтаа баталсныг хэлэхгүй. Тэгээд одоо бараг тэнэг хүнд ойлгогдохуйцаар хөгжлийн бодлого гэдгийг дараагийн удаа гишүүд минь ээ батлахдаа дугаарлаад оруулж ирэхийг хэдүүлээ шаардах хэрэгтэй юм байна. Багшийн цалинг нэмэх нь Монгол Улсын Засгийн газрын бодлого мөн үү, биш үү. Мөн юм бол хэдэд юм. Хэрвээ 1-д юм бол төсвөө олох нь Засгийн газрын үүрэг байхгүй юу. Мөнгөгүй гэсэн асуудал байхгүй. Энийг олоод зээлээр байна уу, бондоо босгоно уу, баялгийн сангаасаа авна уу, барих замаа хэдэн километрээр багасгана уу гэж байгаа нь Засгийн газрын бодлогын асуудал. Гишүүд бол аль нь эхэнд юм бэ гэдгийг асуух нь бид нарын үүрэг. Тэрийг тодорхойлоход оролцох нь гишүүдийн иргэдийн төлөөлөгчдийн үүрэг үү. Түүнээс биш аль хэдийн боочихсон, зүгээр энэ төсөл дээрээ батлуулах гэж байгаа юм дээр наана нь тэдэн төгрөг энэ байна, тэр хаачсан бэ, энэ яасан бэ гэсэн байдалтай гүйцэтгэлийн түвшний юм ярих нь өөрөө ямар ч утгагүй байна. Тэгэхээр бид нар Монгол Улс өөрсдөө яг хөгжлийн бодлого болон төсвөө хийхдээ номлолын бөгөөд аргачлалын асар том алдаатай болхи, чадахгүй байна. Тэгээд гүйцэтгэлийн түвшний яамны төрийн албан хаагчдаа хүндэлж байна. Гэхдээ та бүхэн маань яг сайдынхаа өмнөөс тоо эргүүлээд, нохой, гөлөг төөрүүлээд сурчихсан маягтай байгаад байгаа байхгүй юу. Тэгээд та бүхний ажил биш. Сайд нар чинь юу хийхээ эрэмбэлж бид нар танилцуулах ёстой байхгүй юу. Зам чухал уу, багш чухал уу, хүн чухал уу, боловсрол чухал уу гэдгээ эрэмбэлчихсэн баймаар байгаа юм. Энийг л шаардах хэрэгтэй байна. Тэгэхээр бид нар төсөв төлөвлөгөө хийж байгаа хөгжлийн бодлого хийж байгаа үзэл онолоо өөрчлөхгүй бол Монгол Улс явахгүй нь ээ.

Р.Сэддорж: Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Эдийн засгийн байнгын хороо дээр нам харгалзахгүйгээр төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын эрэмбэ дараалал хэрэгцээ шаардлагыг яаж тооцсон, тэрийгээ гаргаж өг гэсэн зүйлийг бүгдээрээ ярьж байгаад их баярлаж байна.

2 дугаарт нь шалгуур үзүүлэлт дээр бас олон гишүүд анхаарал хандуулдаг болж байна. Энэ бол зөв. Эндээсээ бид нар цаашаа төсвийн зарцуулалт, урсгал зардлаа үр дүнтэй зарцуулдаг, иргэдийн асуудлыг шийддэг, хувийн хэвшлийн асуудлыг шийддэг тийм төсөв болгож явах зорилготой. Тэгээд зарим сайд нар байхгүй байгаад нь харамсалтай байна. Дэлгэрсайхан сайд ганцаараа сууж байна. Үг хэлж байхад ч гэсэн энд Их Хурлын гишүүдийн ард түмний төлөөллийн үгийг сонсож байх ёстой.

Сая сургууль, цэцэрлэг боловсролын асуудлыг яаж шийдэх гэж байгаа юм бэ гэсэн зээл авч шийднэ. Азийн хөгжлийн банкнаас 100 гаруй сая доллароор 41 сургууль, цэцэрлэг барина гэж байна. Хаана барих ёстой эрэмбэ дарааллыг нь гаргаад өгнө гээд Боловсролын яам нь гаргасан гэж байгаа. Агуулга нь буруу байна. Эрэмбэлэлд нь алдаатай байна. 41 сургууль, цэцэрлэгээс нийслэлд 18, орон нутагт 23-ыг барина гэж байгаа юм. Өнөөдөр бид нар яг хаана сургууль, цэцэрлэг хэрэгтэй байгаа юм бэ гээд та бүхэнд энэ хүснэгтийг тарааж өгсөн. Энэ дээр бүгдийг нь биччихсэн байгаа. Бид нар орон даяар 108 сургууль, 95 цэцэрлэгийг барьж байж өнөөдөр Монголын аав ээж нар хүүхдэдээ чанартай боловсрол, хүртээмжтэй боловсролыг олгох боломж нь бүрдэнэ. Нийслэлд хүчин чадал нь мянгаас дээш давчихсан буюу 1 ангид 50, 60, 70-уулаа суугаад, 1 парт дээр гурвуулаа сууж байгаа сургуулиудын жагсаалт энэ хүснэгт дотор байгаа. Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургууль хэтэрсэн ачаалал 4143 хүүхэд, Баянгол дүүргийн Эрдмийн өргөө сургууль хэтэрсэн ачаалал 3180 хүүхэд гээд ярих юм бол бид нар тэргүүн ээлжид нийслэлд 40 сургуулийг барих эрхтэй байгаа. Гэтэл айлаас зээл авч байгаа мөртөө энэ нийслэлд дутагдаад байгаа 40 сургуулийг ерөөсөө оруулахгүйгээр, орон нутагт 1 ангидаа 10, 20-уулаа сууж байгаа тийм газруудаар сургууль барина гээд ороод ирж байгаа. Одоо тулгамдсан асуудлаа бид нар одоо шийдэх ёстой. Орон нутагт ачаалал нь мянгаас дээш хэтэрсэн ганцхан сургууль байгаа. Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын сургууль 1188 хүүхдээр ачаалал нь хэтэрсэн. Бусад нь бол дандаа мянгаас доош байгаа байхгүй юу. Тэгээд Боловсролын яамтай нь ярихаар, сайдтай нь ярихлаар хотод их сургууль, цэцэрлэг барих юм бол хотын хүн ам улам ихсээд, төвлөрөл улам хэцүүднэ гэж. Татвар төлж байгаа аав ээж нар одоо л хүүхдүүддээ чанартай боловсрол олгоё гэсэн тийм хүсэл зорилготойгоор Засгийн газраас ийм шаардлага тавьж байгаа. Боловсролын яаманд ийм шаардлагыг тавьж байгаа. Одоо шийдэж чадах асуудлаа шийдэхгүйгээр хаашаа ямар асуудлыг шийдэх гээд явах гээд байгаа юм бэ гэдэг дээр миний хувьд бол хот төлөвлөгч хүний хувьд бол эргэлзэж байна. Бүх дата нь байна. Судалгаа нь байна. Галбадрах гишүүн бүх судалгааг нь гаргаад өгсөн. Зааж зөвлөөд байхад тэрийг нь авч хэрэгжүүлдэггүй, сонсдоггүй. Нийслэл дээр газар чөлөөлөлт хийх ёстой учраас газар чөлөөлснийх нь дараа нь төсөв тавья гэж байгаа. Ирэх жил нийслэлийн төсөв дээр 450 тэрбум төгрөгөөр газар чөлөөлөлт хийнэ гээд тусгаж байгаа. Энийгээ Боловсролын яамтайгаа, Сангийн яамтайгаа ярилцаад энэ нийслэлд үнэхээр шаардлагатай байгаа 40 сургуулийг, 5 цэцэрлэгүүдийг хэрэгтэй газар нь барья гэсэн зүйлийг бүтээлч байдлаар ажилламаар байна. Хаана хаанаа очоод ярихаар энэ болдоггүй, энэ нь хэцүү, энд тэгчихдэг юм, энэ нь байхгүй гээд асуудлыг шийдмээр байгаа юм уу, шийдмээргүй байгаа юм уу. Гүйцэтгэх засаглалын ажил бол асуудлыг шийдэх ёстой.

Р.Сэддорж: Отгоншарын Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг явагдаж байхад Дэлгэрсайхан сайдаас өөр 1 ч сайд өнөөдөр байхгүй л байна л даа. Жавхлан сайд ирчихсэн байна. Ер нь хоорондоо улс төржиж явсаар байгаад өнөөдөр бид нар төсөв ч юу болж байгаа юм бүү мэд. Яг энэ үед дахиад л нөгөө бидний хамтдаа заавал шийдэл гаргаад явж байх ёстой Оюутолгойн асуудал хойшлогдлоо шүү дээ. 1 л тоо статистик хэлье. Өнөөдөр бид нарын батлах гэж байгаа төсөв нийт орлого ойролцоогоор 33 их наяд төгрөг. Доллароор авах юм бол 9,2 тэрбум доллар болж байгаа. Оюутолгойн төсөл дээр бид нар зээлийн хүүд зээлийн хүүгээ бид нар өөрчилж чадахгүй бол өнөөдрийн ярьж байгаа бид нарын төсвөөс 2 дахин их мөнгийг 18 тэрбум долларыг бид нар зээлийн хүүд төлөх тооцоололтой шүү дээ.

Өнөөдөр бид нар л ахмадынхаа цалин тэтгэвэр, багш нарынхаа цалин тэтгэвэр гээд энэ зүйлийг уг нь шийдэх боломж байсан юм. Энэ боломж дээрээ бид нар шийдэл гаргаж чадахгүй яг үнэнийг хэлэхэд арчаагүй царайлж байгаад өнөөдөр ийм байдалтай л сууж байгаа юм. Ард иргэд нь харж байгаа шүү дээ. 6 сар ориллоо. Одоо хүртэл хэлэлцээрт ороогүй. Гадаад компанийг буруутгах зүйл байхгүй. Өөрсдөөсөө л алдаагаа хайх хэрэгтэй. Яагаад үе үе энэ шийдвэрийг гаргаж байгаагүй юм. Энд 3,5 сая иргэний ардах амьдрал, амьдралын чанар бүгдээрээ яригдаж байгаа шүү дээ. Өнөөдөр Монгол Улс хэрвээ Оюутолгой төсөл дээрээ бид нар сайжруулах боломжоо ашиглаад явчихсан бол өнөөдөр ийм амьдрах, энэ хэдэн нийгмийн асуудлаа шийдэж чадахгүй ийм байхгүй байсан юм. Тэгээд анх байгуулсан тэр хүн нь өчигдөр орж ирээд л бас том том ярьж байгаад л явж байна лээ. Зээлийн хүүг яагаад 7 жил тутам гэсэн юм. Уул уурхайн цикл ч гэх шиг. Жавхлан сайд бас хэлсэн шүү дээ. Яагаад 7 жил гэж бид нар авч үзсэн юм. Яагаад 2, 3 жил байж болоогүй юм. Яагаад ер нь жил болгон бид нар зээлийн хүүг авч үзэж болдоггүй юм. Бид нар жил болгон бонд гаргах юм бол бондын хүү өөр тогтоно шүү дээ. Засгийн газар бонд гаргалаа, жил болгон өөр тогтоно. Зах зээл чинь өөрчлөгддөг байхгүй юу. Энэ төслийн явц өөрчлөгддөг. Өнөөдөр Онтре дээр бас яагаад одоог хүртэл бид нар 20 жил орхигдож ирсэн сэдэв шүү.

1 зүйлийг хэлье. Канадын The northern miner гээд дэлхийн уул уурхайн сэтгүүл дээр 9 сарын 12-нд энэ жилийн 9 сарын 12-нд дэлхий даяар явагдаж байгаа зэсийн хайгуулын төслийн үр дүнгээрээ 1 дүгээрт Онтре жагссан шүү. Дэлхийд 1 дүгээрт жагсаж байна. Онтрегийн талбай дээр Хойд Хюго гэж байгаа. Хойд Хюго дээр хайгуулын үр дүн нь дэлхийд 1 дүгээрт жагсаж байна. Гэтэл өнөөдөр бид нар Онтре дээрээ гэрээ хийж чадаагүй. Гадаадын 2 компани биднээс өмнө гэрээ хийгээд, ашгаа Иймэрхүү байдалтай байж болохгүй байхгүй юу. Энэ асуудлаа бид нар заавал шийдэх ёстой. Мөнгөн дүнгээр аваад үзэх юм бол бид нарын өнөөдрийн төсвөөс 2, 3 дахин их хэмжээний мөнгө ярьж байгаа шүү. Ард түмний баялаг ард түмэнд очих тэр боломжоо яагаад бид нар ашигладаггүй юм. Ийм арчаагүй царайлж байж болохгүй шүү бид нар..../минут дуусав/

Р.Сэддорж: Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн алга байна. Ганбатын Очирбат гишүүн. Жамбалын Ганбаатар гишүүнийг нэмээрэй.

Г.Очирбат: Тэгээд зарчмын хувьд би бас гайхаад байгаа. Би энэ аж үйлдвэрийн салбараас орж ирсэн. Ж.Ганбаатар гишүүн бас энд байна. Олон том групп компани байгуулж, олон хүнийг ажлын байраар хангадаг. Тэр Дэлгэрсайхан сайд бас байна. Олон хүнийг ажлын байраар хангадаг. Тэгээд бид нар тэрийг нь авч явж байгаа компани, групп, аж үйлдвэрийн салбарууд чинь өөрсдөө алдагдалтай ажиллаад ирвэл энэ дампуурчихдаг юм шүү дээ. Цаанаа банкны янз бүрийн эх үүсвэрийн зээлтэй, хөрөнгө оруулалттай. Тэгээд Монгол Улсын төсвийг уг нь энэ 2025 онд алдагдалгүй 1 удаа оруулж ирсэн юм. Тэгээд энэ удаа дахиад 1,3 их наядоор алдагдалтай оруулж ирсэн. Энэ зарчим бол хойшдоо байж болохгүй гэж би хувь гишүүнийхээ хувьд үзэж байгаа шүү.

2-т гэх юм бол дахиад сануулъя. Үндсэн хууль өөрчлөгдөөд, 126 Их Хурлын гишүүнтэй болсон. Тойрог тойргийн жалга довынхоо үзлээс салаад, Монгол Улсын эдийн засгийг нэг сэл хийтэл сэргээтэл хэдэн төслүүд явуулчихъя. Эдийн засгаа 3 дахин тэлье. 1 хүнд ноогдох ДНБ-ээ 10 мянган доллар буюу маш том зорилт тавиад бүгд эхэлсэн шүү. Үүний цаана зөвхөн тоо биш, дандаа бүтээн байгуулалтууд, аж үйлдвэр, аж үйлдвэрийн парк, дотооддоо хийж чадахгүй байгаа бараа бүтээгдэхүүнээ дотооддоо хийж, импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүнээ

дотооддоо хийж, инфляцаа бууруулъя. Инфляц буурснаар яах вэ, ард иргэдийн маань авч байгаа цалин бодитойгоор нэмэр болох юм байна. Олон том шийдвэрүүдийг хийх гэж Үндсэн хуулийн өөрчлөлт 126 Их Хурлын гишүүнтэй болсон гэж бодож байгаа. Тэгээд өнөөдрийн төсөв эрх мэдэлд ойрхон байгаа хүмүүс нь шинэ хөрөнгө оруулалтуудаа хуваагаад авчихсан. Эрх барьж байгаа нам нь 2, 3 хуваагдчихсан. Яаж байгаа нь мэдэгдэхээ больчихсон. Эдийн засгийн байнгын хороон дээр энэ төрийн олон жил төрд зүтгэчихсэн хар хайрцгийн бодлого барьж байгаа төрийн албан хаагч нар нь 81 хүн орж ирээд сууж байхад улс төржөөд сайд нар нь гараад хэвлэлийн хурал хийж байдаг. Энд Монгол Улсын Эдийн засгийн байнгын хороогоор эдийн засгийн асуудлаа ярьж байхад бүх сайд нар нь гараад хэвлэлийн хурал хийж байдаг ийм түүхэн цаг хугацааг өнөөдөр энд сууж байгаа төрийн албан хаагч нартайгаа цуг үзлээ шүү. Ер нь сүүлийн 9 жил энэ төрийг барихдаа энэ байдлаар л явсан юм байна. Одоо нээрээ үнэхээр яг үнэнийг хэлэхэд жигшиж байна шүү. Үнэхээр бараг ой гутаж байна. Олон удаагийн тодотгол, 2 жилийн төсөв дээр ингэж сууж задалж ажиллалаа. Тэгээд бид нарыг бөөс түүлгүүлэх гэж байгаа юм шиг тоонуудаа үг, өгүүлбэрийн ард нуучаад, түүлгүүлдэг. Уг нь бид нар энд бодлого яриад л сууж байх ёстой. Төсвийн ерөнхийлөн захирагч нар энд суучихсан бид нар ажлаа эрэмбэлээд эхлээд энийг хийвэл үр дүнд хүрнэ, 2-т энийг хийе, 3-д энийг хийе, 4-д энийг хийе. Энийгээ хамгаалаад, ард иргэддээ ойлгуулаад, иргэдийн төлөөлөл болсон Их Хурлын гишүүддээ ойлгуулаад, дэмжлэгээ аваад л явж байх ёстой. Тэгэхэд ямар ч тийм бодлого эндээс харагдахгүй. Хуучин руугаа ухраад орчихсон. Улс эх орноо урагшлуулъя гэсэн ямар ч зүрх сэтгэл байхгүй ийм л болчихлоо шүү дээ.

Тэгээд их олон Их Хурлын гишүүд хэлээд байна. Төрийн албан хаагч нар аа, та хэд маань бас энэ Монгол төрийг авч явж байгаа шүү. Тэгээд зарим нэг юман дээр үнэнээр нь юмыг тавьж хэлж байгаарай. Үнэхээр болохгүй бол бид нар та тарт хүч өгөөд явна. Түрүүн яг харж байгаа биз. Энд Эдийн засгийн байнгын хороогоор Монгол Улсын 2026 оны төсвийг хэлэлцэж байхад сууж байсан сайд нар нь бүгд гараад явчхаж байгаа юм. Тэгээд туршлагатайгаар Жавхлан сайд, Дэлгэрсайхан сайд 2 буцаж орж ирээд..../минут дуусав/

Р.Сэддорж: Сайдуудыг дуудаарай. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Эдийн засгийн байнгын хороо дээр бас зориуд орж ирсэн. Тэгээд Монгол Улсын 2026 оны төсөв, 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдлээ 3 жилийн асуудал ерөнхийдөө бас ярьж байна. Тэгээд 1 дүгээрт ирэх жилүүдэд иргэд бол энэ төсвөөс миний орлого яаж нэмэгдэх вэ, аж ахуйн нэгжүүд ч харж байгаа байх. Тэгээд бид нар энд хариу өгөх ёстой. Одоогийн байгаа байдлаар харахаар бол үндсэндээ энэ жил 6 хувиар нэмсэн. Ирэх жил байхгүй. Тэрний дараа жил ер нь байх эсэх нь тодорхойгүй гэдэг ийм л төсвүүд байгаад байна.

Тийм учраас энд бол бид нар ер нь цаашаа яг энэ баялгийг шударгаар хуваарилах, төсвөөс ялангуяа энэ суурь салбар болсон бид нар НҮБ-д суурь 2 хүний эрх болсон 1 нь боловсрол сурах эрх, нөгөөдөх нь эрүүл байх эрх гэдэг 2-ыг манаж байгаа энэ албан хаагчдаа гудамжинд гаргаад л байж байна л даа. Гадаа талбай дээр жагсаж байна. Доор манай үйлдвэрчний эвлэлийнхэн бүх аймаг, сумаас ирсэн хүмүүс бүлтийтэл хараад сууж байна. Яах нь вэ, ийх нь вэ гээд. Энийгээ шийд гэж байна. 600, 700 хүн ирчихсэн байна. Тийм учраас энэ тал дээр бол Сангийн яам маань нэг тоо тавиад өөдөөс яриад суугаад байгаа. 24 хувьд л багтаах ёстой гээд. Их Хурал энийг баталчихсан гээд Их Хурлын нийт гишүүд рүү асуудал тавиад байгаа. Энийг Засгийн газар өөрөө орж ирээд л тавьсан шүү дээ. Үнэхээр

алдагдалтай оруулж ирж байгаа юм бол тэр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж нэмэх тал дээрээ улс төрийн шийдвэрээ гаргаад оруулж ирээд, энэ хүмүүсийг талцуулалгүй, энэ шийдлээ гаргамаар байна. Их Хурлын гишүүн бол төсөвтэй холбоотой хууль санаачлахгүй гэдэг хуулийг нь хүндэтгээд л яваад байгаа. Засгийн газар өөрөө оруулж ирэх юм байна лээ. Төсвийн хязгаар гээд жилийн үйл ажиллагааны төсвөө 24 хувьд барина гэж. Нөгөө талаараа би бас чуулган дээр хэлсэн. Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын мөнгийг урсгал зардал руу оруулж ирээд, урсгал зардал чинь таазандаа тулчихсан. Тэгээд 1-ийг нь нөгөөгөөр нь хасаад танаад, тэгээд та нар өөрсдөө олохгүй юу гэдэг байдал бол ийм зүйл бол байж болохгүй. Тийм учраас Засгийн газар бол энэ тал дээр бол төсөв дээрээ яаралтай тодорхой хэд хэдэн зүйл дээр л яримаар байна.

1 дүгээрт багш, эмч нарын цалин хөлсний асуудал хэдэн хувиар нэмэх юм, яаж нэмэх юм. Ахмадын тэтгэврийн асуудал инфляцаас доошгүй өмнөх жилийн инфляцаас доошгүй нэмнэ гээд хууль дээр маш тодорхой байгаа. Гэтэл одоо 8,8 байгаа инфляцыг бид нар бол 6 хувь гэдэг байдлаар бодож байгаа юм гээд хууль зөрчөөд, энэ чинь бас хууль зөрчиж байгаа төсөв шүү дээ. Манай Төсвийн хууль эрх зүйн үнэлгээ өгч байгаа хүмүүс энэ дээр огт тавихгүй байна лээ. Жил болгон тэгвэл тэр 24 хувь гэдэгтэй чинь ижилхэн цалин хөлс орлогыг инфляцын түвшинтэй уялдуулж нэмнэ гэсэн төлөвлөгөөнд байгаа. Тэрийг тэгвэл яагаад оруулж ирэхгүй байгаа юм. Нөгөө талаас мөнгөгүй юм болов уу гээд харахаар гадаад, дотоод авсан зээлийг нь харахаар сүүлийн 10 хэдэн жил дэлхийд байхгүй өндөр хүүтэй зээл авчихсан. Өдөрт 10 тэрбум алдагдал хүлээж байна гэж байгаа юм. Хүүгийн зөрүүнээс. Тэгээд энийгээ би бол эс үйлдэхүй гэж харж байгаа юм. Хийх ёстой юмаа цаг хугацаандаа хийгээгүй. Тэгээд 4 сар, 4 сар үлдчихсэн гэдэг ийм зүйлийг бол ярьж байгаа. Үнэхээр утгагүй сонсогдож байна.

Дээрээс нь би бас л ярьсан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал гээд 0,5 гээд хуульд байх ёстой зардал. Түрүү жилжингээ орилоод тавиулж чадаагүй. Станц дээр 1 ийм осол болоод л 100 тэрбумаа алдсан шүү дээ. 400 сая төгрөг тавиад, энэ дээрээ аюулгүй байдалдаа анхаар гээд байсан. Одоо тэр 3, 4 дүгээр асуудал гэсэн. Одоо тэгээд иймэрхүү байдалтай байж байгаа. Тийм учраас би Сангийн сайд болон Засгийн газраас энэ төсөв дээр энэ тулчихсан байгаа асуудлууд дээрээ ард түмнийг болон төр засаг ард түмний хооронд энэ үүсээд байгаа багш нарынхаа цалин хөлс, ахмадын тэтгэвэр гээд энэ зүйлүүд дээрээ яаралтай шийдвэр гаргаач ээ. 1 тоо барьж авмаар байна. Огт байхгүй болон тавьж байгаа шаардлага 2-ын хооронд бол асар том зөрүү байгаад байна. Тийм учраас энэ тал дээр бол та бүхнээс хүсэж байна. Тэгээд тэр төсвийн хууль дээр бол өөрчлөлт хийхийг Засгийн газар оруулж ирэхийг хүсэж байна.

Р.Сэддорж: Жамбалын Ганбаатар гишүүн.

Ж.Ганбаатар: Эдийн засгийн байнгын хорооны хурал болж байхад мэдэгдэл энэ тэр ч гэх шиг. Засгийн газар мэдэгдэл хийнэ гэхээр их том юм гэж өөрсдийгөө их том мэдэгдэл хийчихлээ гэж бодож байх шиг байгаа юм. Үгүй ээ, тэгээд мэдэгдэл хийнэ гэдэг чинь хамгийн арчаагүй хүмүүсийн үйлдэл болчихсон юм биш үү одоо. Би лав ер нь парламентыг олонхоороо шийддэг гэж хардаг. Тийм учраас би үүдэнд ер нь сэтгүүлч цуглуулаад мэдэгдэл хийж үзээгүй. Би 10 жил Их Хурлын гишүүнээр сууж байна. Энэ Засгийн газар өөрөө Эдийн засгийн байнгын хороонд төсвөө танилцуулаад сууж байгаа биз дээ. Засгийн газрын өргөн барьсан төсөв юм байгаа биз дээ. Тэгэнгүүтээ бүгдээрээ гарч гүйгээд, миний хувьд бол ямар нэгэн юман дээр гарын үсэг зураагүй. Зурах ч үгүй. Зарим нэг хүмүүс утасдахаар нь би загнаж байгаа

юм. Үгүй ээ, тэгээд энэ мэдэгдэл хийгээд, улам арчаагүй, улам бүр ийм дорой байдалтай байж байж тэгээд мэдэгдэл хийхээр гоё гээд бодчихсон юм байх даа. Ер нь бол янз янзын байдлаар парламентын гишүүд мэдэгдэл хийдэг бол маш муухай харагддаг шүү дээ. Олонхоороо шийддэг парламент, тэгээд өөрөө эсвэл цөөнх байсан юм уу, өөрөө ганцаараа байсан юм бол тэрийгээ тэгээд л дараа дараагийн юмаар засаад л явах ёстой шүү дээ. Тэгээд үүдэнд баахан сэтгүүлч цуглуулаад, Засгийн газар бүр арай ч дээ нээрээ.

Монгол Улсын төсөв би бол ер нь зарлага талд нь юм ярьдаггүй. Энэ зарлага талд нь ярьж байгаа гишүүдэд хандаж хэлэхэд бол орлого талыг нь ярьж байгаач ээ. Орлого талыг нь анхаараач ээ гэж хэлж байгаа юм. Орлогоо олж байж бид Монгол Улс цаашаа явна. Тэгэхгүй бол манай тийм юм болоогүй байна, энэ зам дээр ийм болоогүй байна, тэр цалин ингээгүй байна, ингээгүй байна. Их Хурлын гишүүний дуу хоолой орлого талд нь зайлшгүй хэрэгтэй. Энэ бол бирж чинь ажиллах юм уу, эсвэл Монгол Улс яаж мөнгө олох юм, яаж зөв зарцуулах юм, тэрийгээ яаж ариг гамтай, хямгатай байх юм. Маш замбараагүй. Монгол Улсад мөнгө байгаа. Маш замбараагүй. Би мөнхийн хэлдэг. Би өнөөдөр хэлд орж байгаа биш. Энэ мөнгийг зарцуулж чаддаг хүмүүс бол зарцуулаад, хөгжүүлээд аваад явна. Түрүүн хэн гишүүн хэллээ. Бодлого ярих ёстой. Бүгдийг нь халамжийн салбар болгож байгаа. Тэгээд тэр халамжууд нь өгөхөө болихлоороо буцаагаад засгаа унагана. Монгол Улс хүндэрнэ. Халамж өгөөд, татаас өгөөд, өөд нь татсан салбар байхгүй. Тэгээд үнэхээр нээрээ юу хэлэх юм бэ дээ, арай ч дээ нээрээ. Тэгээд Эдийн засгийн байнгын хороонд өөрсдөө төсвөө өргөн барьчхаад, тэгээд гишүүд орж ирээд хуралдъя гэхээр мэдэгдэл ч гэх шиг. Тэгээд хэнээс асуугаад, хэнд хариулаад, саяын гишүүд хэлж байна шүү дээ. Энэ төрийн албан хаагч нар чинь бодлого ярьдаг хүмүүс биш ээ. Үгүй ээ, энийг анх удаа яриагүй шүү дээ сайд нараа. Үгүй ээ, энийг би анх удаа энэ танхимд сонсоогүй шүү дээ. Би энд 10 жилийн өмнө л сонсож байсан. Сайд нар орж ирж хариулна. Бодлого ярина. Тэгээд төрийн албан хаагч нар хариулчхаад, өөрсдөө байхгүй. Үгүй ээ, одоо тэр мэдэгдэл үнэхээр гоё болчихсон гэж бодож байгаа байх даа. Үнэхээр тэнд зогсож байгаа хүмүүс ямар харагдаж байгаа бол. Үнэхээр нээрээ арай ч дээ нээрээ. Би хэн нэгнийх нь талд орж ярьж байгаа юм биш. Өөрсдөө бүр үнэхээр нээрээ ямар ч арчаагүй байгаа харагдаж байна шүү дээ. Үгүй ээ, тэрнээс зугтах хэрэгтэй шүү дээ. Би больё гээд. Ээлжилж мэдэгдэл хийхээ болих хэрэгтэй шүү дээ.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, үг хэлж дуусаж байна.

Сангийн яаманд бас зарим зүйл дээр хэлж оруулж л байгаа байх л даа. Бид бол хангай газар байж байгаа гол мөрөн ихтэй газруудад амьдарч байгаа хүмүүс бол ихэнх нь байгаа байх. Тэгээд яг тэр нөгөө улсын төсөв бүрдүүлж байгаа газар нутаг чинь бол яг гүний усаар бүх юмаа хийж байгаа. Гүний ус бол зарим газар ус өрөмдөх компанийн өрөм нь хүрэхгүй болчихсон, гарахаа байчихсан байна. Тэгээд 200 метрээс ус гарахгүй болсон нутагтай болсон. Хуучин бол ер нь гар худгаар л малаа услаад байдаг байсан шүү дээ. Тэгээд дээр үед бол устай байхдаа Усны аж ахуйн яамтай байсан байна лээ. Миний мэдэх Жанжаадорж гэж Усны аж ахуйн сайд байсан. Говийн хүн байсан. Тэр үед бол ард түмний усан хангамжийг сайжруулах маш олон зүйлүүдийг хийсэн. Тэрний хүчинд ч одоо явж байгаа. Тэгээд усгүй болчихсон хэр нь Усны яам яамны хэмжээнд, Засгийн газрын хэмжээнд, Засгийн газрын хуралд суух хэмжээний хүн, байгууллага байх ёстой гэж уриалж байгаа. Тэгээд Хэрлэн Тооно төслийн хувьд бол Оюутолгой компаниас 3 сая долларын санхүүжилтээр ТЭЗҮ хийгдэж байгаа. Энэ удахгүй дуусах байх. Орхон-Онги төсөл дээр нөгөө Онги цагаан бургастай дээр бэлэн зураг төсөл байхгүй байгаа. Энийг

хийе гэсэн 13.0 хэдэн тэрбум төгрөгийг хассан байна. Хасаж оруулж ирсэн байгаа. Энийг оруулахгүй бол үнэхээр болохгүй. Ирэх жилийн Коп-17 хурлын үеэр бидэнд бэлэн зураг төсөл байхгүй байгаа. Энийг оруулж байгаа биз дээ. Дээрээс нь яамгүй боловч Усны газартай болсон. Бас чамлахаар чанга атга. Дээрээс нь өнгөрсөн жил говийн усыг хариуцсан нэгжтэй болсон. Тэрний цалин 800 гаруй сая төгрөгийг хасаж оруулж ирсэн. Энийгээ буцааж оруулаарай, суулгаарай гэдгийг хэлье.

Тэгээд бид бол хэдийгээр нэлээн шүүмжлэлтэй ярьж байгаа ч гэсэн Монгол Улсын төсөв саяхан 5, 6 жилийн өмнө 10-аад их наяд л байсан шүү. Одоо бид 33 их наядын тухай ярьж байгаа. Бид бол төлөвлөлтөө улам чамбайруулж явбал бас чамлахаар чанга атга. Хэдийгээр бусад улс орнуудтай харьцуулахад бага ч гэсэн бид бол 3 дахин өндөр төсвийг яриад хэлэлцээд сууж байгаа. Нийтээрээ бол бас дээшилж байгаа, дэвшиж байгаа юмнууд байгаа гэдгийг хэлье.

Тэгээд үдийн цай хөтөлбөрт хүүхдүүдээ алагчлалгүй 6-12 дугаар ангид үдийн цай өгөхийн тулд 196 тэрбум төгрөг шаардлагатай юм байна. Та бүхэн тэр урсгал зардал, тэр тавилга, эд хогшилд хэдэн төгрөг байгааг харж л байгаа. Энд байгаа гишүүд хэлээд л байна. Тэгэхээр үдийн цайгаа уугаагүй хүүхдүүдтэй байж байж бид нар эцэг хүний хувьд, энэ байгууллага удирдаж байгаа хүмүүсийн хувьд энэ бас байж болохгүй зүйл. Цалин тэтгэврээс дутахгүй ач холбогдолтой зүйл бол энэ үдийн цай. Тэгэхээр энийг Сангийн сайд анхааралдаа аваад, өөр хэмнэж болох зардлууд юу байна. Хэмнэж болохгүй зардал гэж ер нь байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ эрэмбэд нь бол маш дээгүүр л явна. Тэгээд энийг хэлье.

Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

12.41 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Өнөөдөр ирсэн ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсэг байр эзэлье.

Жавхлан Сангийн сайд, Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Наранбаяр Боловсролын сайд, Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ариунбуян Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Мөнхдорж Онгой байдлын ерөнхий газрын Санхүү, ар талын газрын дарга, Баянмөнх Онгой байдлын ерөнхий газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Наранпүрэв Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Хүрэлбаатар Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн

засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Марал Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өөрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн.

Гишүүдийг орж ирэхийг урьж байна. Байнгын хорооны өмнөх хуралдаанаар хөтөлбөрийн төслийн талаар асуулт асууж, үг хэлсэн. Нэмж үг хэлэх, асуулт асуух гишүүд байвал асуулт асууж, үг хэлье. Үүний дараа санал хураалт явагдана. Ганбатын Очирбат гишүүнээр тасалъя. Уянга гишүүнийг нэмье. Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Сайн байцгаана уу. Энэ зээлийн хэлэлцээрийг бол дэмжиж байгаа. Гэхдээ нөхцөлтэйгөөр дэмжиж байна. Одоо байгаагаараа бол нийтдээ 41 сургууль, цэцэрлэгийг барина гэж байгаа. Нийслэлд 17 сургууль, 1 цэцэрлэг, орон нутагт 15 сургууль, 8 цэцэрлэг. Гэхдээ та бүхэнд сая тараасан улсын хэмжээнд ачаалал нь хэтэрчихсэн байгаа 108 сургууль, 95 цэцэрлэг байгаа. Эндээсээ бид нар харж байгаад, хаана асуудлыг шийдэх ёстой юм. Тэр сургуулиудыг нь өөрчлөөд, нийслэлд 25 сургууль, 4 цэцэрлэг, орон нутагт 7 сургууль, 5 цэцэрлэг гаргахаар санал боловсруулсан.

Тэгэхээр өнөөдөр Байнгын хороон дээр дэмжигдээд, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдлын байнгын хороогоор дэмжигдээд, нэгдсэн чуулганаар дэмжигдээд явна байх. Дэгийн тухай хуулийн 76.3.2, 76.6.2-т заасны дагуу энэ хэлэлцээрийн төсөлд засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна. Нэгдсэн чуулганаар дэмжигдээд явсны дараа 76.8-д заасны дагуу Засгийн газарт Боловсролын яам, Сангийн яам 2-т энэ 41 сургууль, цэцэрлэгийн байршлыг нь өнөөдөр энэ миний гаргаж байгаа, Галбадрах гишүүний гаргаж байгаа, Батнайрамдал гишүүний гаргаж байгаа энэ саналд нийцүүлээд, жагсаалтыг шинэчлэх гэсэн саналтай байна. Энийг Их Хурлын Тамгын газрынхан маань ямар журмаар, яаж ямар үе шатад нь яаж оруулах вэ гэдэг дээр гарц гаргалгаа гаргаж өгөөд, энийг заавал тусгуулах хүсэлтэй байна.

Р.Сэддорж: Эхлээд Сангийн сайд, тэгээд Наранбаяр сайд, дараа нь би хариулъя.

Б.Жавхлан: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Энэ жил Боловсролын яам дээр бид туршилт хийсэн гэх үү дээ. Бид нарынхаа хэмжээнд л хиймэл оюун ухаан юм даа. Төрд байгаа бүх датануудаа оруулаад л эрэмбэлсэн байгаа юм. Тэрийг бол харин ч Боловсролын яамныханд би талархал илэрхийлнэ. Бусад яамнууд энэ дээр бас жоохон удаашралтай байгаад байгаа. Харин Боловсролын яам маань ашгүй их дата сайтай юм байна лээ. Тэгээд ингэж гарсан. Одоо бол Их Хурал дээр нэгэнт өргөн барьснаас хойш Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдаад, энэ дээр дахиад эрэмбэлээд, асуудлууд яриад явахад бол чөлөөтэй шүү дээ. Тэр дээр бол ямар ч асуудал байхгүй. Засгийн газраас ерөөсөө тэнд эсрэг байр суурь байхгүй. Тийм ээ. Бүгд Их Хурал дээр яаж батлагдана. Тэрийг нь бид биелүүлээд л явна. Гүйцэтгэлийг нь хангаад л явна.

Р.Сэддорж: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ үнэхээрийн тэр газар зүйн мэдээллийн сан дээр суурилаад гарч ирсэн. Тэгээд энэ дээр бол орж ирж байгаа саналуудыг бид хүлээж аваад, тэгээд Азийн хөгжлийн банкны хэлэлцээ хийх явцад бас энэ

жагсаалтуудаа илүү чамбайруулах ийм боломжтой гэж харж байна. Тийм учраас хүлээж авах саналтай байна.

Дорнод аймгийн тухайд бол өнөөдөр шилжих 4 төсөл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1 төсөл арга хэмжээ, Азийн хөгжлийн банкаар бол 1 төсөл, арга хэмжээ Хэрлэн сум дээр гээд ингэчихсэн явж байгаа. Тэгээд цаашдаа энэ боломжийг нь бас хараад тийшээгээ бас шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалтуудыг бол ярилцаж болно гэж харж байна.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүний гаргасан энэ саналын дагуу Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаан дээр таны гаргасан саналыг оруулаад явуулна. Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Гишүүдээ, хоорондоо маргахгүй шүү. Минутдаа үгээ хэлчихье. Урьд нь би бас хэлж байсан. 1,7 их наяд төгрөг 475 сая долларын асуудал байгаа. Үүнээс 232 орчим сая доллар нь энгийн нөхцөлтэй софер, үлдсэн 243 сая доллар нь хөнгөлөлттэй эх үүсвэр гээд байгаа юм. Тэгэхээр ер нь бүгдийг нь хөнгөлөлттэй эх үүсвэр лүү татаад оруулаад ирэх боломж байсан уу, байгаагүй юу гэдэг дээр асуулт асуучихъя.

2 дугаарт энэ гишүүдийн яриад байгаа бас зөв. Аймгуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах эрчимжүүлсэн төсөл гээд байгаа юм. 225 сая доллар гээд тавьчихсан. Зарим 1 аймгуудыг оруулаагүй, орхичихсон. Тэндээс сонгогдсон гишүүд нь бас их гомдолтой байдаг. Маш төвөгтэй юм байна лээ. Тэгэхээр яг магадгүй Улсын Их Хурлын гишүүд гэдэг бол энэ чинь ард түмнээ төлөөлөөд сууж байгаа энэ хүмүүсийнхээ байр суурийг нь сонссон юм уу, сонсоогүй юм уу гэдэг асуулт гарч ирээд байгаа юм.

2 дугаарт боловсрол дээр болохоор 130 сая доллар нь байгаад байгаа юм. 130 сая доллар. Тэгээд түрүүний Лувсанжамц гишүүний саналыг бол би хувьдаа дэмжиж байгаа юм. Ямар ч тооцоо судалгаагүй Баян-Өлгийд баригдах 960 хүүхдийн сургууль Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт баригдах 960 хүүхдийн сургууль адилхан 16 тэрбумын төсөвтэй. Бүгдийг нь зүгээр автоматаар хуваагаад тавьчихсан. Ийм тооцоолол гэж байдаг юм уу Сангийн яам, Наранбаяр сайд аа. Баян-Өлгийд 960 хүүхдийн сургууль барих, Улаанбаатар хотод барих 2 адилхан үнийн дүнтэй байх уу. Үгүй ээ бүхэл бүтэн Сангийн яам байж байж энэ дээрээ та нар хэдэн мянган км-ийн зөрүү гарна шүү дээ. Бүр маш сонин юм оруулаад ирсэн. Энийгээ засах ёстой 1-д.

2-т гэх юм бол энэ хэрэгцээг нь эрэмбэлэх ёстой. Улаанбаатар хотод бол сургуулийн хүртээмж бага байгаа. Тэгэхэд Улаанбаатар хот дээр бага, орон нутгууд дээр их тавьчихсан байдаг. Энэ тоо дээрээ ажиллах ёстой. Энийгээ ажиллаж гаргаж ирсэн юм уу, үгүй юм уу. Нэг бол Лувсанжамц гишүүн хувь гишүүнийх нь судалгаагаар түрүүний мэдээллээ хэлсэн үү. Хувь гишүүний судалгаагаар хэлж байна шүү дээ. Бүхэл бүтэн яам байж байж ажлаа хийхгүй. Түрүүний хурал дээр хэлээд л гаргасан. Энэ төсөв мөнгөтэй холбоотой, ялангуяа 1,7 их наяд төгрөг 475 сая доллартой холбоотой асуудал ярьж байгаа. Тэгэхээр энийгээ зөв эрэмбэлээд, зөв өртөг тооцоог нь хийгээд, аль аймаг Улаанбаатар хот бол Улаанбаатар хот, холын аймгууд бол олон аймгууд дээрээ тооцоолол хийгээд оруулж ирэх шаардлагатай гээд хэлсэн. Одоо бас орж ирээгүй л байгаа.

Р.Сэддорж: Хэн эхэлж хариулах вэ. Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Очирбат гишүүний асуултад хариулъя. Азийн хөгжлийн банктай хийх гэж байгаа энэ төслийн хүрээнд бол эрүүл мэндийн салбарт ёстой алагчлал байхгүй гэдгийг би танд хариуцлагатай хэлчихье. Яагаад гэхээр бид нөхцөл байдлын үнэлгээг аймаг бүр дээр хийж байгаа. Жишээлэх юм бол сая Увс, Ховдод 6-10 сая долларын хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр эмнэлэг барьчихсан. Өргөтгөл бариад, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, төрөлжсөн мэс заслын хэсгийг хийгээд өгчихсөн учраас энийг давтаж хийх шаардлагагүй. Тэгэхээр ерөөсөө шалгуур юу гэж гарч байна вэ гэхээр хаана, юу дутуу байна, ямар аймагт эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, дээрээс нь нөгөө харвалт, шигдээс, гэмтэл осолтой холбоотой тусламжийг шуурхай хүргэхэд юу дутуу байгаа гэдгийг бүр аймаг бүрээр нь гаргаж байгаа шүү. Тийм учраас энэ ерөөсөө 21 аймгийг 1 ч аймгаа орхигдуулахгүй бүх сан санхүүжилтүүд хэрэгтэй зүйлийг нь хийнэ. Түүнээс аймаг болгонд байшин барьж өгөхгүй. Бид үрэлгэн тогтолцооноосоо илүү ухаалаг систем рүү орж байгаа. Тэгэхээр гэмтсэн, харвасан, шигдээс болсон, эрчимт эмчилгээ шаардлагатай яаралтай тусламжийн хүмүүсийг Улаанбаатар луу зөөхгүй байхад аймаг бүр дээр юу хийх вэ гэдэг тусгай детальчилсан төлөвлөгөө гараад, тэр төлөвлөгөөний дагуу хийгдэнэ. Жишээлбэл зарим аймагт эмнэлэг нь болохгүй болчихсон байх жишээтэй. Жишээлбэл Өвөрхангай бол ерөөсөө болохгүй байна. Тийм учраас тэнд эмнэлэг барина. Жишээлбэл өөр аймагт зөвхөн яаралтай тусламжийн хэсэг нь байхгүй учраас тэр хүзүүвчийг нь бариад яаралтай тусламжийн хэсгийг бариад хүзүүвчээр эмнэлэгтэй холбож өгнө. Дотор нь бүх аймгуудад эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжөө, сургалтаа, дээрээс нь явуулын машин гээд байгаа. Түргэн тусламжийн энэ тогтолцоог бүх аймгуудад хүртээмжтэй болгоод сумаасаа иргэдээ аваад явчихдаг, аймгаасаа Улаанбаатар луу ирүүлэхгүй байх тэр тогтолцоог хийх зорилготой. Тийм учраас би танд бардам хэлж чадна. Ямар нэгэн алагчлал эсвэл улс төрийн өнгө аяс энд байхгүй. Цэвэр эрүүл мэндийн тусламжийг хүргэхийн төлөө ажиллаж байгаа хөтөлбөр гэдгээ хариуцлагатай хэлье.

Р.Сэддорж: Наранбаяр сайд тодорхой хариулаарай.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ Азийн хөгжлийн банкны яг энэ хөнгөлөлттэй зээлээр 41 сургууль, цэцэрлэгийн барилга байсан. 32 нь сургууль, 19 цэцэрлэг байсан. Энэ дээр бол 17 байршил нь Улаанбаатарт, үлдсэн нь орон нутгууд байсан юм. Тэгээд бас Лувсанжамц гишүүн өөрөө бас судалгаа хийж үзээд, 19-ийг нь Улаанбаатар дээр тавих шаардлагатай гэсэн байна. Тэгэхээр үнэхээрийн Улаанбаатар хот дээр бол хүн амын төвлөрөл бол маш их байгаа. Энэ утгаараа бас байж болох хувилбар гэж харж байна.

Нөгөө талдаа тэр зайнаас хамаарсан өртгийн тооцоо байхгүй юу гээд. Энэ 2024 оны жишиг нормативаар нь тооцоод гаргачихсан байгаа. Тэгээд Азийн хөгжлийн банктай ерөнхий хэлэлцээрээ байгуулсны дараа тухайн байршил болгоноор нь бас төсвөө ярьж, баталж эхэлнэ. Тэгэхээрээ тэр дээр бол илүү нарийвчилсан төсөв нь гарна гэсэн ийм ойлголттой байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Тулга гишүүнийг нэмье. Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад Наранбаяр сайд бараг хариулчихлаа даа. Би зүгээр нэмэлт мэдээлэл өгье. энэ удаа чинь ерөнхий хэлэлцээр шүү. Ерөнхий хэлэлцээр. Ерөнхий хэлэлцээрийг Их Хурлаар соёрхон баталсны дараа төсөл бүрээр тусгайлан хэлэлцээр дээр ордог. Тэгэхээр тэр үед яг хэлэлцээрийн эцсийн магадлан хийгдсэн дүн Азийн хөгжлийн банкнаас тавьдаг шаардлага,

дүрмийн дагуу хийгдэж тавигдана. Энэ жилийн хувьд яг төсөв дээр 3 сургууль, 2 цэцэрлэг, 2 дотуур байр орсон байгаа.

Боловсролын жил гээд одоо яг бэлэн байдал хангасан, зураг төсөв нь хийгдчихсэн, нарийн магадлал нь яг таны хэлж байгаагаар газар зүйн байрлалын хувьд бүр яг хааш нь харуулж барих вэ гэдгийгээ эцэслээд гаргачихсан, шууд тендер зарлахад бэлэн төслүүдээ гаргаад ир гэхээр манай салбараас жишээ нь яг л ийм л тоо гарч ирж байгаа байхгүй юу. 3 сургууль, 2 цэцэрлэг, 2 дотуур байр. Нэмээд тавья ч гэсэн байхгүй. Тэгэхээр бэлэн байдлаа хангаж чадаагүй .../минут дуусав/

Р.Сэддорж: Нэмээд 1 минут Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тэгэхээр нэмэлт нэгэнт ийм боломж эх үүсвэр гарч ирж байгаа учраас тийшээгээ оруулъя гэхээр тэнд чинь одоо байгаа жишиг, нэг хэвшмэл тийм зураг төсвөөр төсөөллөөр оруулж ирж, ерөнхий хэлэлцээрээ хийж аваад, тэгээд дараагийн шатын тусгайлан хэлэлцээр лүүгээ л явдаг дараалалтай юм байгаа юм.

Р.Сэддорж: 1 Минут Очирбат гишүүн.

Г.Очирбат: Эрүүл мэндийн салбарынхан маань үнэхээр сайхан судалгаатай байгаа юм байна. Тэгвэл энэ ерөнхий энэ гэрээн дээрээ тавьчихсан аймгууд дээр хойд талд нь үнийн дүнг нь тавьчихаарай. Бид энд бодлого ярьж байгаа. Бодлого ярьж байвал бодлого яаж очиж хэрэгжиж байна гэхээр төсвийн хөрөнгө оруулалт буюу энэ гадаад, дотоодын зээл тусламжаар иргэдэд очиж үр дүн нь гарч байгаа. Тэгэхээр таны яриад байгаа судалгаа чинь энэ дээр бол харагдахгүй байгаад байгаа юм. 1 ч тоо байхгүй. Зүгээр нэр тавьчихсан. Би бол тэгж харж байгаа шүү Чинбүрэн сайд аа. Тэгэхээр энэ дээрээ тоонуудаа тавьчихаарай гэж хэлэх гэж байгаа юм.

2 гэх юм бол энэ ерөнхий хэлэлцээр гэсний дараа дандаа янз бүрийн асуудал явж байгаа шүү. Ерөнхий хэлэлцээр гээд оруулаад ирдэг. Соёрхон батлуулчихдаг. Ерөнхий том дүнгээрээ 475 сая төгрөгийг авчихдаг засаг. 1,7 их наяд төгрөг гээд тодотгоод байгаа шүү би. Авчихдаг, тэгэнгүүтээ тэрний захиран зарцуулалт дээр тэгээд Жавхлан сайд яг үнэнээ л хэлж байна шүү дээ. Боловсролын яам ажлаа хийгээгүй л байна шүү дээ. Саналаа өг гэхээр 3 сургууль, 3 цэцэрлэг л байсан байна шүү дээ. Тэгээд өмнөөс хараад сууж байгаа гишүүд сонгогдсон тойрог болгон дээр асуудал байна. Тэнд боловсрол байх.../минут дуусав/

Р.Сэддорж: Хэн хариулах вэ. Наранбаяр сайд хариулаарай.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ ийм юутай юм. Бид бас жишиг зураг гэж гаргаж ирж, жишиг зургаар явсан ийм түүх бий. Тэгээд энэ жишиг зурагтай явснаас болоод тэр төсөв янз бүрээр хөдлөөд сургуулийн барилга, цэцэрлэгийн барилга дээр 3 жилээс илүү он дамначихсан ийм тохиолдлууд гараад байгаа юм. Тийм учраас сургууль болгон зураг төсөвтэй өөрийн тухайлсан зураг төсөвтэй байхыг Сангийн яамнаас шаардсаны дагуу ийм бас жишиг зургаар явж байсан. Ийм түүх бий. Тэр нь онцгүй, тийм гашуун түүх болчихсон байдаг. Энэ ерөнхий хэлэлцээр учраас энэ дээр бас зарим нэгэн сургуулийн хүчин чадлыг бууруулах ч юм уу ярилцаад, бас энд онцгой шаардлагатай байгаа газруудад зураг төсөв нь хэрвээ боловсруулагдаж байвал, амжихаар бол оруулаад явъя л даа. Ингээд явахад болно. Боломжтой. Жишээлбэл Дорнод аймагт би өөрөө очиж үзсэн. Үнэхээрийн шаардлага хэрэгцээ өндөр байгаа. Гэтэл зураг төсөв нь байхгүй болсноос болоод энэ удаад орж чадаагүй яваад байгаа юм. Энийг бид оруулж .../минут дуусав/

Р.Сэддорж: Ерөнхий хэлэлцээр явж байгаа юм байна. Тулга гишүүнийг нэмээрэй. Заяабал гишүүнийг нэмээрэй. Үг хамт явж байгаа. Одоо Болдын Уянга гишүүн.

Б.Уянга: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Түрүүн бид нар 2026 оныхоо төсөвтэй холбоотой хэлэлцүүлгийг хийлээ. Тэгээд энэ жил бол хэлэлцүүлэг 5 удаа, 5 үе шаттай болсон гэж ойлгож байгаа. Тэгээд зүгээр 1 зүйлийг өөрийнхөө асуултынхаа өмнө заавал хэлье гэж бодсон юм.

Эдийн засгийн байнгын хороон дээр өнөөдөр л бид нар дандаа л ажил ярьж байна шүү дээ. Тэгээд л тэгэнгүүт яг дундуур нь ороод, зарим залуу гишүүд маань маш их улс төржөөд байгаа нь ерөөсөө онцгүй байна. Урьд өмнө нь Байнгын хороонууд хэдхэн гишүүдтэй хуралдаад л байдаг байсан шүү дээ. Тэгээд л өнөөдөр 1 нам нь асуудалтай харагдангуут дэвсэж орж ирээд л, ядаж залуучууд арай өөр байвал зүгээр юм шиг. Тэгээд энэ дээр цааш цаашдаа бүгдээрээ тал талдаа анхаарах хэрэгтэй гэж хэлмээр байна.

Одоо бас бид нар их л чухал зүйлийн талаар ярьж байна шүү дээ. 475 сая долларын 1,7 их наяд гээд сая Очирбат гишүүн хэллээ. Яг энэ зээлийн доторх агуулгууд нь ямар байгаа юм бэ гэдгийгээ ингээд л ярьж байна. Бас л чухал сэдэв шүү дээ. Тэгээд л байхгүй л байх юм зарим гишүүд. Тэгээд энэ дээр яах вэ өмнө нь Эдийн засгийн байнгын хорооны хурал дээр асуулт, саналуудаа авчихсан байсан учраас тэгээд цаашаа нэлээн ухаад харах ийм боломж бүрдлээ л дээ.

Тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан байна уу. 3 дахь асуудал нь энэ Азийн хөгжлийн банк хоорондох санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрт Монгол Улсын ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэх 20 сая доллар тавигдсан байгаа байхгүй юу. Энэ дотор нь яг юу байгаа юм бэ гээд цаг байсан юм чинь мэдээж харж байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөцийн ур чадварыг л хөгжүүлнэ гэж оржээ. Ухаалаг технологи, инновацыг нэвтрүүлэх мэргэжлийн болон техникийн боловсролын төрөлжсөн гэсэн жишиг сургалт энэ тэр гээд. Тэгээд тэр яамнаас хүн байна уу. Энэ 20 сая долларын задаргааг асуумаар байх юм. Тэгээд одоо байхгүй бол яаж дэмжих юм. Яагаад зөвхөн Хөдөө аж ахуйн яам дээр яг энэ агуулга дээр нь 20 сая доллар тавьсан юм. Өөр бусад газрууд нь яачихсан юм. Шууд боловсролынхоо салбар гээд тавивал яадаг юм ер нь. Яг энэ ерөнхий зээлийн гэрээний энэ задаргаа дээр Эрүүл мэндийн яам дээр бол хэлэх зүйл байхгүй. Угаасаа түрүүний удаа нэлээн судалгаатай байгааг нь харсан. Боловсролын яам дээр бол тэгээд л Лувсанжамц гишүүний л саналыг дагачихмаар байх юм. Судалгаа нь байна шүү дээ. Ийм саналтай байна. Тэгээд Хөдөө аж ахуйн яамны холбогдох мэргэжилтнээс энэ 20 сая долларын задаргааг л асуучихмаар байх юм. Политехник коллеж барина л гэхчхэн байх шиг байх юм.

Р.Сэддорж: Буяагийн Тулга гишүүн. Хариулт Сангийн яам хариулаарай. 2 номер.

Х.Батжаргал: Уянга гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Батжаргал. Тэгэхээр энэ хөдөө аж ахуйн салбар дахь хүний нөөцийн дутагдлыг арилгах чиглэлээр боловсролын салбарт хэрэгжих ийм төлөвлөлт хийгдсэн байгаа. Өөрөөр хэлэх юм бол хамгийн их хүний нөөцийн дутагдал хөдөө аж ахуйн салбар, тэр тусмаа хөдөө аж ахуйн салбар өөрөө хамгийн их хүний нөөцийг шингээдэг салбар. Тэгээд богино хугацааны сургалтуудыг хийх, тэнд шаардлагатай байгаа ду дадлагын баазыг бэлтгэх, хамгийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглох,

мэргэжлийн болон Политехникийн коллежийн энэ үйл ажиллагаа, дэд бүтцийг сайжруулах энэ чиглэлээр явагдаж байгаа. Тэгээд өөрөөр хэлэх юм бол хөдөө аж ахуйн салбар тэргүүлэх чиглэл тэр дотроо байршлын хувьд бол төвийн бүсийг голчилж түлхүү анхаарч хөгжүүлэхээр тусгасан ийм төсөл байгаа.

Задаргаа асуусан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ төвийн бүсэд политехник коллежийг хөгжүүлэх дэд бүтцийг нь барих, дадлагын баазуудыг барих, хөдөө аж ахуйн ажиллах хүчний сургалтын хөтөлбөрийг сайжруулах, хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлтийн дүн шинжилгээ дээр үндэслэсэн үйл ажиллагааг бэхжүүлэх гэх зэрэг ажлуудыг төлөвлөсөн байгаа.

Р.Сэддорж: Болдын Уянга гишүүн тодруулж асууна.

Б.Уянга: Боловсролын яам яам дээрх төсөл гэж ойлголоо. Яг энэ политехник коллеж бий болгоно энэ тэр гэсэн том яг зорилтот ажлууд байсан учраас задаргааг нь харахыг хүссэн юм. Тэгэхээр энийг бичгээр ирүүлэхийг хүсье.

Р.Сэддорж: Буяагийн Тулга гишүүн.

Б.Тулга: Та бүгдийнхээ энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхээр Азийн хөгжлийн банкнаас авах энэ ерөнхий хэлэлцээрийг бол Засгийн газар, Засгийн газрын холбогдох байгууллагууд зээл авч байгаа Азийн хөгжлийн банк гээд олон улсын банк, санхүүгийн байгууллага гээд маш олон удаагийн хэлэлцээрийн үр дүнд бол та бидний өмнө батлагдахаар орж ирсэн байгаа.

Тийм учраас эрхэм гишүүддээ бас энэ удаагийн зээлийн ерөнхий хэлэлцээрийг дэмжиж саналаа өгнө үү гэж уриалмаар байна. Яагаад гэвэл бид нар төсөв дээр сая төсөв үүний өмнө ярилаа. Төсөв дээр энэ олон сургууль, цэцэрлэг хэрэгтэй байгаа эрүүл мэнд, хөдөө аж ахуйн политехникийн коллеж гээд энэ зүйлүүдийг бид нар төсөвт нэгэнт суулгаж чадахгүй байгаа. Тийм учраас нэгэнт өнөөдрийг хүртэл хийгээд ирсэн яриа хэлэлцээрийг Байнгын хороо чуулган дээрээ баталж өгөөд, харин энэ Сангийн яам, Боловсролын яам энэ гишүүдийн хэлээд байгаа энэ хаана, хаана ямар байдлаар эрэмбэлж бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг хийх вэ гэдгээ илүү сайн нарийвчилж тохироод явах нь зөв байх гэсэн ийм уриалгыг бас хэлмээр байна. Яагаад гэвэл энэ дээр бид нар унагаачихдаг. Энэ дээр бид нар хойшлуулчихдаг. Гадна талын байгууллага бид нарын энэ унагааж байгаа, хойшлуулж байгааг бол бид шиг сонсоод хүлээхгүй шүү дээ. Дахиад л 1, 2 жилээр хойш нь шийдчихнэ. Тийм учраас энийг бас бүгдээрээ нухацтай авч үзээд, шийдвэрээ гаргаасай гэж уриалж байна. Энийг хэлэх гэсэн юм.

Р.Сэддорж: Батжаргалын Заяабал гишүүн.

Б.Заяабал: Баярлалаа. Тэгэхээр энэ 475 сая долларын ийм нийгмийн шинж чанартай зээлийн асуудал орж ирж байгаа. Энийг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгээд би зүгээр эндээс тодруулаад доторх юмыг нь асуумаар байна л даа. Эрүүл мэндийн чиглэл, ялангуяа орон нутгийн эмнэлгүүдийг нэлээн чадавхжуулах, оношилгоог нь дээшлүүлэх, оношилгоогоо зөв тавьдаг ийм чадвартай болгох үүднээс нэлээдгүй дэмжлэг очиж байна гэж ингэж үзэж байгаа. Тэгээд энэ дээрээ та бас тодорхой бас хариулж өгөөч ээ. Хөдөөгийн нэгдсэн 6 эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийг тоног төхөөрөмжөөр хангана гэхихсэн байна. Тоног төхөөрөмжөөр тоноглогдсон түргэн тусламжийн автомашин, явуулын эмнэлгийн автомашинаар хангана гэхихсэн байна гэх мэтчилэн энэ ажлууд нь яг ямар ямар аймгуудад яаж

яаж хуваарилагдсан бэ гэдэг талаар бас дэлгэрэнгүй мэдээлэл 1 дүгээрт өгөхийг хүсэж байна.

2 дугаарт нь Наранбаяр сайдаас боловсролын тавигдсан 32 сургууль, 9 цэцэрлэг гээд байдаг. Үүний чинь тавьчихсан энэ төсөвт өртөг нь одоо хийгдэж байгаа зураг төсвөөсөө өөр байгаад байх юм. Жишээлбэл Увс аймгийн Зүүнговь сумд та нар 7,7 тэрбум төгрөгөөр сургууль барина гээд тавьчихсан. Хийгдсэн зураг төсвөөр энэ чинь 9,7 тэрбум болчихоод байна шүү дээ. Тэгээд 7,7-г чинь хууль дээр байгаа 15 хувийг нь нэмэгдүүлээд тавих гэхээр 8,8 болчих гээд байдаг. Дахиад цаана нь 1,5, 1,6 тэрбум төгрөгийн дутагдалтай, дахиад л нөгөө царцсан барилга чинь болж хувирчих гээд байна. Энэ дээрээ та тодорхой бас хариултыг өгөөч ээ. Тэгээд бусад чиглэлтэй энэ хийгдэж байгаа онцгой гэх мэтчилэн бусад газрууд дээр хийгдэж байгаа бас ажлууд байгаа юм байна. Энэ дээрээ хүрз, жоотуу гэхээсээ илүү яг дэлхийн энэ онцгой байдалд хэрэглэгддэг тоног төхөөрөмж доороо нь юу байдаг юм ийм тоног төхөөрөмж авна гэж бас итгэж найдаж байгаа. Энэ дээрээ бас яг ямар тоног төхөөрөмж авахаар байгаа юм бэ гэсэн ийм мэдээллүүдийг бас дэлгэрэнгүй өгөөч ээ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр бид энэ байршлуудаа эхлээд жишиг нормативаар тавьчихсан байгаа. Одоо ерөнхий хэлэлцээр батлагдсаны дараа Азийн хөгжлийн банктэй бүх төсвүүдийг нарийвчилж гаргана. Тэр үедээ бол бүхий л яг тэр сургуулиа маш хурдан хугацаанд тэр цэцэрлэгээ хурдан хугацаанд дуусгах энэ бүхий л төсвүүдийг нь тавьж ингэж өгөх юм байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ дээр бол бид хэлэлцэх явцдаа бүх төсвүүдийг, нэмэлт төсвүүдийг ч гэсэн оруулж ирж хийх боломжтой гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл ерөнхий хэлэлцээр байгуулагдсаны дараа сургууль тус бүр, төсөл тус бүрээр нь хэлэлцээр байгуулагдаад явна. Ийм юутай байгаа. Энэ мөнгө бол нөгөө дотор нь хөдөлгөх янз бүрийн санхүүгийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх замаар мөнгийг нь бол хүргэнэ гэж харж байгаа юм.

Р.Сэддорж: Тэгээд хамгийн гол нь хүүгийн асуудал байгаа. Бид нарын болгоомжлох юм бол тэр л байгаа. Тэгээд дотроо хөдөлгөх юм бол дараа нь яригдах юм байна л даа. Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. Энэ хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүд гэдэг маань хүн амын тоо ихтэй, тэр дотроо мэс заслын тусламж шаардлагатай байгаа учраас 6 хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт тус бүр мэс заслын тоноглол, тоног төхөөрөмж, байр савыг нь барих, дээрээс нь өнгөрсөн хэлэлцүүлэг дээр бас гишүүд та бүгдээс хэлж байсан зүйл бол ер нь энэ хилийн боомтын нэвтрэлтийг бас сайжруулахад анхаараарай гэж байсан. Мөн авто замын урсгал ихтэй, уулзвар ихтэй, гэмтэл осол гарах магадлалтай гэдэг. Ерөөсөө л энэ чинь бид нөгөө яаралтай тусламжийг л түргэн хүргэх гээд байгаа том зорилго тавьж байгаа. Тэр утгаараа тэр нөхцөлүүдийг хангасан байх нөхцөлүүдийг л тавиад байгаа. Тэгээд бид нар апдэйт хийгээд яваад байна. Мэдээж сая Наранбаяр сайдын хэлдгээр ерөнхий хэлэлцээр батлагдсаны дараагаар бид дахин due diligence буюу нөхцөл байдлын үнэлгээ хийгээд яг хаана нь хэн, юу хийж байж бид энэ нас баралтыг бууруулах юм бэ, эмнэлгийн тусламж урьдчилж хамгаалж болох нас баралтыг бууруулахад юу юу хийх юм бэ гэдэг бол нэлээн тийм..../минут дуусав/

Р.Сэддорж: Чинбүрэн сайд 1 минут гүйцээж хариулъя.

Ж.Чинбүрэн: Жишээлбэл та энэ жагсаалтыг анзаарсан бол 17 эмнэлэг гээд байгаа аймгийн нэгдсэн эмнэлэг. Жишээлбэл түрүүн би хэлсэн Ховд, Увсад хийчихсэн. Одоо Дарханд том нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа баригдах ажил явагдаж байна. Азийн хөгжлийн банкны төслөөр гэх мэтчилний давхацуулахгүйгээр тэгээд энэ чинь та бүхэн бас нэг зүйлийг ойлгоорой. Дандаа байшин барих төсөл биш шүү. Нөгөө яаралтай тусламж, эрчимт эмчилгээ төрөлжсөн харвалт шигдээсний тусламжийг сайжруулахад л дутуу байгаа зүйлүүдийг л гүйцээх ийм зорилготой. Зарим газар нь бол яаралтай тусламжийн тасгийг нь барьж өгөх, зарим газар нь хагалгааны хэсэг байхгүй газрууд байна шүү дээ. Зарим эмнэлгүүдэд СТ хүртэл байхгүй газрууд байж байна. Ангиографи хийж чадахгүй, зүрхний шигдээсээ аварч чадахгүй газрууд байж байна. Ингээд бүгдийг нь төрөлжөөд саяын ярьсан тусламж үйлчилгээг яаралтай тусламж, эрчимт эмчилгээг бүрдүүлэх тогтолцоог хийнэ. Ер нь бол 21 аймагтаа эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, зүрхний шигдээс, харвалтаас болоод Улаанбаатар луу ирдэггүй байх энэ үндсэн нөхцөлийг бүрдүүлнэ.

Р.Сэддорж: Ажлын хэсгийн 3 номер. Онгой байдлын ерөнхий газрын дарга Ариунбуян.

Г.Ариунбуян: Заяабал гишүүний асуултад хариулъя. Онцгой байдлын ерөнхий газар, хошууч генерал Ариунбуян илтгэж байна. Энэ төсөл хэрэгжсэнээр онцгой байдлын албанд тулгамдаж байгаа нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн тусгай зориулалтын хувцас хэрэглэл, хангамжийг бол тодорхой хувиар нэмэгдүүлнэ. Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр бол албаны хэмжээнд нийт хангамж 57 орчим хувьтай байгаа. Төсөл хэрэгжсэнээс 81 орчим хувьд хүрнэ гэж бид бүхэн тооцоолж байна. Гишүүний хэлсэнчлэн тэр нисгэгчгүй нисэх төхөөрөмж, дрон гээд сүүлийн үеийн дэвшилт техник технологийн хувьд бол өнөөдрийн байдлаар 43 хувийн хангалттай байгаа. Төслийн хүрээнд бас тодорхой тооны төхөөрөмжүүдийг нийлүүлж, 51 хувьтай болохоор бид нар бас тооцоолоод төслөө боловсруулсан байгаа.

Р.Сэддорж: Заяабал гишүүн тодруулж асууя.

Б.Заяабал: Наранбаяр сайд аа, тэгээд 130 сая доллар л байгаа шүү дээ боловсрол дээр чинь. 32 сургууль, 9 цэцэрлэг гээд биччихсэн. Тэгээд эд нарыг чинь эхнээсээ эхлүүлээд зураг төсөв нь хийгдэхээр хүрэхгүй байна гэдэг юм яригдаж байна шүү дээ. 7,7 тавьчихсан. Бодит амьдрал дээр 9,7 болоод 2 тэрбумаар дутуу тавьчихсан байна. Та дотор нь гүйлгэнэ гээд байна. Тэгэхээр энэ 32 сургуулиас чинь хасагдана гэсэн үг юм уу. 9 цэцэрлэгээс чинь хасагдана гэсэн үг юм уу. Тэрийгээ тодорхой хэлж өгөөч.

2 дугаарт Чинбүрэн сайд энэ хийх гэж байгаа энэ автомашин, тоноглогдсон автомашинаар түргэн тусламжийн автомашинаар хангана гээд байна. Яг ямар ямар сумууд дээр ямар ямар аймгийн ямар ямар сумууд дээр хангахаар байгаа юм бэ. Энийгээ тодорхой хэлж өгөөч. Тэгээд энд тэнд очоод, миний төсвөөр ийм юм хийж байгаа гээд л дураараа яриад эхэлдэг шүү дээ. Энэ юмнуудаа тодорхой тавимаар байна шүү дээ. Тодорхой мэдээлэл өгмөөр байна шүү дээ. Ерөнхий явдаг, тэгээд сайд нар үзэмжээрээ шийддэг ийм зүйл баймааргүй байна. Энэ нь өөрөө төсвийн хуулийг бас зөрчиж байгаа асуудал шүү дээ.

Р.Сэддорж: Чинбүрэн сайд, дараа нь Наранбаяр сайд.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр өмнөх төслүүдийн хүрээнд 170 сумыг явуулын автомашин буюу түргэн тусламжийн тусгай тоногдсон машинаар хангачихсан юм. Үүний үлдэгдэл 105-ийг нэмж хангах гэж байгаа. Тэгэхээр нөгөө өмнөх төслүүд нь хоорондоо уялдаа, шүтэлцээтэй шүү. Дээрээс нь ерөөсөө шалгахад их амархан. Сумууд ийм зориулалтын машинтай болж чадсан уу л гэдэг. Энэ төсөл хэрэгжсэнээр өмнөх төслүүдтэйгээ уялдаад, бүх 330 сум маань явдаг түргэн тусламжийн машинтай, тэр нь интернэттэй, дотроо хүнээ тээвэрлэхдээ веб камер зөвлөгөө аваад, хүнээ аймаг дээр аваачна. Аймаг нь ямар хүн ирж байгааг мэдээд бэлтгэлээ хангачихсан хүлээгээд байж байдаг ийм тогтолцоог хийх гэж байгаа юм. Тэгэхээр бол өмнө нь хангаагүй сумуудаа автомашинаар хангана. Явуулын зориулалтын түргэн тусламжийн машин. Гаралгүй яах вэ, гарчихсан. Өмнөх нь өгчихсөн учраас тэр тооцоолол .../минут дуусав/

Р.Сэддорж: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэгэхээр Заяабал гишүүний яг санаа зовоод байгаа нь үнэн. Тэгэхээр бид бас энэ ерөнхий хэлэлцээрийн дараа төсөл тус бүрээр нь хэлэлцээр хийхэд энэ асуудлыг шийдээд явах боломжтой гэж харж байгаа. 2, 3 ийм арга зам байгаа. 1 нь бол Юнескогийн зүгээс нэмэлт санхүүжилт оруулж ирэхээр ярьж байгаа. Дутагдсан хэсэг дээр нь дэд бүтцийг нь илүү шилдэг технологи, пассив хаусын технологи тал дээр нь бол хөрөнгөө оруулна гэж.

2 дугаарт бол бид бас дэд бүтцийн холболтыг нь бол төсвөөс гаргахаар ингэж Сангийн яамтай ярилцаж, шийдвэрлэж байгаа. Тэгэхээр зэрэг бас дотор нь бас 960-тай сургуулиудыг 640 болгож бууруулж, бусад сургуулиуд руу нь өг гэсэн ийм шаардлагыг бас Азийн хөгжлийн банкнаас бас эхнээсээ тавьж эхэлж байгаа. Ийм байдлаар ямар ч байсан энэ сургуулиудаа бүгдийг нь барьж дуусгах хөрөнгийн эх үүсвэрийг бол бий болгоно гэж харж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Миний хувьд бол тэр зээлийн хүүг л асуумаар байгаа юм. Зээлийн хүү зориулалтын хувьд бол хамгийн чухал зориулалттай байна. Энэ нь бол ерөнхий хэлэлцээр учраас дараа нь бол нарийвчилсан тэр хуваарилалтууд хийгдэх юм байна. Тийм учраас зээлийн хүүгийн талаар хугацааны талаар хариулж өгөөч ээ. 1 номер.

С.Тулга: Сангийн яам Тулгаа. Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Энэ 475 саяын эх үүсвэр маань 2 өөр төрлийн эх үүсвэрээс орж ирж байгаа. 243,8 сая доллар нь бол Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй эх үүсвэр байгаа. Энэ нь бол зээлийн хүү нь бол 2 хувь тогтмол байна. Тэгээд хугацааны хувьд бол 25 жил, эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх ийм нөхцөлтэй орж ирж байгаа. Дараагийн энгийн нөхцөл нь 231,2 сая ам.доллар байгаа. Энэ нь болохоор зээлийн хүү нь софер дээр нэмэх нь 0,6 хувь ийм хөвөгч хүүтэй орж ирж байгаа. Өнөөдрийн хувьд бол софер маань 4,2 хувьтай. Тэгээд 0,6 гэхээр одоогийн байдлаар 4,8 хувийн хүүтэй ийм зээл байгаа. Хугацааны хувьд бол мөн адил 25 жил, эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөхөөр ийм байгаа.

Р.Сэддорж: Жавхлан сайд.

Б.Жавхлан: Очирбат гишүүний асуултад хариулъя. Монгол Улс нөгөө буурай орныхоо ангиллаас гараад, хөгжиж байгаа орны ангилалд орчихсон шүү. Дунд хэмжээний, дунд талынхаа дээд талд нь гарчихсан явж байгаа. Тэгэхээр цаашдаа

бидэнд энэ нэн хөнгөлөлттэй зээл улам ховордоно. Олдохгүй болно гэсэн үг. Ийм зээл авдаг ангиллаасаа бид нар гараад явчихсан. Гарч яваад 3 жил болж байгаа. Тэгэхээр харин энэ удаа бид ийм холимог зээл авч чадаж байгаа нь харин бас нэг талаараа сайн үзүүлэлт юм. Ямар ч байсан талаас арай багагүй өндөр хэмжээтэй нь нэн хөнгөлөлттэй ийм зээлээрээ авч байна. Арилжааны зээлийг бол бид авахаас өөр арга байхгүй. Гэхдээ арилжааны зээл маань софер дээр нэмэх нь 0,5 гэдэг 4,7 манай Засгийн газрын өөрийн бенч марк софер дээр нэмэх нь 2,2 байгаа. Үүнээсээ доогуур ийм байгаа нь бол одоо бидэнд олдож байгаа хамгийн хөнгөлөлттэй зээл л энэ байгаа гэсэн үг.

Р.Сэддорж: Байнгын хорооны гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт бэлдэж байх хооронд Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Сая асуулт дээрээ Мийгаа даргаас, Их Хурлын Тамгын газраас асуусан. Заяабал гишүүн бас сая хэлж байна. Яг хаана сургууль, цэцэрлэг, эмнэлэг тэрийг нь тодорхой болгомоор байна. Энэ 41 сургууль, цэцэрлэгийг нь одоо байгааг нь биш, өнөөдөр миний тараасан бичгийн дагуу шинэчилмээр байна. Дэгийн тухай хуулийн 76.3.2, 76.6.2-ын дагуу энэ хэлэлцээрийн төсөлд засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж байгаа. Тэгэхээр Мийгаа даргын хэлж байгаагаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр зөвхөн санал, дүгнэлт хэлбэрээр орно гэж хэлээд байгаа. Тэрийгээ та нэг тодорхой болгож өгмөөр байна. Би санал гаргах юм уу, эсвэл энийг нь зүгээр бичгээр санал, дүгнэлт гарахаар Засгийн газраас өөрсдөө энэ агуулгыг нь шинэчлэх юм уу. 76.8-д заасны дагуу Засгийн газар дахин засвар хийгээд оруулж ирэхээр буцааж болно гэж байгаа шүү дээ. Энэ дээр яг тодорхой хариулт өгөөд, нөхцөлтэйгөөр дэмжмээр байна гэдгийг манай Байнгын хорооны гишүүд маань бүгд сая хэлсэн шүү дээ.

Р.Сэддорж: Ажлын албаны микрофоныг өгье. Та чинь ажлын албанаас асуугаад байгаа биз дээ тийм ээ. Би бол түрүүн хариулчихсан шүү дээ.

Д.Мягмарцэрэн: Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Мягмарцэрэн байна. Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйл дээр зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан зөвшилцөх асуудлыг зохицуулсан байгаа. 76.1 дээр гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээний тухайд гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл эсхүл эх бичвэрийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ гэсэн байгаа. Энэ тэгэхээр манай Байнгын хорооны хувьд бол ямар нэгэн тусгайлсан саналын томьёолол гаргаж, санал хураалт явагдахгүй. Энэ гэрээний нөхцөлийг дэмжсэн, дэмжээгүй талаарх санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ. Чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 76.6 дээр Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл эсхүл эх бичвэрийн талаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана гэж байгаа. Энэ дээр яг Лувсанжамц гишүүний асуусан энэ 76.6.2 дахь заалтаар бол баталсан буюу жинхэлсэн олон талт гэрээний эх бичвэрээс бусад олон улсын гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй

тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр таны санал бол Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтэд зүгээр тусгагдаад, Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд очно. Тэр хамтарсан Байнгын хорооны хуралдаанаар таны саналыг бас Засгийн газарт хүргүүлнэ л гэсэн үг. Тэрнээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргаад, санал хураалгах энэ тэр тийм юунууд бол байхгүй байгаа.

Р.Сэддорж: Пунсалмаа гишүүн, Очирбат гишүүн, Бадамсүрэн гишүүн санал хураалтад бэлдье. Бадамсүрэн гишүүнийх орохгүй байна.

Тэгээд энэ протоколд бол бүр хэлсэн үг болгон протокол дээр үлдэж байгаа. Энэ дээр яг өөрчилж болно гэж Сангийн сайд хэллээ. Сайд нар хэллээ. Санал хураалт явуулъя.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах “Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулах санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Ганбатын Очирбат танилцуулна. Хөтөлбөрийн төслийг хэлэлцэж дууслаа.

13.35 цаг.

Дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайланг Монголбанкны Ерөнхийлөгч Бядрангийн Лхагвасүрэн танилцуулна. Лхагвасүрэн Ерөнхийлөгчийн микрофоныг нээе. Ажлын хэсгийн 3 номер.

Б.Лхагвасүрэн: Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрж мэндчилье.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барилаа.

Эдийн засгийн сэргэлт өсөлтийг дунд хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх нь өнгөрсөн жилийн мөнгөний бодлогыг боловсруулахад чухал зарчим, зорилт болж байсан. Энэ удаад ч бодлого, үйл ажиллагааг төлөвлөхөд энэхүү зорилт нь улам бүүр ач холбогдолтой болж байна.

Дэлхий нийтэд цахим шилжилт, олон улсын худалдаа, харилцаанд гарч буй өөрчлөлт, түүний нөлөөгөөр олон улсын мөнгө санхүүгийн тогтолцоо хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалтай уялдуулан эдийн засгийн тогтвортой

байдлыг дунд хугацаанд хадгалах бэхжүүлэхэд чиглэсэн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг боловсруулсан болно.

Монгол Улсын эдийн засаг харьцангуй тогтворжиж, оны эхний хагаст 5,6 хувиар өслөө. Үүнд өнгөрсөн өвөл тохиосон зудын нөлөө арилж, хөдөө аж ахуйн салбар оны эхний хагаст 35,6 хувиар өссөн нь нийт өсөлтийн талаас илүү хувийг бүрдүүлсэн болно. Төмөр зам, орон сууцын барилгын ажил идэвхжиж, барилгын салбар 25,2 хувиар, үйлчилгээний салбар 4,5 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ.

Монголбанкны төсөөллөөр энэ оны сүүлийн хагаст зэсийн олборлолт нэмэгдэх, шинэ төслүүдийн бүтээн байгуулалт эрчимжих зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Улмаар эдийн засгийн өсөлт 2025-2026 онуудад 5-6 хувь тогтвортой өсөх хүлээлттэй байна.

Инфляцыг бууруулж, эдийн засгийг тогтворжуулах зорилгоор авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч, инфляц энэ оны 2-7 сарын хооронд буурсан хэдий ч 8 дугаар сард дотоодын хүнсний үнийн нөлөөгөөр бага хэмжээгээр нэмэгдлээ. Ирэх саруудад хүнсний үнийн нөлөөгөөр инфляц эрчимжиж болзошгүй байгаа ч цаашдаа алгуур буурч 2026 онд зорилтот интервалд орох хүлээлттэй байна. Түүнчлэн төлөвлөсөн бүтээн байгуулалтуудыг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлага хэвээр байна. Дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх нь эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэр алдагдах, төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханш, инфляцын дарамт нэмэгдэх эрсдэлтэйг мөн дурдах нь зүйтэй байх.

Иймд инфляцын зорилтыг хангахад мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, хүнсний бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн доголдлыг технологийн шийдлүүдийг ашиглан шуурхай шийдвэрлэхэд ахиц дэвшил гаргахад анхаарч ажиллах нь чухал байна. Мөн гол нэрийн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтворжуулах нь үнийн савлагааг бууруулж, иргэд, үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчдын бодит орлогыг хамгаалсан, нам тогтвортой түвшний инфляцын орчин бүрдүүлэхэд суурь болохыг бол энд онцлохыг хүсэж байна.

Дэлхий дахинд худалдааны бодлого улс орнуудын харилцаа хурдацтай өөрчлөгдөж байна. Энэ нь глобал эдийн засгийн төлөв манай улсын гадаад эрэлт түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж байгаа. Үүний илрэл нь нүүрсний экспортын орлого оны эхний 8 сард өмнөх жилийн мөн үеэс 2,7 тэрбум доллароор багассанаас харагдаж байна. Гадаад худалдааны эргэлт саарч, урсгал дансны алдагдал тэлж буй энэ үед Засгийн газар, банкнууд болон хувийн секторын гадаад зээл, бондын эх үүсвэр нь гадаад валютын дотогшлох урсгалыг тэтгэж байгаа болно. Төлбөрийн тэнцлийн цаашдын төлөв нь эрдэс бүтээгдэхүүний үнэ, улс орнуудын тарифын бодлого, худалдааны түнш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарах болно.

Манай улсын гадаад худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлт цаашид саарах хүлээлттэй байна. Иймээс нүүрс, төмрийн хүдэр зэрэг эрдэс бүтээгдэхүүний үнийн төлөв өөдрөг биш байна. Экспортын орлого буурч буй энэ үед макро бодлогын оновчтой хослолыг хэрэгжүүлж, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах нь нэн чухал гэдгийг бас энд онцлон дурдъя. Түүнчлэн аливаа томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг гадаад валютын нөөцөд нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр хэрэгжүүлэх нь чухал байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах Үндсэн чиглэл нь нам тогтвортой инфляцын орчныг бүрдүүлэх, банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зээлийн нөхцөлийн эрэлт, нийлүүлэлт талаас нь судалж, бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох, бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд шаардлагатай бодлого зохицуулалтын арга хэмжээг тодорхойлох зэрэг зүйлүүдээр онцгойлон анхаарч боловсруулагдсан болно.

Сүүлийн жилүүдэд нэмэгдээд буй геополитикийн хүндрэлээс үүдэн гадаад эрэлт саарах, экспортын гол түүхий эдийн үнэ хүлээлтээс хурдтай буурах зэрэг нь манай улсын экспортын орлого, валютын дотогшлох урсгалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Түүнчлэн нефтийн нийлүүлэлт саатах, цаг агаарын нөхцөл муудан, өвөлжилт хүндрэх, өвлийн улиралд эрчим хүчний нийлүүлэлтийн тасалдал бий болох зэрэг нь инфляцыг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжилийг сааруулах эрсдэлтэй.

Гадаад, дотоод эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа ч Монголбанк ирэх жилийн инфляцыг 6 /+2/ нэгжийн хувийн интервал тогтворжуулж, 2027 оноос зорилтын голчийг 5 хувь болгож бууруулахад мөнгөний бодлогоо үндсэн чиглэлд тусгалаа. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхэд Засгийн газрын дэмжлэг, төсвийн мөчлөг сөрсөн бодлого голлох үүрэгтэй байх болно.

Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын хүрэлцээг банкны эрсдэлийн түвшинтэй уялдуулан тодорхойлох зорилт бүхий Базелийн стандартын бүлэг 2-ын үнэлгээний аргачлалуудыг туршилтын байдлаар нэвтрүүлж, холбогдох журмыг боловсруулан ажиллалаа.

Цаашид банк өөрийн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүнийг үр ашигтай байдлаар төрөлжүүлэн банкны системийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хяналт шалгалтын олон улсын стандартад бүрэн нийцүүлэхийг зорьж байна.

Мөн банк, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжлэг үзүүлэх хүрээнд иргэдийн санхүү, эдийн засгийн суурь мэдлэг дээшлүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаанд хээл хахууль, ядуурал, улс төрийн байдал, ажилгүйдэл зэрэг нийгэм, улс төрийн хүчин зүйлст ихээр сөрөг нөлөө үзүүлдэг гэж санхүүгийн орчны хүчин зүйлс мөн багагүй сөрөг нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын санхүүжилтийн орчны хувьд 2017 оноос хойш хувийн хэвшилд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү нэг зээлдэгчид оногдох дундаж зээлийн хэмжээ төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Мөн судалгаагаар бизнесийн байгууллагуудад барьцаа хөрөнгийн үнэлгээ доогуур байгаа нь санхүүжилт авахад тулгамдаж буй гол асуудал байна гэж гарсан. Иймд бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд банкны зээл олголтын нөхцөл шаардлагыг судалж, зээлдэгчийн хэрэгцээ салбарын онцлогт нийцсэн зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүрээг өргөжүүлэхэд чиглэж ажиллахаар мөн мөнгөний бодлогоо боловсрууллаа.

Технологийн шинэчлэл, цахим шинэчлэлтийн эрин үед санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, төлбөр тооцооны дэвшилт арга хэрэгслүүд хурдтай нэвтэрч, төв банкны үйл ажиллагаа ч дижитал шилжилтэд хөл нийлүүлэх шаардлагатай болж байна. Иймээс үндэсний төлбөрийн системийн зохицуулалтыг боловсронгуй болгох шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжин ажиллахаар зорьж байна. Түүнчлэн санхүүгийн системийн болзошгүй эрсдэлийг үнэлж удирдахад чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн уян хатан тогтох зарчим олон нийттэй харьцах үйл ажиллагаа болон банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх, мөнгө угаах терроризмыг санхүүжилттэй тэмцэх үндэсний бодлогыг шинэчлэхээр мөн тусгасан болно.

Монголбанкны бодлого, үйл ажиллагаа нь дотоод эдийн засагт ирэх аливаа сөрөг шокийн нөлөөг бууруулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход дэмжлэг үзүүлэхээр чиглэгдсэн болно.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийг дэмжиж баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Лхагвасүрэн Монголбанкны Ерөнхийлөгч, Баярдаваа Мөнгөний бодлогын газрын захирал, Аюуш Хууль, эрх зүйн газрын захирал, Ариунбат Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал, Даваасүх Судалгаа, статистикийн газрын захирал, Энхжин Санхүүгийн зах зээлийн газрын захирал, Анар Төлбөр тооцооны газрын захирал, Борхүү Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын Эрсдэлийн үнэлгээний хэлтсийн захирал.

Танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Батшугар гишүүнээр, Очирбат гишүүнээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Надад 2 асуулт байна.

1 дүгээрт 2025 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр инфляц ер нь хэдэн хувьтай гарна гэж төсөөлж байгаа вэ. Тодорхой тоо хэлээч.

2-т Монголбанкны зүгээс энэ тэтгэврийн зээлтэй холбоотой янз янзын эргэж хургасан шийдвэрүүдийг нэлээн хэдэн удаа гаргалаа. Яагаад энэ тэтгэврийн зээлийн бодлого Монголбанкны хувьд ийм тогтворгүй бодлого болж хувирав. Энэ зээлтэй холбоотой ер нь цаашдаа ямар бодлого барина гэж бодож байгаа юм. Зүгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр би таны өгсөн ярилцлагыг сонссон. Магадгүй хариулт энэ түвшинд ирэх болов уу гээд би бас урьдчилаад хэлчихье. Олон улсын түвшинд таны харьцуулж үзэж байгаа мэргэжлийн эдийн засагчийн хувьд мэргэжлийн банкир хүний хувьд зөв. Дэмжиж байна.

Гэхдээ өнөөдөр бид тэтгэврийн зээлээ олон улсын түвшинд авч үзчихээд, ахуй амьдрал, амьжиргааныхаа түвшнийг яагаад олон улсын түвшинд авч үзэхгүй байгаа юм. Тийм боломжгүй бол яагаад өнөөдөр Монгол Улсын амьдралын чанар, Монгол Улсын ард иргэдийн амьдралын чанар өнөөдөр байгаа нөхцөл байдал энэ хөрсөн дээрээ тохирсон уялдаа холбоотой бодлого хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгээд инфляц оны эхний хагаст бол Монголбанкны бодлогын тэр зорилтот хүрээнд байсан. Сая 8 сарын инфляц арай зорилтоос дээш өндөр гараад эхэлж байгаа. Энэ нь бол шинэ хүнсний ногооны үнэ ханшийн нөлөө бол улирлын шинжтэй маягаар орж ирсэн гэж харж байгаа. Оны төгсгөлд бол инфляц бол 8 хувьд яг энэ хүрээнд д бол гарна гэж төв банкны зүгээс харж байгаа юм. Оны төгсгөл рүүгээ бол инфляц бас буурах ийм хандлага суурь үеийн нөлөө бас байгаа. Түүгээрээ бол 8 хувьтай гарна. 2026 онд бол мэдээж энэ 8 хувьтай тогтворжуулаад, 2027 оноос бол бид голчоо 5 +/-2/ буюу ер нь бол голчийн дээд хэсэг нь бол 7 руу орж ирнэ. Энэ рүү тогтворжино гэж харж байгаа.

Тэтгэврийн зээлтэй холбоотойгоор тэтгэврийн зээл, тэтгэвэр барьцаалсан зээл, тэгээд л ер нь орлого барьцаалсан гэдгээрээ цалин барьцаалсан, эсвэл хадгаламж барьцаалсан энэ зээлийг бол олон улсад бол хэрэглээний зээл гэж явдаг. Энэ тэтгэврийн зээлтэй холбоотой өмнө нь бас нэлээн олон улс төрийн шийдвэрүүд ч гэсэн гарч байсан. Бас тэтгэврийн зээлийг тэглэж байсан ийм тохиолдол байгаа. Тухайн үед бол нийт тэтгэврийн зээлийн хэмжээ бол 700 тэрбумаар бол хэмжигдэж байсан. Тэгээд 700 орчим тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийн үлдэгдлийг тухайн үед бол тэглэж байсан. Тэгээд тухайн үед бас хууль, эрх зүйн талууд дээр өөрчлөлтүүд орж байсан.

Ялангуяа тэтгэврийн зээлийг бол тодорхой 6 сарын хугацаатайгаар жилдээ 1 удаа олгоно ч гэдэг юм уу тийм хуулийн заалт бас үйлчилж байсан. Тэр хуулийн заалт дараа нь бол ковидын хууль байхгүй болоход бол хамт хүчингүй болж байсан. Тэгээд ер нь бол хэрэглээний зээл гэдэг зүйлээрээ ерөнхий стандартад бол оруулж өгч байсан.

Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ тэтгэврийн зээлийг тухайн үед Монголбанканд хүсэлт гаргаж байхад бол нийт өрийн үлдэгдэл нь 2,1 их наяд болж байна. Энэ нь бол бусад хэрэглээний зээлээс бол маш өндөр өсөлттэйгөөр нэмэгдэж байгаа учраас энэ дээр бол бас тодорхой хэмжээнд анхаарахгүй бол энэ асуудал бол цаашаа хүндрэх магадлалтай байна гэдгээрээ хүсэлт тавьж байсан учраас Монголбанк бол хэрэглээний зээлийг бусад зээлтэй адилтгаж, хэрэглээний зээлийн ерөнхий зохицуулалтад оруулсан. Дараа нь бол мэдээж бас тодорхой хүсэлтүүд гарсан учраас дээр нь мөн Их Хурал дээр ч гэсэн энэ асуудал хөндөгдөж ярьсан учраас бол Монголбанкны хувьд тэтгэврийн зээлийг хэрэглээний зээлийн гэсэн ерөнхий зохицуулалтаасаа гаргасан байгаа. Тэгэхээр бол оруулаад, гаргасан ийм зүйл гарсан. Өмнө нь бол хэрэглээний зээл 70/30-ийн харьцаатай явсан. Дараа нь 60/40 болж хатууруулж ирсэн. Өнөөдрийн байдлаар бол хэрэглээний зээлд байдаг ерөнхий зохицуулалт бол өр, орлогын харьцааг 50/50 гэдгээр явж байгаа юм. Тэгээд 50/50 гэдэг харьцаагаар явахад бол тэтгэврийн зээл бас их хүндэрч байгаа гэдэг утгаараа бол гаргасан. Ер нь бол олон улсад тэтгэврийн зээл гэдэг ойлголт байдаггүй. Ер нь бол ийм зээл, бүтээгдэхүүн үйлчилгээ байдаггүй. Ялангуяа Энэтхэг гэдэг юм уу, Индонез гэдэг юм уу, Бразил гэсэн ер нь жоохон тийм ядуу буурай, тийм ойлголттой улсуудад бол ийм зээл бас тодорхой хэмжээнд байдаг гэдгээрээ гардаг юм байна лээ. Бидний судалгаагаар бол ер нь ийм байхгүй учраас ерөнхийдөө тэтгэврийн зээл гэдэг бүтээгдэхүүн Монгол Улсад бол хэрвээ байвал банк нь өөрөө өөрийнхөө дотоод бодлогоор зохицуулаад явж болно гэдгээрээ гаргасан байгаа. Тэгэхээр бол яах вэ хэрэглээний зээлийн зохицуулалтад оруулсан, гаргасан гэдэг л ийм 2 л бодлогын шийдвэр

гарсан. Одоо бол ерөнхийдөө банкнууд бол өөрийнхөө бодлогын хүрээнд бол энэ зээлийг олгоод явж байгаа.

Р.Сэддорж: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Эхний асуулт дээрээ тодруулъя. Төсвийн байнгын хорооноос төсвийн төслийг хэлэлцэж байх хэлэлцүүлэг хийх явцад Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын инфляцын хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг 9,5 гэдэг тоо хэлж байсан. Та бол 8 гэж байна. Тэгэхээр энэ оны төгсгөлд ер нь манай инфляц хэд байх юм бэ. Энийг тодорхой, бодитой гаргаж өгөөч. Яагаад гэвэл бид хуулиараа энэ 2025 оны төсвийн гүйцэтгэл дээр инфляцын түвшинтэй уялдуулж, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх хуулийн үүрэгтэй. Тийм учраас энэ тодорхой тоо байх хэрэгтэй байна.

2 дугаарт тэтгэврийн асуудлаар олон улсын түвшинд харьцуулаад банкнууд өөрсдөө шийдье гээд гаргачихлаа гэж. Би бол энэ шийдвэрээс чинь болоод өнөөдөр цалингийн зээлийн хүүгээс бага байсан тэтгэврийн зээлийн хүү өнөөдөр цалингийн зээлээс өсчихлөө. Тэгээд энэ бодлогыг яагаад орхигдуулж байгаа юм бэ.

Р.Сэддорж: Хариулт 3 номер.

Б.Лхагвасүрэн: Инфляц яг точный тоо гэвэл ер нь 8 хувьтай гарна гэж Монголбанк бол итгэлтэй байгаа. 2023 оны сүүлийн хагасаас инфляц 1 оронтой тоонд орсон. Үүнээс хойш сүүлийн 2 жилийн хугацаанд инфляц хамгийн нам түвшиндээ 4,6 хувь, хамгийн өндөр түвшиндээ 9,6 хувьтай ингэж явж ирээд, дундаж нь бол 7,4 байгаа. Сүүлийн 2 жилийн яг дундаж гэж ярих юм бол 7,4. Тэгэхээр ер нь энэ бол өөрөө Монголбанкны зорилтот хүрээнд байна гэж Монголбанк харж байгаа. Тэгээд оны төгсгөл 10, 11, 12 сард дундаж нь бол 8-тай гарахаар ингэж хүлээгдэж байгаа. Ирэх оны эцэст бол Монголбанкны өнөөдрийн хийж байгаа төсөөлөл бол 6,9, 7 орчим хувьтай байна гэсэн төсөөлөл байгаа.

Тэтгэврийн зээлтэй холбоотойгоор тэр хүү, хугацааны асуудал дээр бол ер нь бол Монголбанк бодлого л гаргадаг ийм институт бодлогын .../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 3 номер.

Б.Лхагвасүрэн: Бодлогын институт. Тэрнээс биш арилжааны банкны яг дотоод үйл ажиллагаа, тэр бүтээгдэхүүн үйлчилгээнийх нь хүү гэдэг юм уу, тийм хүүтэй байх ёстой, тийм хугацаатай байх ёстой, тэгэх ёстой гэж бүх дотоод үйл ажиллагаа оролцдоггүй учраас банк болгон өөр өөрийн л нөхцөл юугаа тавьж бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байгаа.

Р.Сэддорж: Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Асуулт давхацчихлаа. Хариултаа авчихлаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн.

Б.Пунсалмаа: Сайн байцгаана уу. Өнөөдөр энэ арилжааны банкнуудаас энэ аж ахуйн нэгж, хувь хүмүүс зээл авч байгаа нь тун цөөхөн байна. Сүүлийн 10 жилд ер нь их цөөхөн болсон шүү. Тэгээд ер нь арилжааны банкнууд маань өнөөдөр хэнд зээл өгөөд байна гэхээр энэ Шинэ хоршоо, Ногоон хувьсгал, Цагаан алт гээд энэ төслүүдэд зээл олгоод байгаа юм. Тэгээд удалгүй л инфляц хэцүүдлээ гээд,

бодлогын хүүгээ өндөр болгодог. Энэ бодлогын хүү өндөр олгосноороо арилжааны банкнууд төв банкны үнэт цаас хэлбэрээр төв банкандаа мөнгөө байршуулаад байгаа байхгүй юу. Ингэхээр арилжааны банкнуудад хэрэгтэй. Яагаад хэрэгтэй гэхтэй нь зэрэг компани, аж ахуйн нэгжүүдэд зээл олгоод эрсдэл хүлээж байхын оронд энэ төв банк дээрээ өндөр хүүтэй байршуулах нь арилжааны банкнуудад хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгээд аж ахуйн нэгж, хувь хүмүүст зээл олдохгүй байгаад байгаа юм. Тэгэхээр одоо бид нар ер нь цаашдаа энэ асуудлыг ер нь яаж шийдвэрлэх юм. 1 дүгээрт.

2 дугаарт төв банкны үнэт цаас хэлбэрээр ер нь хэдий хэмжээний мөнгө төв банканд төвлөрч байна вэ. Арилжааны банкнуудад ер нь жилдээ хэдий хэмжээний хүү өгч байна. Энэ өгсөн хүү нь сүүлийн 3 жилээр нэгтгээд 1 дүнг нь гаргаж ирэх юм бол хэр хэмжээний үнэт цаасанд хүү өгсөн бэ гэдэг асуудал байна. Тэгээд ер нь Монголбанкандаа, ер нь мөнгөний бодлогын хувьд хэлчихэд байна шүү дээ. Ер нь дандаа инфляц хөөргөлөө гээд энэ мөнгөний ханшийг ингэж чангаруулж байхаар эсрэгээрээ бид нар энэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг задлах, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн энэ хэрэглээ дээр хяналт тавих ийм арга аргачилгаа хэрэглэх хэрэгтэй байна. Өнөөдөр төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн эдийн засагт сүүлийн 7, 8 жилд оруулсан дүн нь 80, 90 их наяд төгрөг байна шүү дээ. Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үл хөдлөх хөрөнгө нь тийм болсон байна. Энэ чинь төрийн өмчийн аж ахуйн нэгж үл хөдлөх төдий хэмжээгээр худалдан авалт хийж, эдийн засагт мөнгө орж ирж байна гэсэн үг. Энэ өөрөө инфляцыг өрдөж байгаа. Тэгэхээр бид нар төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хяналтдаа оруулах, эсрэгээрээ энэ арилжааны банкнуудад өгч байгаа энэ бага хүүтэй зээлээ нэмэгдүүлэх энэ арга, аргачилгаа дээр ажиллах хэрэгтэй байна.

Та бүгдээс саяын тоог авъя. Ер нь үнэт цаас хэлбэрээр хэдий хэмжээний хүүг арилжааны банкнуудад олгож байна вэ.

Р.Сэддорж: 3 номер. Хариулт.

Б.Лхагвасүрэн: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя. 2025 оны 8 сарын эцсийн статистик тоогоор бол нийт банкнаас олгосон зээлийн нийт хэмжээ 42,2 их наяд төгрөг байна. 42,2. Таны бас хөндөж ярьсан энэ Засгийн газрын хүүгийн дэмжлэгтэй ийм зээл байгаа. Сүүлийн 3 жил олгогдож байгаа. Энэ дотор бол хүнсний хувьсгал ч гэдэг юм уу, Цагаан алт, Атрын 4, хоршоог дэмжих ч гэдэг юм уу ийм зээл байгаа. Нийт зээлийн сүүлийн 2 жилд олгосон хэмжээнд 3,2 их наяд байгаа. 3,2 их наяд. Энэ бол өөрөө ерөнхийдөө нийт зээлийн 5-6 хувь л байгаа. Яах вэ, энэ дээр бол Засгийн газар өөрөө хүүгийнх нь татаасыг нь өгөөд олгодог учраас энэ зээл олгогдоод явж байгаа. Энэ зээл дээр бол Монголбанкнаас 1 ч төгрөг гардаггүй. Таны бас асууж байгаа банкны илүүдэл нөөц буюу Монголбанкны үнэт цаасан дээр байршсан байгаа мөнгөнөөс энэ зээл бол гараад явдаг. Өнөөдрийн байдлаар төв банкны үнэт цаасны үлдэгдэл бол 7,4 их наяд төгрөг байна. 8 сарын эцсийн байдлаар. Тэгээд ерөнхийдөө бодлогын хүүгээр бол хүү төлдөг. Ер нь Монголбанкны өнөөдөр бас санхүүгийн тайлан дээр бол нэлээн том дарамт болж байгаа энэ бодлогын арга хэрэгсэл бол энэ Төв банкны үнэт цаас байгаа. Нийт алдагдлын бараг талаас илүү хувь нь бол энэ үнэт цаасанд төлж байгаа хүүгийн зардлаар бол гардаг байгаа. Ерөнхийдөө энэ үнэт цаас бол хамгийн гол нь яагаад энэ үнэт цаас гараад явж байгаа вэ гэхээр төсөв нэлээн тэлээд явахаар эдийн засаг руу их хэмжээний мөнгө ордог. Мөн гаднаас томоохон хөрөнгө оруулалт орж ирээд, эдийн засаг руу бас их хэмжээгээр мөнгө ордог. Энэ нь өөрөө эдийн засгийн тэнцвэртэй байдлыг алдагдуулдаг учраас энийг нэлээн тийм стрелизац гэж ярьдаг.

Манай мэргэжлийн хэлээр тогтворжуулах маягаар төв банкны үнэт цаас энд ажиллаад л явдаг схем байгаа байгаа юм. Хэрвээ төв банкны үнэт цаас гэж байхгүй байна гэвэл эргээд Засгийн газар бол мэдээж үнэт цаас гаргаж явах ёстой. Дэлхий нийтэд ер нь бол сайн туршлага болсон зүйл нь бол Засгийн газрын үнэт цаас. Энэ үнэт цаасыг харин Монголбанк авах, буцаагаад зарах, нийлүүлэх маягаараа эдийн засгийн нээлттэй ийм үйл ажиллагаа хийгээд, эдийн засгаа тогтворжуулаад явдаг байгаа.

Р.Сэддорж: Энхбаярын Батшугар гишүүн.

Э.Батшугар: Баярлалаа. Энэ оны 5 сарын 16-нд Улсын Их Хурлын Зээлийн мэдээллийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэгээд үндсэн өөрчлөлт нь бол ангилал байхгүй болгоод, үүгээрээ дамжуулж санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх онооны систем рүү оруулах зүйлүүд явсан л даа. Тэгээд 9 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн гэж ойлгож болох юм болсон. Гэхдээ үүнтэй холбоотойгоор бас маш их хэмжээний гомдол гараад байна иргэдээс. Зээлээ төлөөд цөм ч гэсэн хар жагсаалт байхгүй болно гэсэн хүлээлт байсан чинь харин эсрэгээрээ оноо нь маш багаар хэмжигдээд, аль эсвэл зарим санхүүгийн байгууллага нь оноог нь хүлээж авахгүй үйлдлээс болоод санхүүгийн үйлчилгээ авч чадахгүй байна гэсэн гомдол маш их ирээд байна.

Тэгэхээр энэ 2 байгууллага байгаа шүү дээ. Сайнскор, Бүрэнскор гээд яг онооны аргачлал нь олон улсын стандартын дагуу байна уу, үгүй юу. Үүнтэй холбоотойгоор яг хүртээмжээ нэмэгдүүлж чадаж байна уу, үгүй юу. Тэгээд бага багаар зээлээ төлөөд явчихаар нөгөөдөх нь оноо нь өсөөд, хүүгээрээ дамжуулж санхүү хүртээмж нь нэмэгдэнэ. Цаашлаад зээлийн авах хүүгийнх нь зардал нь буурна гэх мэтчилэн маш олон эерэг талуудтай шүү дээ. Та тэрийг сайн мэдэж байгаа. Тэгэхдээ яг тэр схем нь Монголд хэрэгжиж байна уу, үгүй юу гэдэг дээр бас эргэлзээ төрөөд, үүнтэй холбоотойгоор бас Монголбанкнаас тухайн 2 байгууллагад аргачлалыг нь шалгах гэж шалгалт оруулах нь зүйтэй юм гэж харж байгаа юм. Яг олон улсын стандартын дагуу аргачлалаа хийж байна. Оноогоо бодох. Аль эсвэл ямар нэгэн байдлаар бас доголдол үүсээд байна уу. 4,8 гүйлгээний дата бааз байгаад байгаа. Тэгэхээр энэ дата бааз яг зөв схемд нь оруулаад, системд оруулаад, тэгээд оноогоо гаргаж байна уу, үгүй юу гэдэг нь л чухал байна л даа. Тэгэхээр та бас энэ дээр нэлээн анхааралтай ажиллаад, яг тухайн иргэн зээлээ төлчихсөн байхад оноог нь өсгөхгүй байгаад байгаа зүйл байна уу, үгүй юу гэдэг шалгалт оруулмаар байна л гэж хэлье. Тэгж байж бид нар энэ зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. Хүртээмж нэмэгдсэн нь өөрөө бас тодорхой хэмжээний эдийн засгаа тэлэх тийм бололцоо үүснэ л дээ. Үг хэлсэн юм.

Р.Сэддорж: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсгийг үндэслэн боловсруулсан Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 7 дугаар заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Төв банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд үүрэг болгосугай.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу. Алга байна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа уншиж, танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

13.52 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ